

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021.01.04

Даланзадгад сум.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Цагдаагийн газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллаж тайлан биелэлтийг улирал бүр хүргүүлсэн. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд хяналтад авч, биелэлт үр дүнг тооцох албан бичгийн жагсаалтын дагуу орон нутаг дахь Цагдаагийн газраас хэрэгжүүлэх 92 төрлийн албан бичгийн холбогдох заалтуудыг хяналтад авч, эзэнжүүлэн хуваарилав. Цагдаагийн ерөнхий газраас хяналтад авч, биелэлт үр дүнг тооцох баримт бичгүүдийн улирлын болон 2020 оны эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар тайлан биелэлтийг нэгтгэн хүргүүлсэн.

Мөн баримт бичгүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх, зорилгоор шийдвэр, үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж буй холбогдох алба, нэгжтэй тухайн тасгийн дарга нар байнга холбоотой ажиллаж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнан ажиллаж байна.

Тасгийн дарга болон биелэлт үр дүнг хариуцсан алба хаагчдад баримт бичгийн биелэлт үр дүнг тайлагнахад анхаарах асуудлын талаар Захиргааны удирдлагын тасгийн дарга мэдээлэл хийж, бичгээр зөвлөмж өгсөн.

Баримт бичиг, үйл ажиллагааны хэрэгжилтийг цагдаагийн газрын дарга биечлэн хянаж, цахим гарын үсэг зурж, тэмдэг дарж албажуулан холбогдох алба, нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүнд бичиг баримтын хэрэгжилтийн хугацаа хоцроосон, тайлагнахгүй орхигдуулсан зөрчил гараагүй байна.

1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаал, шийдвэрийн талаар:

2020 оны 1 дүгээр улиралд Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 8 удаа хуралдаж 43 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд үүнээс хяналт шалгалт буюу албаны шалгалтын талаар 8, алба хаагч нарын сарын ажлын үр дүнгийн талаар 3, хүний нөөцийн чиглэлээр 18, алба хаагчийн шагналын талаар 1, гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаар 1, хүний нөөц болон бусад чиглэлээр 30 асуудал тус тус байна. Мөн тайлангийн хугацаанд алба хаагч нарын сарын ажлын үр дүнгээр нийт 250 алба хаагчийн цалинг нэмж бууруулсан бөгөөд үүнээс 196 алба хаагчийн цалинг 5-20 хувь нэмж, 54 алба хаагчийн цалинг 5-20 хувь бууруулсан байна.

Цагдаагийн газрын даргын тушаалыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан ЦБҮАЖурам /код 136/ журмын дагуу төлөвлөн, тушаалын төслийг тасаг албадын дарга нарт танилцуулан шаардлагатай гэж үзвэл нэмэлт саналыг тусган, хууль эрх зүйн актад бүрэн нийцүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 1 дүгээр улиралд Цагдаагийн газрын даргын 89 тушаал буюу байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 26, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 63 тушаал боловсруулж гарган биелэлтэд нь хяналт тавьж хэрэгжүүлэн ажилласан байна.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан, шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 1 дүгээр улиралд 8 алба хаагчдад албаны шалгалт явуулахад 14 алба хаагч холбогдон шалгагдсан байна.

Албаны шалгалт явуулсан зөрчлийг хэлбэрээр нь авч үзэхэд Аюулгүй байдлын хэлтэс, ХШҮДАХэлтсийн бусад төрийн байгууллагын хяналт шалгалтаар 3, иргэд аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнаас гомдол гаргасан буюу мэдээлсэн 1, байгууллагын дотоод хяналт шалгалтаар 4 зөрчил бүртгэгдсэн бөгөөд албаны шалгалтын дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2 алба хаагчид сануулах, 5 алба хаагчийн сарын цалинг 3 сар 20 бууруулах, 1 алба хаагчид даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр сануулж шийдвэрлэсэн байна. Зөрчилд холбогдон шалгагдсан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзэхэд тасгийн дарга 1, хэсгийн байцаагч 1, ахлах байцаагч 1, эрүүгийн мөрдөгч 1, жижүүрийн мөрдөгч 1, цагдаа зохицуулагч 1, бусад цагдаа 2 алба хаагч тус тус холбогдон шалгагдсан байна.

Иргэд аж ахуй нэгж байгууллага, алба хаагчдаас удирдах албан тушаалтанд хандаж гаргасан 78 өргөдлийг хүлээн авсан бөгөөд үүнээс ажилд орох, суралцахыг хүссэн 3, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 16, тэтгэвэр, тэтгэмж хүссэн 4, захиргааны чөлөө хүссэн 12, бусад 43 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна.

2020 оны 2 дугаар улиралд Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 10 удаа хуралдаж 51 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд үүнээс хяналт шалгалт буюу албаны шалгалтын талаар 7, алба хаагч нарын сарын ажлын үр дүнгийн талаар 3, хүний нөөцийн чиглэлээр 31, алба хаагчийн шагналын талаар 2, гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийн талаар 1, тэтгэмжийн чиглэлээр 2, бусад чиглэлээр 2 асуудал тус тус байна. Мөн тайлангийн хугацаанд алба хаагч нарын сарын ажлын үр дүнгээр нийт 249 алба хаагчийн цалинг нэмж бууруулсан бөгөөд үүнээс 214 алба хаагчийн цалинг 5-20 хувь нэмж, 35 алба хаагчийн цалинг 5-20 хувь бууруулсан байна.

Цагдаагийн газрын даргын тушаалыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан ЦБҮАЖурам /код 136/ журмын дагуу төлөвлөн, тушаалын төслийг тасаг албадын дарга нарт танилцуулан шаардлагатай гэж үзвэл нэмэлт саналыг тусган, хууль эрх зүйн актад бүрэн нийцүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 2 дугаар улиралд Цагдаагийн газрын даргын 94 тушаал буюу байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 23, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 71 тушаал боловсруулж гарган биелэлтэд нь хяналт тавьж хэрэгжүүлэн ажилласан байна.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан, шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага

тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 2 дугаар улиралд 8 алба хаагчдад албаны шалгалт явуулахад 11 алба хаагч холбогдон шалгагдсан байна.

Албаны шалгалт явуулсан зөрчлийг хэлбэрээр нь авч үзэхэд Аюулгүй байдлын хэлтэс, ХШҮДАХэлтсийн бусад төрийн байгууллагын хяналт шалгалтаар 3, иргэд аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнаас гомдол гаргасан буюу мэдээлсэн 4, байгууллагын дотоод хяналт шалгалтаар 1 зөрчил бүртгэгдсэн бөгөөд албаны шалгалтын дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 1 алба хаагчид сануулах, 3 алба хаагчийн сарын цалинг 2-3 сар хүртэл 20 бууруулах, 1 алба хаагчид даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр сануулах, 2 алба хаагчийн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар албанаас дутагдлаар халж шийдвэрлэсэн байна. Зөрчилд холбогдон шалгагдсан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзэхэд хэсгийн байцаагч 1, эрүүгийн мөрдөгч 1, жижүүрийн мөрдөгч 2, хэсгийн төлөөлөгч 4, зохицуулагч 1, экологийн асуудал хариуцсан байцаагч 2 алба хаагч тус тус холбогдон шалгагдсан байна.

Иргэд аж ахуй нэгж байгууллага, алба хаагчдаас удирдах албан тушаалтанд хандаж гаргасан 126 өргөдлийг хүлээн авсан бөгөөд үүнээс ажилд орох 13, суралцахыг хүссэн 1, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 19, тэтгэвэр, тэтгэмж хүссэн 10, захиргааны чөлөө хүссэн 9, бусад 74 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна.

2020 оны 3 дугаар улиралд Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 24 удаа хуралдаж 127 асуудал хэлэлцсэн бөгөөд үүнээс хяналт шалгалт буюу албаны шалгалтын талаар 26, алба хаагч нарын сарын ажлын үр дүнгийн талаар 9, хүний нөөцийн чиглэлээр 42, цол болон шагналын талаар 19, тэтгэмжийн чиглэлээр 9, цэргийн байнгын тэтгэвэрт гарах чиглэлээр 7, бусад чиглэлээр 15 асуудал шийдвэрлэсэн байна. Мөн тайлангийн хугацаанд алба хаагч нарын сарын ажлын үр дүнгээр нийт 600 алба хаагчийн цалинг нэмж бууруулсан бөгөөд үүнээс 472 алба хаагчийн цалинг 5-20 хувь нэмж, 128 алба хаагчийн цалинг 5-20 хувь бууруулсан байна.

Цагдаагийн газрын даргын тушаалыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан ЦБҮАЖурам /код 136/ журмын дагуу төлөвлөн, тушаалын төслийг тасаг албадын дарга нарт танилцуулан шаардлагатай гэж үзвэл нэмэлт саналыг тусган, хууль эрх зүйн актад бүрэн нийцүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 3 дугаар улиралд Цагдаагийн газрын даргын 251 тушаал буюу байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 70, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 181 тушаал боловсруулж гарган биелэлтэд нь хяналт тавьж хэрэгжүүлэн ажилласан байна.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан, шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 26 алба хаагчдад албаны шалгалт явуулахад 32 алба хаагч холбогдон шалгагдсан байна. Албаны шалгалт явуулсан зөрчлийг хэлбэрээр нь авч үзэхэд Аюулгүй байдлын хэлтэс, ХШҮДАХэлтсийн бусад төрийн байгууллагын хяналт шалгалтаар 4, иргэд аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнаас гомдол гаргасан буюу мэдээлсэн 14, байгууллагын дотоод хяналт шалгалтаар 8 зөрчил бүртгэгдсэн бөгөөд албаны шалгалтын дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 5 алба хаагчид сануулах, 7 алба хаагчийн сарын үндсэн цалинг 2-3 сар хүртэл 20 бууруулах, 4 алба хаагчийг цагдаагийн байгууллагад жилийн

хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах, 1 алба хаагчийг албан тушаал бууруулах, 2 алба хаагчид даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр сануулах, 4 алба хаагчийн цалинг сарын ажлын үр дүнгээр 20 хувь бууруулж шийдвэрлэсэн байна. Зөрчилд холбогдон шалгагдсан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзэхэд офицер 18, ахлагч 3 буюу үүнээс тасгийн дарга 1, хэсгийн байцаагч 2, эрүүгийн мөрдөгч 5, жижүүрийн мөрдөгч 4, хэсгийн төлөөлөгч 6, зохицуулагч 3, экологийн асуудал хариуцсан байцаагч 2, цагдаа 3 алба хаагч тус тус холбогдон шалгагдсан байна.

Иргэд аж ахуй нэгж байгууллага, алба хаагчдаас удирдах албан тушаалтанд хандаж гаргасан 294 өргөдлийг хүлээн авсан бөгөөд үүнээс ажилд орох 19, ажилд дахин орох 11, суралцахыг хүссэн 3, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 46, тэтгэвэр, тэтгэмж хүссэн 16, захиргааны чөлөө хүссэн 47, бусад 152 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна.

2020 оны 4 дүгээр улиралд Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 7 удаа хуралдаж 43 асуудал хэлэлцсэн шийдвэрлэсэн байна. Мөн тайлангийн хугацаанд алба хаагч нарын сарын ажлын үр дүнгээр нийт 185 алба хаагчийн цалинг нэмж бууруулсан бөгөөд үүнээс 153 алба хаагчийн цалинг 5-20 хувь нэмж, 32 алба хаагчийн цалинг 5-20 хувь бууруулсан байна.

Цагдаагийн газрын даргын тушаалыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан ЦБҮАЖУрам /код 136/ журмын дагуу төлөвлөн, тушаалын төслийг тасаг албадын дарга нарт танилцуулан шаардлагатай гэж үзвэл нэмэлт саналыг тусган, хууль эрх зүйн актад бүрэн нийцүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 4 дүгээр улиралд Цагдаагийн газрын даргын 251 тушаал буюу байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 70, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 181 тушаал боловсруулж гарган биелэлтэд нь хяналт тавьж хэрэгжүүлэн ажилласан байна.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан, шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 46 алба хаагчдад холбогдуулан 38 албаны шалгалт явуулсан байна. Албаны шалгалт явуулсан зөрчлийг хэлбэрээр нь авч үзэхэд Аюулгүй байдлын хэлтэс, ХШҮДАХэлтсийн бусад төрийн байгууллагын хяналт шалгалтаар 5, иргэд аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнаас гомдол гаргасан буюу мэдээлсэн 18, байгууллагын дотоод хяналт шалгалтаар 15 зөрчил бүртгэгдсэн бөгөөд албаны шалгалтын дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 5 алба хаагчид сануулах, 12 алба хаагчийн сарын үндсэн цалинг 1-3 сар хүртэл 20 бууруулах, 4 алба хаагчийг цагдаагийн байгууллагад жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах, 1 алба хаагчийг албан тушаал бууруулах, 2 алба хаагчид даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр сануулах, 5 алба хаагчийн цалинг сарын ажлын үр дүнгээр 20 хувь бууруулж шийдвэрлэсэн байна. 1 алба хаагчид холбогдон ирүүлсэн өргөдөл гомдлын хөөн хэлэлцэх хугацаа дууссан байсан тул арга хэмжээ тоцоогүй. 1 алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй байна. Зөрчилд холбогдон шалгагдсан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзэхэд офицер 38, ахлагч 8 холбогдон шалгагдсан байна.

Иргэд аж ахуй нэгж байгууллага, алба хаагчдаас удирдах албан тушаалтанд хандаж гаргасан 348 өргөдлийг хүлээн авсан бөгөөд үүнээс ажилд орох 26, ажилд дахин

орох 11, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 51, тэтгэвэр, тэтгэмж хүссэн 16, захиргааны чөлөө хүссэн 80, бусад 164 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна.

1.3. Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг алба хаагчдын сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлон дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналтад авч хэрэгжилтийг хангах хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалттай уялдуулан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “сургалтын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх” /код 118/ журмын 118.11.2 дахь заалтын дагуу 60-80 цагийн багтаамжтайгаар 3.5-5 кредит байхаар тооцон боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/07 дугаар тушаалын хүрээнд Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар нь 2020 онд эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, алба хаагчдын ажлын байранд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газраас 2020 оны 3 дугаар улиралд албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажлын байр дахь сургалт, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийт 71 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 9694 алба хаагч хамрагдсан байна.

Мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын талаар: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хэбэй мужид 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвар гарснаас хойш дэлхийн улс орнуудад тархац халдвар нь хурдацтай өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан алба хаагчдыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төр засаг, улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд албаны үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр албаны сургалтыг Цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж хуваарийн дагуу нийт алба хаагчдад цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулж ажиллалаа.

Тус Цагдаагийн газраас 2020 оны 1 дүгээр улиралд албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажлын байр дахь эрх зүйн сургалт болон мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын чиглэлээр Төрийн албаны тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, Шинэчлэн батлагдсан сонгуулийн тухай багц хуулийн ойлголт, үзэл баримтлал, Авлигын эсрэг хууль, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмээр Захиргааны удирдлагын тасаг, Цагдаагийн албаны тухай хууль, Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар Эрүүгийн цагдаагийн тасаг, Цагдаагийн албаны тухай хуулийн 4, 5 дугаар бүлэг, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаал “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”, Цагдаагийн эргүүл харуулын дүрмээр Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэг, Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр Шуурхай удирдлагын тасаг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн ойлголт, үзэл баримтлалаар цагдаагийн хошууч Б.Оюунчимэг, Хүний эрхийн тухай ойлголт, үндсэн зарчмаар Мөрдөн байцаах тасаг, Зөрчлийн тухай хуулийн ойлголтоор

Хэрэг бүртгэх тасаг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар Замын цагдаагийн тасаг хуваарийн дагуу тус тус сургалт зохион байгуулан ажилласан.

Тус Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 15-2/74 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл, ажлын чиглэл, “Жолоочийн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхийг шалгах ажиллагааны үед баримтлах эрх зүйн баримт бичиг”-ээр бэлтгэсэн хичээлийн сэдвийг Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Ханбогд, Гурвантэс сум дахь цагдаагийн тасагт хүргүүлсэн бөгөөд Цагдаагийн газрын төвийн алба хаагч нарт сургалт зохион байгуулж, дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал: Цагдаагийн газрын 01 дүгээр сарын 29-ний өглөөний рапорт дээр 15-2/74 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл, ажлын чиглэлийн нийт алба хаагчдад танилцуулж, ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Т.Түмэнжаргал “Жолоочийн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхийг шалгах ажиллагааны үед баримтлах эрх зүйн баримт бичиг”-ийн жагсаалтаар 2 цагийн сургалт зохион явуулж, алба хаагчдаар сургалтын дэвтэрт тэмдэглүүлсэн. Мөн хүргүүлсэн мэдээлэл, ажлын чиглэлийн дагуу Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Ханбогд, Гурвантэс сум дахь цагдаагийн тасгийн алба хаагчдад 02 дугаар сарын 05-ны өдөр сургалт зохион явуулж, алба хаагчдаар сургалтын дэвтэрт тэмдэглүүлсэн.

Цагдаагийн алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр ГБХХГХУС ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Оюунчимэг “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” сэдвээр, МДШШУАлбаны сангийн эрхлэгч цагдаагийн дэд хурандаа Б.Цолмонхүү “ЦБҮАЖ 701,702 сангийн үйл ажиллагаа” сэдвээр 1 удаа тус тус сургалт зохион байгуулж ажилласан. Мөн тус Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгаас санаачлан 2020 оны 01 дүгээр сард цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм болон сахилгын дүрмээр 180 ширхэг буюу 324,000 мянган төгрөгөөр гарын авлага бэлтгэж алба хаагчдад тараан өгч ажилласан. Захиргааны удирдлагын тасгаас 2020 оны 02, 03 дугаар сард цагаан шонхор, цагдаагийн тангараг, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмээр мэдээллийн самбарыг 400,000 мянган төгрөгөөр хийлгэж цагдаагийн газрын хурлын танхим, түүхэн уламжлалын танхим болон иргэдийг хүлээн авах танхимд байршуулж ажилласан.

2020 оны 2 дугаар улиралд Цагдаагийн албаны тухай хуулийн 8 дугаар бүлгээр Шуурхай удирдлагын тасаг, Шинэчлэн батлагдсан сонгуулийн тухай багц хуулийн ойлголт, үзэл баримтлалаар Захиргааны удирдлагын тасаг, Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шалгах тухай хуулиар Мөрдөн байцаах тасаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал сэдвээр Урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Цолмон, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Хэрэг бүртгэх тасаг, Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар, Гамшиг галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр Нийтийн хэв журам хамгаалах тасаг хуваарийн дагуу тус тус сургалт зохион байгуулан ажиллалаа. Мөн Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 3/122 дугаартай ажлын чиглэлийн хүрээнд Цагдаагийн албаны тухай хуулийн дөрөв, тав дугаар бүлэгт заасан хэм хэмжээ, үндэслэлийн хүрээнд алба хаагчдаас тодорхой ажиллагаа явуулах, албадлага хэрэглэх талаар бэлтгэсэн 11 видео сургалтын гарын авлагыг цагдаагийн байгууллагын нэгдсэн систем /sestem.police.gov/-ын гарын авлага хэсгийн сургалтын материал цэсээс татан авч алба хаагчдад албаны сургалт зохион байгуулах талаар төлөвлөгөө хуваарь боловсруулан Цагдаагийн газрын даргын 2020 оны А/43 тоот тушаал гаргаж батлуулан

төв болон сум дундын цагдаагийн хэлтэс, тасагт 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 41/851 дугаартай албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 3/122 дугаартай ажлын чиглэлийн хамт хүргүүлж ажилласан бөгөөд 11 видео сургалтыг цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж хуваарийн дагуу нийт алба хаагчдад цахимаар сургалт зохион байгуулж ажилласан. Ажлын чиглэлтийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтсийн 2020 оны 06 дугаар сарын 10-ны 5д/4103 дугаартай албан бичгээр Цагдаагийн албаны тухай хуулийн дөрөв, тав дугаар бүлэгт заасан хэм хэмжээ, үндэслэлийн хүрээнд алба хаагчдаас тодорхой ажиллагаа явуулах, албадлага хэрэглэх талаар бэлтгэсэн 11 видео сургалтын дагуу тус Цагдаагийн газраас 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 09.00 цагаас 06 дугаар сарын 13-ны өдрийн 18.00 цагийн хооронд нийт 124 алба хаагчдыг цахим шалгалтад бүрэн хамруулсан бөгөөд шалтгаантай буюу чөлөөтэй 1, ээлжийн амралттай 5, хүүхэд асрах чөлөөтэй 6, албан томилолттой 3 алба хаагч дээрх сургалтад хамрагдаагүй болно.

Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтсийн 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 5д/4162 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид албан үүрэг гүйцэтгэхдээ иргэдтэй харилцах арга тактик”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх арга тактик”, “Гамшгийн үеийн дадлага сургууль” сэдэвт видео сургалтуудыг цагдаагийн байгууллагын нэгдсэн систем /sestern.police.gov/-ын гарын авлага хэсгийн сургалтын материал цэсэд байршуулсныг татан авч Цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж сургалтыг цахимаар зохион байгуулж ажилласан.

2020 оны 03 дугаар улиралд Төрийн албаны тухай хуулийн ойлголт сэдвээр Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хурандаа А.Төмөрмөнх, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ойлголт, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн ойлголт үзэл баримтлал сэдвээр Урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Цолмон, Цагдаагийн дотоод албаны дүрэм, Цагдаагийн хүрээний дүрэм, Цагдаагийн эргүүл харуулын дүрэм зэрэг сэдвээр Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ц.Эрдэнэбаатар, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмээр Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Төмөрмөнх нар тус тус сургалт зохион байгуулж ажилласан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль болохтой холбогдуулан алба хаагчийн аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 3/189 дугаартай ажлын чиглэл ирсэн бөгөөд ажлын чиглэлийн хүрээнд сургалтын төлөвлөгөө, хуваарь гаргаж цагдаагийн газрын даргаар батлуулан Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсэг сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг сонгуулийн тухай хууль зөрчих, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /сонгуулийн нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах зөвшөөрөл хүсэх код309/ журмын хүрээнд сонгуулийн тухай хууль зөрчсөн үйлдэл, эс үлдлийг шалгах онцлог, Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа, Сонгуулийн санал авах байр хамгаалах, Сонгуулийн тухай хууль зөрчих, Сонгуулийн тухай хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг шалгах онцлог, Радио холбоогоор мэдээ, мэдээлэл дамжуулах, дууны дүрсний, дуу-дүрсний төхөөрөмжөөр үйл явдлыг баримтжуулах, холбогдох бусад техник хэрэгсэл ашиглах сэдвүүдээр Мөрдөн байцаах

тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батсүх, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаяр, Хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Түмэнбаяр, Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ц.Эрдэнэбаатар, Ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Эрзориг, мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Баярбат, Холбоо мэдээллийн инженер, цагдаагийн дэслэгч Г.Батболд нар алба хаагчдад тус бүр 1 удаа сургалт зохион байгуулж ажилласан.

Шуурхай удирдлагын тасгаас алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангах зорилгоор алба хаагчдад жагсаалын теорем, удирдлагаас хэт богино долгионы радио станцаар өгөгдөх нэгдсэн команд болон харуул хамгаалалтын үед харилцах код зэргээр гарын авлага 150 ширхгийг бэлтгэж алба хаагчдад тараан өгч ажилласан.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын талаар: Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, сахилга, ёс зүй, харьцаа хандлага, биеэ авч явах соёл, хувь хүний төлөвшил, хөгжлийн түвшнийг ахиулах зорилгоор Улаанбаатар Их сургуулийн Сэтгэл судлалын тэнхимийн эрхлэгч Б.Оюун-Эрдэнийг байгууллага дээрээ урьж, алба хаагч нарт “Гэр бүлийн харилцаа” сэдвээр сургалт, ярилцлага зохион байгуулав. Мөн аймгийн Эрүүл мэндийн газар, “ЗООНОЗ” ӨСТ-тэй хамтран “Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх” сэдвээр 1 удаа, тус Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн сэтгэл зүйч, цагдаагийн дэд ахлагч Э.Сувданчимэг “Темперамент” сэдвээр 1 удаа, Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч О.Төмөртоогоо “Хадгаламжийн нэгжид тавигдах шаардлага” сэдвээр 1 удаа, Fohow компанийн мэргэжилтэн Г.Цолмонхүүг урьж “Эрүүл аж төрөх соёл” сэдвээр 1 удаа, Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Ж.Булганчимэг “Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 1 удаа, Насан туршийн боловсролын төвийн багш Э.Амартүвшин “Тамхи” сэдвээр 1 удаа, Алба хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Захиргааны удирдлагын тасгийн Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч О.Төмөртоогоо Насан туршийн боловсролын төвийн багш Г.Анхмаагаас “Англи хэлний” анхан шатны цахим цуврал 5 хичээлийг авч Цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж сургалтыг цахимаар 3 удаа, мөн шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвар гарснаас хойш дэлхийн улс орнуудад тархац халдвар нь хурдацтай өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан алба хаагчдыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн яамны цахим хаягаас “Амны хаалт хэрхэн зөв сонгож хэрэглэх” видео сургалт 1 удаа, Лектор Челагийн “Залуустаа хэлэх үг: Итгэл, үнэмшил, зорилго бэлэглэх цахим лекц”-ыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа А.Төмөрмөнх цахим сайтаас татан авч Цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж алба хаагчдад цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын нийт алба хаагчдад Гэр бүл хүүхдийн үндэсний сургагч багш Б.Төмөрбат “Аз жаргалтай гэр бүлийн нууц” сэдвээр 1 цаг, удирдах албан тушаалтнуудад “Удирдлагын арга зүй” сэдвээр 1 цаг, Мөнхийн гэгээн амьдрал төрийн бус байгууллагын тэргүүн Т.Сайнхүү “Архины хор уршиг” сэдвээр 1 цаг, Сэтгэл зүйч Г.Наранбаатар “Гэр бүлийн харилцаа хандлага” сэдвээр 1 цаг, Гэр бүл судлаач доктор профессор Д.Намжил “Монгол гэр бүлд тулгардаг асуудал” сэдвээр 1 цаг, Америкийн элчин сайдын яамны Монгол Улс дахь Дипломат аюулгүй байдлын албаны мэргэжилтэн Лхагважаргал, Даваажаргал нар “Хуурамч бичиг баримтыг хэрхэн шалгах тухай” сэдвээр 3 цаг, Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч О.Төмөртоогоо “Архив албан хэрэг хөтлөлтийн заавар, онол арга зүй”, “Д амин дэмийн дутагдал буюу рахит өвчний тухай” сэдвээр цахимаар 1 удаа, Урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн,

цагдаагийн хошууч Г.Цолмон “Алба хаагчдаас гэмт хэрэг илрүүлэхэд орчин үеийн техник технологи мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах” сэдвээр 1 цаг, “Өнгө нэмье 2020” аяны хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас Мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын албанаас зохион байгуулж байгаа “Хариуцлагатай алба хаагч” арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгаас аймгийн Юнител ХХК-ний салбарын мэргэжилтэн Нямсүрэнг урьж “Quiz хөтөлбөрт нэгдэж групп үүсгэх тухай” сэдвээр алба хаагчдад мэдээлэл хүргүүлж ажилласан.

Мөн Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж буй “Өнгө нэмье-2020” нөлөөллийн аяны хүрээнд Хэрэг бүртгэх албанаас зохион байгуулж буй “Харилцаа-Хандлага” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Хэвлэл мэдээллийн төв, Хар тамхитай тэмцэх газартай хамтран “Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх нь” видео хичээлийг Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын цахим сургалтын нэгдсэн системд байршуулсныг Гарын авлага хэсгээс татан авч уг ведио сургалтыг цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж мөн сум дундын цагдаагийн хэлтэс, тасгийн дарга нарт дээрх сэдвийн хүрээнд алба хаагч нарт сургалт зохион байгуулах чиглэлээр 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдөр 41/1402 дугаартай албан бичиг хүргүүлж, тус Цагдаагийн газрын нийт алба хаагчдад цахимаар сургалт зохион байгуулж ажилласан.

Тус Цагдаагийн газраас Дотоод хэргийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн “Цагдаагийн эрх зүй” мэргэжлийн бакалаврын эчнээ 5 жилийн хөтөлбөрт 1 алба хаагч хамрагдаж байгаа бөгөөд тус сургуулиас 2020-2021 оны хичээлийн жилийн 1 дүгээр улирлын сургалт 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл цахим хэлбэрээр зохион байгуулах тухай албан бичиг ирсэн бөгөөд алба хаагчийг хуваарийн дагуу цахимаар суралцуулах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газраас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Шинэ коронавирус тархалтын үед сэтгэлзүйн тусламж үзүүлэх, стрессийг удирдах чадварыг хөгжүүлэх” сэдэвт богино хугацааны сургалтад Замын цагдаагийн тасгаас 2, Нийтийн хэв журам хамгаалах тасгаас 8 буюу нийт 10 алба хаагч хамрагдсан бөгөөд сургалтад хамрагдсан алба хаагчдад гэрчилгээ олгогдсон.

Дадлагажуулах сургалтын талаар: Аймгийн Эрүүл мэндийн газар, “ЗООНОЗ” ӨСТ-тэй хамтран “Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын үед хорих цээрийн дэглэм тогтооход өөрийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөж хэрэглэх ойлголт” сэдвээр хамтарсан сургалт зохион байгуулав.

Сонгуулийн үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдуулан алба хаагчийн аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх арга тактик, Жагсаал цуглаан, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа, команд, дохио” сэдвээр цагдаагийн газрын нийт алба хаагч нарт Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Ц.Эрдэнэбаатар 2 цагийн дадлагын сургалт зохион байгуулсан. Мөн Дотоодын цэргийн Тусгай салааны алба хаагчдад “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх арга тактик, Жагсаал цуглаан, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа, команд, дохио” сэдвээр 1 цагийн сургалтыг тус тус зохион байгуулж ажилласан. “Хуульч ажиллагаа” арга хэмжээний хүрээнд Мөрдөн байцаах тасгаас

мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Саранчимэг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Дүрэмт хувцас өмсөж хэрэглэх” журам /код 917/-аар 1 удаа цахимаар сургалт зохион байгуулж ажилласан.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2020 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний хүрээнд 2020 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдах сургалтад тус Цагдаагийн газрын мэдээлэл судалгааны мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Ё.Отгонтуяа, цагдаагийн ахлах дэслэгч З.Алтанзул нарыг хамруулсан.

Мөн цагдаагийн газраас хэсгийн төлөөлөгч нарын цугларалт зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаяр хэсгийн төлөөлөгч нарт “Алба хаагчийн буудлага үйлдэх үеийн дадлага сургуулилт”-ыг 1 удаа зохион байгуулж ажилласан.

Иргэд олон нийтэд чиглэгдсэн сургалтын талаар: Тус Цагдаагийн газраас иргэд олон нийтэд чиглэгдсэн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллага аж ахуй нэгжүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт яриа таниулгыг тогтмол зохион байгуулж ажилласан.

Аймгийн төвийн Гандирс худалдааны төвийн худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд “Ятгах тусам нягтал аяны хүрээнд” 34 иргэнд, Очир худалдааны төвийн 6 иргэнд Аз худалдааны төвийн 8 иргэнд тус тус яриа хийсэн. Мөн хүнс хөдөө аж ахуйн газрын 11 ажилтанд, Эрүүл мэндийн газрын 21 ажилтанд, Онцгой байдлын газрын 37 алба хаагчдад “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулиар сургалт зохион байгуулж ажилласан.

Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн нийт 73 эмэгтэй сурагчдад “Нуугдмал ХАХ” сэдвээр, Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн 48 алба хаагчдад “Архи ба амьдрал” сэдвээр, Сумын засаг даргын тамгын газрын ажилтнуудад “Үгүй гэж хэлье” аяны хүрээнд тус тус сургалт зохион байгуулж ажилласан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн зан төлөвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Хайрлая” нэртэй нөлөөллийн аяныг “Зөв хүн-Зөв гэр бүл-Зөв ирээдүй” уриатайгаар аймгийн Төрийн болон төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэмжлэг оролцоотойгоор зохион байгуулан ажиллаж байна. Уг аяны хүрээнд иргэд олон нийтэд чиглэгдсэн сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээллийг Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын цахим хаяг, орон нутгийн зарын групп болон “Алтан говь” телевизээр сурталчлан ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын 2020 оны б/03 дугаар тогтоолоор Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэдээс авсан элсэлтийн шалгалтад тэнцсэн 6 иргэнийг нөөцийн жагсаалтад бүртгэж, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад урьд ажиллаж байсан 4 иргэнийг сургалтад хамруулахгүйгээр сул орон тоонд томилохоор, 2 иргэнийг “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох цахим сургалтад 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд хамруулахаар Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны Б/349 дүгээр тушаал

болон Цагдаагийн газрын даргын 2020 оны 6/78 дугаар тушаалаар хуваарийн дагуу цахим сургалтыг зохион байгуулж ажилласан.

Тайлангийн хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын 2020 оны 6/03 дугаар тогтоолоор Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэдээс авсан элсэлтийн шалгалтад тэнцсэн 2 иргэнийг буюу Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад урьд ажиллаж байсан 1 иргэнийг сургалтад хамруулахгүйгээр сул орон тоонд томилохоор, 1 иргэнийг “Харуулчин” мэргэжил олгох цахим сургалтад 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 08 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд хамруулахаар Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны Б/559 дүгээр тушаалын дагуу Цагдаагийн газрын даргын 2020 оны 6/140 дүгээр тушаалаар сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж батлуулан хуваарийн дагуу цахим сургалтыг зохион байгуулж ажилласан. Сургалтын хугацаанд суралцагч Шинэхүү овогтой Галтхүү /РД:КЮ89052895/ нь 2020 оны 07 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд хичээл сургалт тасалсан, сургалтын дадлага хийгээгүй зэрэг зөрчил дутагдал гаргасан тул суралцагчийг сургалтаас чөлөөлөх тухай албан бичиг Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтэс болон Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд хүргүүлж ажилласан.

“Цагдаа” мэргэжил олгох сургалтад хамрагдаж “Эрх зүйн үндэс” хичээлийн шалгалтад F буюу 60-аас доош үнэлэгдсэн иргэн Ц.Болдбаатарыг дахин шалгалтад хамруулж ажилласан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох сургалт зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан эргүүл, харуул, цагдаа-зохицуулагч, цагдаа-жолооч, нярав, эмч мэргэжлээр элсэлтийн бүртгэл явагдаж байгаа талаар орон нутгийн телевизүүд болон Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын цахим хаягаар иргэд олон нийтэд зар мэдээллийг хүргэж ажилласан бөгөөд “Цагдаа”, “Харуулчин” мэргэжил олгох цахим сургалтын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу тус Цагдаагийн газраас 2020 оны 03 дугаар улиралд олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гаргасан 10 иргэнийг судалж хууль, эрх зүй, хүний эрхийн мэдлэг олгох, харилцааны соёл, биеийн хүч хэрэглэх, холбооны хэрэгсэл ашиглах, нэг бүрийн, хамгаалах тусгай хэрэгсэл болон хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас өмсөж, хэрэглэх зэрэг сэдвүүдээр Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ц.Эрдэнэбаатар сургалт зохион байгуулж ажилласан.

Мөн тайлангийн хугацаанд сум дундын цагдаагийн хэлтэс, тасгуудаас албаны сургалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээг сар бүр нэгтгэн авч Цагдаагийн газрын албаны сургалтын нэгдсэн тайлан мэдээнд тусгаж Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх албаны, сургалтын хэлтэст цаг тухайд нь хүргүүлэн ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс сургалтад хамрагдах алба хаагчдын нэрс, сургалтын төлөвлөгөө, санал, сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдын мэдээлэлтэй холбоотой албан бичгийн хариуг цаг тухайд нь гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Тайлангийн хугацаанд Гурвантэс сумын Шивээхүрэн хилийн боомтод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын дарга эрхлэгч болон нүүрс тээвэрлэдэг жолооч нарт буюу нийт 222 иргэнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх

тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт яриа таниулгыг 1 удаа зохион байгуулж ажилласан.

Тус Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Цолмон, Говийн наран АА бүлгэмийн тэргүүн Т.Дашцэрэн нар Гурвантэс сумын төвд оршин суух хаягтай архины хамаарал бүхий 14 иргэнд архинаас хэрхэн ангижрах арга замын талаар ганцаарчилсан болон бүлгийн яриа таниулга хийж, тус суманд АА бүлгэмийг шинээр байгуулахаар 1 иргэнийг Дундговь аймагт зохион байгуулагдсан “Архичид аминчлахуй” чуулга уулзалтад хамруулан ажилласан.

Өмнөговь аймгийн Политехник коллежийн 2, 3 дугаар курсийн 250 оюутанд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, зөрчлийн тухай хууль, хөдөлмөр хамгааллын чиглэлээр, ерөнхий боловсролын 3 дугаар бүрэн дунд сургуулийн 6 дугаар ангийн 23 сурагчдад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 40 минутын яриа хийж ажилласан.

Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг аймгийн Дулааны цахилгаан станц ХХК-ны ажилчдад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа сургалт зохион байгуулж ажилласан.

Мөрдөн байцаах албаны 74 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгаас 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10.00-12.00 цагийн хооронд Иргэдийг хүлээж авах танхимд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулав.

Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс тус Цагдаагийн газрын албаны сургалтын үйл ажиллагаанд 98.9 буюу бүрэн хангалттай үнэлгээ өгсөн байна.

Соён гэгээрүүлэх чиглэлээр:

Тус Цагдаагийн газраас соён гэгээрүүлэх ажлын 2 зорилтын хүрээнд 23 заалттай салбар төлөвлөгөө боловсруулан хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн газраас 2020 оны 1 дүгээр улиралд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Соён гэгээрүүлэх ажил зохиох /код 939/ журам”-ын дагуу алба хаагчдын оюун санаа, сэтгэхүйг хөгжүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, албаны онцлогоос үүссэн сөрөг нөлөө, сэтгэл зүйн алжаалыг тайлан зорилгоор тайлах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Алба хаагчдын дунд явуулах мэдээлэл сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын чанар, үр дүнг сайжруулах, арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилгоор оны эхэнд бие бүрэлдэхүүний дунд ярилцлага зохион, санал хүсэлтийг авч төлөвлөгөө хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх ажлын зохион байгуулж байна.

Цагдаагийн газрын хийж гүйцэтгэсэн ажил, тодорхой төрлийн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар явуулж байгаа бодлого үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга ёс зүйн байдал, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Алтан говь” “USTV” “Говийн наран” орон нутгийн телевизүүдтэй хамтран ажиллаж байна.

Цагдаагийн газрын даргын 2020.01.24-ны өдрийн А/10 тоот тушаалаар нөлөөллийн аяныг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Аян эхэлснээс хойш 2

сарын хугацаанд нийт үйл ажиллагааны талаарх 45 мэдээлэл Өмнөговь Цагдаагийн газар фейсбүүк, пэйж хуудас, вэб сайтуудад байршуулан, Өмнөговь аймгийн гаралтай олны танил, нэр хүндтэй хүмүүсийг хамруулан уриалга видео 19-ийг бэлтгэн түгээж, уран сайхны видео шторк 6 ширхгийг чанарын шаардлага хангасан студиэр гэрээний дагуу бэлтгүүлэн олон нийтэд хүргэх ажлыг алба хаагчид, хамтран дэмжиж ажиллаж байгаа байгууллагуудын алба хаагчдын хүчээр зохион байгууллаа. Мөн зохион байгуулж байгаа аяныг иргэдээс дэмжиж нийт 5 нийтлэл бэлтгэн постолсон байна. Уг ажлын хүрээнд “Үгүй” аянтай холбоотой нийт 66 мэдээ, мэдээлэл, уриалга, шторк цахим сүлжээнд байршуулан түгээсэн нь давхардсан тоогоор 292891 хүнд хүрсэн мэдээтэй байна.

Аймгийн төвд 3х6 хэмжээтэй аяныг сурталчилсан анонс 4-ийг, зам дагуух сурталчилгааны самбар 20 ширхгийг байршуулан, 3 төрлийн зурган постер 2500 ширхэг, аяны логог 5000 ширхэг хэвлүүлэн сумдад хуваарилан аймгийн хэмжээнд тарааж ажилласан.

Архи ба амьдрал сэдэвт сургалтыг 0131-р ангийн 48 алба хаагчид болон аймгийн Төв номын сангийн 10 ажилтанд зохион байгуулж, аянд нэгдүүлэх ажлуудыг зохион байгууллаа.

Нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгүүд сум орон нутагтаа аяны талаарх сурталчилгааг хариуцан зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэдийг нэгдүүлэн, 14 хоног тутамд мэдээллээ ирүүлэн нэгтгэж ажиллаж байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр “Мартын 8”-ныг тохиолдуулан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүд зохион байгуулагдаж, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Наранбаатар нийт эмэгтэй алба хаагчдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

"Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан тус газрын эмэгтэйчүүдийн зөвлөл эрэгтэй алба хаагчдаа хүндэтгэл үзүүлэн "Цайтай рапорт" зохион байгуулж, "Азын сугалаа" явуулж, "Хөгжөөнт тоглоом" тоглуулан гарын бэлэг, дурсгалын зүйлийг гардууллаа.

Байгууллага, алба хаагч, гэр бүлийн дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх, хууль, эрх зүйн болон танин мэдэхүйн мэдлэгийн цар хүрээг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “50000 уналт”, “АХА” зэрэг хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээн, “Мөнгөтэй зочин” гэр бүлийн уулзалтыг зохион байгууллаа. Танин мэдэхүйн хөгжөөнт “50000 уналт” тэмцээнд тасаг, салаа бүрээс 2 алба хаагч оролцон өрсөлдөж, мэдлэг, ур чадвар, авьяасаараа бусдыгаа манлайлсан ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Эрзориг, мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Баярбат нар тэргүүн байр эзэлж, мөнгөн шагналаар шагнуулав. Танин мэдэхүйн “АХА” тэмцээнд 48 алба хаагчид оролцож, өөрийн мэдлэг, ур чадвараараа манлайлсан эдийн засгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Билгүүн тэргүүн байр эзэлж, нэг өдрийн цалинтай чөлөөгөөр шагнууллаа.

Мөн Цагдаагийн газраас гавьяаны амралтад гарсан бэлтгэл хошууч Г.Өнөржаргал, Ж.Ганчимэг нарт хүндэтгэл үзүүлэв.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын "Эрүүл чадварлаг хүний нөөц бүрдүүлэх" зорилтыг хэрэгжүүлэх, алба хаагчдын чөлөөт цагийг гэр бүлийн хамт спортоор хичээллэж өнгөрүүлэх, бие бүрэлдэхүүний бие бялдрыг хөгжүүлэх, хамт олны нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор "Мөсний баяр" зохион байгуулав. "Мөсний баяр"-ын үеэр алба хаагчдын дунд мөсөн дээрх олс таталт, мөсний хөл бөмбөг, мөсөн шагай, мөсний сумо, тэмцээнүүдийг зохион байгуулж, шагнаж урамшуулав. Цагдаагийн алба

хаагчдыг сэтгэл гутрал, ажлаас залхах хам шинж стресс бухимдалд орохоос урьдчилан сэргийлэх аливаад чин сэтгэлээсээ хандах эерэг хандлагыг төлөвшүүлэх, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх чиглэлээр “Инээмсэглэл ба урам” аяныг зохион байгуулан ажиллаж байна. Цагдаагийн газрын алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр “Хамтдаа уншъя” 30 минутын ном унших аяныг зохион байгуулан ажиллаж байна.

“Өнгө нэмцгээе-2020” уриан дор зохион байгуулагдаж байгаа “Нэг сэтгэл, нэг соёл” арга хэмжээний хүрээнд Цагдаагийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх, ахмад үеийнхээ тэргүүн туршлага, арга барилаас суралцах, тэднийг бахархан дуурайх үзлийг төлөвшүүлэх, залуучуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг ахиулж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Шүүхийн шинжилгээний албатай хамтарсан өдөрлөгийг зохион байгуулав. Өдөрлөгийн хөтөлбөрийн дагуу төрийн байгууллагад 32 жил, үүнээс төрийн тусгай албанд 31 жил ажиллаж байгаа аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дарга, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаяртай хийх уулзалт, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, ажил, амьдралын баялаг туршлагаас алба хаагч нар хуваалцлаа. Өдөрлөгийн үеэр “Наран говь” хамтлагийн уран бүтээлчид ая дуугаа өргөж, Цагдаагийн байгууллагад сэргийлэгчээс НХЖХТ-ийн дарга хүртэл дэвшин ажиллаж байсан, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаярт хамт олны зүгээс халуун талархал илэрхийлж, дурсгалын зүйлийг гардуулан өгөв. Мөн батлагдсан хөтөлбөр, цагийн хуваарийн дагуу нийт бие бүрэлдэхүүнийг аймгийн Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаатай танилцуулж, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаярын хувийн цуглуулгаас бүрдсэн үзэсгэлэнг сонирхуулж, тус байгууллагын хурлын танхимд зангиагүй уулзалтыг зохион байгуулж, дурсгалын зэрэг татуулав. Уг арга хэмжээний явц, үр дүнг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд сурталчилж, хөрөг нэвтрүүлгийн зураг авалт хийлгэв.

Цагдаагийн газрын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх баярын арга хэмжээг 2020 оны 10-р сарын 02-ны өдөр зохион байгуулж, Цагдаагийн газраас гавьяаны амралтад гарсан бэлтгэл хошууч Б.Оюунчимэг, бэлтгэл ахмад Д.Мөнхтүвшин нарт хүндэтгэл үзүүлж, нийт ахмад ажилтнуудад гарын бэлэг гардуулав.

Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс тус Цагдаагийн газрын соён гэгээрүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд 94.5 буюу бүрэн хангалттай үнэлгээ өгсөн байна.

1.4. Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлэн ажил арга хэмжээ:

Гамшгийн нөхцөл байдалд ажиллах алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай 3791 ширхэг 20,000,000 төгрөгийн үнэлгээтэй хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодис, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг танилцуулж, шаардагдах санхүүжилтийг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлснээр гоц халдварт өвчний үед өмсөж хэрэглэх хамгаалалтын нэг удаагийн хувцас 380, амны хаалт/макс/ 2628, нэг удаагийн бээлий 1574, нүдний шил 220, ариутгалын бодис 398, халуун хэмжигч 5, ус буцалгагч 4, тавиур 3, өлгүүр 20, арчуур 15, дархлаа дэмжигч, нэмэлт

хоол тэжээлийн зүйлс 1310 ширхгийг авч, шаардлагатай зүйлсээр алба хаагч нарт 1 удаагийн хангалт хийлээ. Алба хаагчдыг дархлаажуулах, витаминжүүлэх аяныг 7 хоног бүр зохион байгуулж, жижүүр харуул, хяналтын постод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг өдөрт 3 удаагийн хоол, хүнсний зүйлээр бүрэн хангаж, гамшгийн үед нийт бие бүрэлдэхүүнийг тусгай горимоор ажиллуулахад шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, бусад зүйлсийн нөөцийг бүрдүүлэн ажиллалаа.

Хүйтний улиралд алба хаагчдыг болзошгүй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, дархлааг сайжруулах зорилгоор халуун буцалгаа, аарц, чацаргана, хүчир төрөгчийн коктейлиор даваа, лхагва, баасан гарагт үйлчилж байна.

Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор “Өнө орших” өрхийн эмнэлэгтэй хамтран алба хаагчдыг элэгний В, С вирусийг эрт илрүүлэх, тоолох эмчилгээ, дархлаажуулалт, вакцинд хамруулав

Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг ахиулах зорилгоор Насан туршийн боловсролын төвийн багш Г.Анхмаагаас “Англи хэлний” анхан шатны цахим цуврал 5 хичээлийг авч Цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж сургалтыг цахимаар 5 удаа, мөн шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвар гарснаас хойш дэлхийн улс орнуудад тархац халдвар нь хурдацтай өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан алба хаагчдыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн яамны цахим хаягаас “Амны хаалт хэрхэн зөв сонгож хэрэглэх” видео сургалтыг татан авч Цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж алба хаагчдад цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулж ажиллалаа.

1.5. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээний талаар:

Даланзадгад сумын хөрөнгө оруулалтаар албаны бэлэн байдлыг хангах, цахилгаан тасарсан үед хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 11 сая төгрөгийн өртгөөр генераторыг авах, алба хаагчдын ажиллах боломж нөхцөлийг сайжруулах зорилгоор 20 сая төгрөгт зөөврийн компьютер авахаар Даланзадгад сумын ЗДТГ-аас тендер зарлан Сүүн Хүнгий ХХК шалгаран нийлүүлэлт хийгдсэн.

Байгаль орчны сайдад хүсэлт тавьж, яамны 4.5 сая төгрөгийн өртгөөр нисдэг камер дрон авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Даланзадгад сумыг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хэсгийн төлөөлөгч нарын буудлыг цэвэр, бохир, дулааны шугамд шинэчлэн холбох ажлын хүрээнд Даланзадгад сумын ЗДТГ-аас тендер зарлан Эрчим өргөө ХХК шалгаран 2020 оны 07-р сард гүйцэтгэлийн ажил эхэлж, 2020 оны 11-р сард улсын комисс хүлээн авсан.

Алба хаагчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бий болгох зорилгоор тус цагдаагийн газрын спорт заалны барилгыг тохижуулахаар аймгийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлд 420.0 сая төгрөгийг тусгуулан шийдвэрлүүлсэн бөгөөд 2020 оны 01 дүгээр сард аймгийн засаг даргын тамгын газраас тендер зарлуулж, “Хан Богд Арвижих” ХХК шалгарч бүтээн байгуулалтын ажил хийгдэж, улсын комисс хүлээн авсан. Спорт заалны барилгыг иж бүрэн засварт оруулсан бөгөөд

фитнес, иог, албаны бэлтгэлийн өрөөтэй, 2 талын жигүүрт саун, душ, эрэгтэй, эмэгтэй бие засах газартайгаар тохижуулагдсан. Заалны шал стандарт шаардлагад нийцсэн агч модон шалтай бөгөөд орчин үеийн тоноглолоор тоноглож байна.

1.6. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүн:

Тус Цагдаагийн газраас иргэдийн амар тайван байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Аюулгүй амар тайван Өмнөговь” /2017-2020/, “Амгалан хот Даланзадгад” /2017-2020/ хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж, аймгийн болон Даланзадгад сумын Засаг даргын тамгын газартай хамтран хэрэгжилт, биелэлт үр дүнг тооцон Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцууллаа. Дээрх 2 хөтөлбөр бүрэн хангалттай хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

1.7. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Цагдаагийн газрын хэмжээнд Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг цагдаагийн газрын даргын тушаалаар томилсон.

Салбар зөвлөл нь Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомж, шийдвэрийг цагдаагийн газрын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулан ажилласан.

Тухайлбал тус цагдаагийн газрын 1 дүгээр давхарт буюу “Иргэдийн танхим”-д Авлигын эсрэг хууль, хөтөлбөр болон тус цагдаагийн газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээг сурталчилах булан, самбар, санал хүсэлтийн хайрцаг гаргаж холбогдох мэдээлийг байршуулан иргэд олон нийтэд сурталчилж байна.

Аймгийн хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн буюу аймгийн ЭБАТ-тай хамтран нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 1 удаа 1 цагийн сургалт зохион байгуулсан ба нийт 125 алба хаагч хамрагдсан.

“Мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага” зэрэг ном, зурагт хуудас, боршур зэргийг алба хаагч болон иргэд олон нийтэд түгээж, цагдаагийн газрын 1 дүгээр давхар болон алба хаагчдын өрөөнүүдэд зурагт хуудсыг байршуулсан.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтад заагдсан Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын 2019 оны ХОСХОМ-ийг <https://meduuleg.iaac.mn> цахим системд бүрэн оруулж баталгаажуулсан.

Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, тэдгээртэй холбоотой бусад хууль тогтоомж, шийдвэрийг алба хаагчдад таниулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан Үүнд:

-Тасаг, хэсгийн алба хаагчдын дунд Авлигаас ангид байх амлалтын дэвтэр аялуулж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ХАСХОмыг үнэн зөв, хугацаанд нь мэдүүлэх талаар бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

-Алба хаагчдад “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн танилцуулга, шаардлага хэрэгцээ, ач холбогдлын талаар мэдээлэл хийсэн.

-Цагдаагийн ЭБАТ цагдаагийн дэслэгч О.Төмөртоогоо, хүний нөөцийн хэрэг хөтлөгч, цагдаагийн дэд ахлагч Э.Сувдаа нар Авлигын эсрэг хууль, тогтоомжийг сурталчилж, ХАСХОМ мэдүүлэх зөвлөмж, аргачлалыг алба хаагчдад өгсөн.

-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллага, алба хаагч нартай холбоотой гомдол мэдээлэл, санал хүсэлтүүдийг тухай бүр хүлээн авч, мөн цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, авлига, хээл хахууль, хүнд суртал, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын 126 дугаарын тусгай утсаар 24 цагаар хүлээн авч буй талаар иргэд олон нийтэд мэдээлэл хийж, энэ талаарх зурагт хуудсыг цагдаагийн газрын иргэдийг хүлээн авах танхимд байршуулсан.

Авлига, хээл хахууль авах, өгөх, зуучлах, шан харамж авах болон харьяаллын бус хэрэг маргаанд хөндлөнгөөс нөлөөлөхийг оролцох зэрэг ёс зүйн зөрчил гаргахгүй байх талаар цагдаагийн газрын ЭБАТ алба хаагчдаас бичгээр баталгаа гаргуулан авсан.

Үүний үр дүнд алба хаагчид Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал, ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэлтэй болж, авлига, ашиг сонирхолтой холбоотой ямар нэг хэрэг, зөрчилд алба хаагч холбогдоогүй эерэг үр дүн гарсан.

1.8. Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар:

Тус Цагдаагийн газарт 2020 онд цагдаагийн алба хаагчтай холбоотой 9 гомдол, мэдээллийг иргэд байгууллагаас ирүүлсэн ба нийт 9 алба хаагч холбогдсоноос ЦАХ-ын харилцааны соёл, ёс зүй зөрчсөн 3, ажлын хариуцлага алдсан 4, бусад 2 байна. Тухайн гомдол мэдээлэл бүрийг хүлээн авч бүртгэлд оруулж, холбогдох албан тушаалтан албаны шалгалт явуулж хариуцлага тооцон хуулийн хугацаанд шийдвэрлэн гомдол гаргагчид хариуг 100 хувь бичгээр өгч ажилласан. ЦЕГ-ын 126 дугаарын утсанд 2 алба хаагчдад, иргэд аж ахуй нэгж байгууллагаас 7 алба хаагчдад гомдол мэдээлэл ирж албаны шалгалт явагдаж шийдвэрлэгдсэн. 2020 онд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл, ирээгүй. Гомдол мэдээлэл бүрийг хүлээн авч бүртгэлд оруулж, холбогдох албан тушаалтан албаны шалгалт явуулж, 1 алба хаагчид “Сарын үндсэн цалинг бууруулах”, 3 алба хаагчид “Сануулах”, 1 алба хаагчид “Цагдаагийн албанд эргэж орох эрхгүйгээр халах”, 1 алба хаагчид “Албанаас халах”, сахилгын шийтгэл

оногдуулж, 2 алба хаагчид холбогдох гомдол нотлогдоогүй, 1 алба хаагчид холбогдох гомдол мэдээлэл хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр тус тус хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг 100 хувь хуулийн хугацаанд шалгаж, шийдвэрлэн хариуг өгсөн.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүрийн 25-ны дотор ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

1.9. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Цагдаагийн газрын алба хаагчдын гаргасан сахилга, ёс зүй харилцааны зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг цагдаагийн газрын даргын тушаалаар байгуулагдсан “Сахилга ёс зүйн зөвлөл” судалж, дүн шинжилгээ хийсэн.

Энэ оны байдлаар 4 зөрчилд 4 алба хаагч холбогдож, сахилгын арга хэмжээ авагдсан байна.

Зөрчил гаргасан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзвэл зохицуулагч 1, харуулын цагдаа 1, жижүүрийн мөрдөгч 1, мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа 1 байна. 2020 онд сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргасан 15 алба хаагчийг цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан “Ёс төлөвшил” төлбөртэй сургалтад хамруулсан байна.

Сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын 2 буюу 50 хувь нь офицер, 2 буюу 50 хувь нь ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.

Сахилгын зөрчлийг хэлбэрээр нь авч үзвэл архидан согтуурсан 3 буюу 70 хувийг, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн зөрчил 1 буюу 30 хувийг тус тус эзэлж байна.

Цагдаагийн газрын алба хаагчдаас энэ оны байдлаар гаргасан сахилга, ёс зүйн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг судлахад зөрчил гарахад нөлөөлсөн дараах шалтгаан нөхцлүүд байна гэж үзлээ. Үүнд:

1. Албанд хандах хандлага сул, аливаад хөнгөн хийсвэр байдлаар ханддаг.
2. Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхгүйгээр архи согтууруулах ундааны зүйл хэрэглэдэг.
3. Алба хаагчид өөрсдөө бие дааж мэдлэг ур чадвараа дээшлүүлдэггүй.
4. Хувь хүний төлөвшил, хандлага, мэргэжлийн ур чадвараас шалтгаалан сахилга ёс зүйн зөрчил гаргаж байна
5. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлдэггүй.
6. Нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрддөггүй зэрэг шалтгаан нөхцөл байна.

Цагдаагийн газрын алба хаагчдыг сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүй, ажлын хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн дараах ажил арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- Алба хаагчдаас 2019 онд гаргасан сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, алба хаагчдад зөвлөмж хүргүүлсэн.

- “Өнгө нэмцгээе” аяны хүрээнд Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг ханах албанаас “Нэг сэтгэл нэг соёл” уриан дор зохион байгуулсан арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил арга хэмжээг 2 сарын турш тасралтгүй зохион байгуулсан.

- Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа “Хорт зуршил-Эрүүл бие” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил, арга хэмжээг долоо хоног бүр 2 сарын хугацаанд тасралтгүй зохион байгуулан ажилласан.

- Мөрдөн байцаах албанаас зохион байгуулж байгаа “Хуульч ажиллагаа” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил, арга хэмжээг долоо хоног бүр 2 сарын хугацаанд тасралтгүй зохион байгуулан ажилласан.

- Хэрэг бүртгэх албанаас зохион байгуулж байгаа “Харилцаа-Хандлага” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил, арга хэмжээг долоо хоног бүр 1 сарын хугацаанд тасралтгүй зохион байгуулан ажилласан.

- Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас зохион байгуулж байгаа “Хариуцлагатай алба хаагч” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил, арга хэмжээг долоо хоног бүр 2 сарын хугацаанд тасралтгүй зохион байгуулан ажилласан.

- Эрүүгийн цагдаагийн албанаас зохион байгуулж байгаа “Үлгэрлэл- манлайлал” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу алба хаагчдын сахилга ёс зүйд чиглэсэн ажил, арга хэмжээг долоо хоног бүр 2 сарын хугацаанд тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

- Энэ оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн” зохион байгуулсан.

- Нийт алба хаагчдаас бичгээр баталгаа 4 удаа гаргуулан авсан

- Сахилга ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сар бүр соён гэгээрүүлэх ажил, сургалтыг зохион байгуулж, байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хаягт байршуулсан.

- Цагдаагийн газрын дарга, тасгийн дарга нараас алба хаагчдад сахилга ёс зүйн чиглэлээр ажлын чиглэл, зааварчилгааг бичгээр 3 удаа өгсөн.

- Дээд шатны байгууллагаас ирүүлсэн сахилга ёс зүйтэй холбоотой үүрэг, ажлын чиглэлийг алба хаагчдад тухай бүр танилцуулсан зэрэг ажил арга хэмжээг зохион байгуулсан.

Цагдаагийн алба хаагчдыг алдаа зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлж цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмээр 180 ширхэг өврийн дэвтэр бэлтгэн нийт алба хаагчдад тарааж, цагдаагийн газрын хурлын танхим болон 2 давхарт цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг байршуулсан. Мөн Цагдаагийн алба хаагчдын дунд цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмээр сургалт зохион байгуулахаар хуваарь гарган 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Цагдаагийн газрын даргаар батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Шуурхай удирдлагын тасгаас алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангах зорилгоор алба

хаагчдад жагсаалын теорем, удирдлагаас хэт богино долгионы радио станцаар өгөгдөх нэгдсэн команд болон харуул хамгаалалтын үед харилцах код зэргээр гарын авлага 150 ширхгийг бэлтгэж алба хаагчдад тараан өгч ажилласан. Алба хаагчдаас бичгээр баталгаа 2 удаа гаргуулан авсан.

Тус цагдаагийн газраас энэ оны байдлаар нийт 30 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан ба тухай бүр албаны шалгалт явуулж хариуцлага тооцож дахин зөрчил дутагдал гаргахгүй байх талаар баталгаа авч хэвшсэн. Сахилга ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сар бүр соён гэгээрүүлэх ажил, сургалтыг зохион байгуулж, байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хаягт байршуулсан.

Цагдаагийн газрын дарга, тасгийн дарга нараас алба хаагчдад сахилга ёс зүйн чиглэлээр ажлын чиглэл, зааварчилгааг бичгээр 6 удаа өгсөн. Дээд шатны байгууллагаас ирүүлсэн сахилга ёс зүйтэй холбоотой үүрэг, ажлын чиглэлийг алба хаагчдад тухай бүр танилцуулсан зэрэг ажил арга хэмжээг зохион байгуулсан зэрэг ажил арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд алба хаагчдын сахилга ёс зүйн зөрчил урд оны мөн үеэс 11 нэгжээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

1.10. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус цагдаагийн газар нь 2020 оны байдлаар бараа үйлчилгээний зардалд 2,329.7 тэрбум төгрөг, цалин хөлс нэмэгдэл урамшилд 2,019.1 тэрбум төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 97,8 сая төгрөг, ХХОАТатвар 166,6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 68,3 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 138,7 сая төгрөг, норматив зардалд 34,9 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 25,9 сая төгрөг, дотоод томилолтын зардалд 15,9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 2,4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,2 сая төгрөг, Гэрээт цагдаа, Олон нийтийн цагдаагийн санхүүжилтэд бараа үйлчилгээний зардалд 535,2 сая төгрөг, цалин хөлс нэмэгдэл урамшилд 248.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 51,4 сая төгрөг, ХХОАТатварт 47,8 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 39,4 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 26,1 сая төгрөг, норматив зардалд 42,9 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 62,6 сая төгрөг, дотоод томилолтын зардалд 6,9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 22,9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 44,3 сая төгрөг тус тус зардлуудыг тооцож зарцуулсан байна.

Торгууль, шийтгэлийн хуудас, галт зэвсгийн гэрчилгээний талаар: Энэ оны байдлаар 42 алба хаагч 973 ширхэг торгуулийн хуудас авч, 971 ширхэг торгуулийн хуудасны тооцоо хийн алба хаагч нарын гар дээр 504 ширхэг торгууль шийтгэлийн хуудасны үлдэгдэлтэй байна. Торгууль шийтгэлийн хуудас нярваас 2017 оноос хойш авсан судалгааг гарган торгуулийн хуудсаа цаг хугацаанд нь ЦБҮАЖурам код 812-ийг хэрэгжүүлэх \14 хоногийн дотор төлбөр төлүүлэх, сард 2-оос доошгүй удаа санхүүтэй тооцоо нийлж байх\ гэх мэт шаардлагыг тавьж шийтгэлийн хуудас тасалсанаас хойш хоног, сар, жил дамнан хэтэрсэн алба хаагчдын судалгааг гарган газрын даргад танилцуулан хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарт холбогдох журмыг хэрэгжүүлж зөрчилгүй ажиллах албан тоот хүргэж тооцоо хийн ажилласан байна.

Автомашин шатахууны тайлан тооцоо: Цагдаагийн газрын хэмжээнд аймаг болон сумдын хэлтэс, тасаг хэсгийн төлөөлөгч нар 40 гаруй автомашины дуудлага, мэдээлэл томилолтоор явахад нийт 143,5 сая төгрөгийн шатахууныг олголоо. Өмнө нь жолооч нар шатахуунаа өдөр бүр нярваас шатахуун олгох хуудас, гар талон, гаргуулан авч ШТС-аас

өр үүсгэн авдаг байсныг зогсоож, автомашин бүрд шатахууны картыг газар, хэлтэс, тасаг, сумдын хэсгийн төлөөлөгч нарт нэг бүрчлэн захиалж, автомашины шатахууны нормыг сараар тооцон газрын даргаар батлуулж, автомашины картуудыг орон зайнаас үл хамааран цэнэглэж тухай бүр орлого зарлагыг хянадаг болов. Автомашины замын хуудсыг өөрчилж, замын хуудасны дагалдах тайлангийн хуудсыг гарган давхар хөтлүүлэн тайланг сар бүр авч хэвшсэн.

Үндсэн хөрөнгө, бараа материал, эд хөрөнгийн бүртгэл тооцоо: Алба хаагчид нийт 104,9 сая төгрөгийн бичиг хэрэг, шуудан холбоо, аж ахуйн, хэвлэл мэдээлэл, хичээл сургалт, урсгал засварын материалуудыг хүлээн авч зарцуулсан байна. Алба хаагчдын эд хөрөнгийн картыг 2017 оны Сангийн сайдын шинэчилсэн маягт хуудсаар нэг бүрчилэн нээлгэн хөтлүүлэх, 2019 оны жилийн эцэст актлагдсан эд хөрөнгүүдийг санхүүгийн программд дотоод шилжүүлгээр бүртгэснийг, нярав руу буцаан орлого авч, зарлага болгосныг, алба хаагч нэг бүрчлэн тулгалт хийн бүртгэлийг дахин санхүүгийн программд дотоод шилжүүлгээр бүртгэх ажлыг зохион байгуулав. Нярав дээр байх үндсэн хөрөнгө, бараа материалын агуулахын бүртгэлийн дэвтэр шинээр нээн данс бүрээр агуулахын бүртгэл хөтөлж байна.

Бичиг хэрэг аж ахуйн болон бусад материалын талаар: Алба хаагчдын бичиг хэргийн материалд 22,8 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэн олголоо. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бараа үйлчилгээ авах хяналтыг сайжруулж алба хаагч нар материал авахдаа ахлах нягтлан бодогчоор хянуулан, газрын даргаар батлуулан нярваас авч байх шат дамжлагыг хэвшүүлэв. Алба хаагч нар иргэн, аж ахуй нэгжүүдээс шууд бараа үйлчилгээ захиалан өр үүсгэн авдаг байсныг зогсоож, үнийн судалгаа хийн зөвхөн нярав захиалж авах, урсгал засвар автомашины сэлбэгүүдийг аж ахуйн ажилтан судалгаа хийн иргэн аж ахуй нэгжүүдээс авах шаардлагатай тохиолдолд алба хаагч гарын үсэг зурах эрх бүхий алба хаагчид танилцуулж авах хяналтыг сайжруулав.

Автомашины урсгал засварын талаар: Аймаг, сумдын хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарын автомашинд нийт 39,8 сая төгрөгийн тос тосолгооны материал, сэлбэг хэрэгсэл, засвар хийлгэв. Албан ажилд явж байгаа автомашинд үйлчилгээ хийхэд автомашины картыг хэрхэн хөтөлснийг үндэслэх мөн техникийн комиссын дүгнэлт гарсан тохиолдолд үйлчилгээ хийх зардлыг шилжүүлэх ажлыг зохион байгуулж хэвшсэн.

Цалингийн талаар: 2020 онд нийт 89 алба хаагчийн цалинг 18,1 сая төгрөгөөр хасаж, 188 алба хаагчийн цалинг 67,4 сая төгрөгөөр нэмж, жилийн эцсийн урамшуулалд үндсэн цалинг 50 хүртэл хувиар нэмж 107 алба хаагчийг 44,2 сая төгрөгөөр нэмж, ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй 8 алба хаагчид 10,6 сая төгрөгийн урамшууллыг тус тус тооцож олголоо. Алба хаагчдын цалинг аль болох нээлттэй хэлбэрт шилжүүлж цалин олгох бүрд алба хаагч нарт цахимаар /мэйл хаягаар/ цалингийн мэдээлэл дэлгэрэнгүйгээр хүрдэг болгов. Ээлжийн амралт, эмнэлгийн хуудас листтэй, жирэмсний амралт, хүүхэд асрах чөлөөтэй гэх мэт асуудлуудаас зарим сарын нийгмийн даатгал орхигдсоныг нөхөн тайлан гарган Нийгмийн даатгалын хэлтэст мэдээлэн залруулав. Алба хаагчдын цалингаас хоолны мөнгөний суутгал хийдэг байсныг таслан зогсоосон байна.

Халагдсан алба хаагчдын хувцасны тооцооны талаар: Ажлаас халагдсан он дамжсан 16 алба хаагчийн хувцасны 15 сая гаруй төгрөгийн тооцоо байсныг төлбөр барагдуулах арга хэмжээ зохион байгуулж хаяг тодорхойгүй 6 алба хаагчийг Улсын бүртгэлийн хэлтсээс оршин суугаа лавлагааг гаргуулан аймаг болон Улаанбаатар хот дүүргүүдийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд өгч, бусад алба хаагч нартай төлбөр барагдуулах талаар удаа дараалан холбогдож 11 алба хаагчийн 11 сая гаруй төгрөгийн хувцасны төлбөр

барагдуулж, 1 алба хаагчийг 1,1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулахаар шүүхийн захирамж гаргуулан заасан хугацаанд төлөхгүй байгаа тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албадан гаргуулахаар материалыг бүрдүүлэн хүргүүлсэн.

Актлах эд хөрөнгийн талаар: 2019 оны жилийн эцэст актлуулах санал өгсөн 6 автомашины материалын бүрдэл дутуу буцаасныг оны эхэнд нэг бүрчлэн холбогдох материалыг бүрдүүлж Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулж актлах саналыг аймгийн Өмчийн газарт хүргүүлснээр 7 мотоцикл актлуулж, 5 автомашин дуудлага худалдаанд оруулж данс бүртгэлээс хассан байна.

Автомашины татвар, техникийн үзлэгийн төлбөр тооцооны талаар: 2017 оноос хойш аймгийн татварын хэлтэстэй ямар тээврийн хэрэгслүүд хэдэн төгрөг тушаасан бүртгэл тооцоо байхгүй хасалт хийгээгүй автомашин бүр өртэй байсныг 2017, 2018, 2019, 2020 он тус бүрээр автомашин бүрээр төлбөр төлөх судалгааг гарган тооцоо хийн өрийг барагдуулав.

Цайны газрын үйл ажиллагааны талаар: Тус Цагдаагийн газарт үйл ажиллагаа явуулж байсан цайны газар нь ямар нэгэн түрээсийн төлбөр гэрэл цахилгаан, халаалт дулааны тооцоо хийдэггүй байсныг зогсоож, аймгийн Өмчийн газартай Төрийн өмчийн тухай хууль журмын дагуу гурвалсан түрээсийн гэрээ байгуулав.

Эрүүлжүүлэх баривчлах байрны төлбөр тооцоо: Эрүүлжүүлэх байрны хоногийн төлбөр болон шүүхээр баривчлагдсан иргэдийн хоногийн төлбөр тооцоог хийх маягт хүснэгтийг өөрчлөн тодотгож, тухай бүр санхүүтэй тооцоо нийлж байх талаар эмч нарт заавар зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна.

Байгууллагуудтай тооцоо нийлсэн байдал: 2020 оны 3-р улирлын байдлаар халаалт дулаан, гэрэл цахилгаан, шатахуун, бичиг хэрэг, аж ахуй материал, урсгал засвар, шуудан холбооны үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, НДШ, татвар гэх мэт харилцагч төрийн болон иргэн аж ахуй нэгжүүдтэй тооцоо нийлж, нийт 123,1 сая төгрөгийн тооцоог барагдуулаад байна.

Олон нийтийн цагдаагийн нэмэлт санхүүжилтийн талаар: Сар бүр шаардагдах цалин, ндш, ххоат, бусад зардлуудын тооцоог гарган гүйлгээ хийн шилжүүлэх зардлуудын тооцоог гарган аймгийн Төрийн сангийн хэлтэст хүргүүлэн эрх нээлгэн зөвшөөрөл авч зарлага гарган ажиллаж байна. Мөн нэмэлт санхүүжилтээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлууд, Хууль бусаар алт болон бусад зүйлс олборлох үйл ажиллагаанд ажиллах, Коронавирусийн үед ажиллах, Сонгуулийн хамгаалалтад ажиллах, Баяр наадмын хамгаалалтад ажиллах цаг үеийн байдлаас шалтгаалж бусад үед цагдаагийн байгууллагаас ажиллахад шаардагдах зардлын тооцоог гарган санхүүжилт авч төрийн сангаар эрх нээлгэн тухай бүр зарцуулан ажиллаж байна. Аймгийн оёдлын үйлдвэртэй гэрээ байгуулан шинээр томилогдсон олон нийтийн цагдаагийн алба хаагч нарын хувцасны захиалгыг хийсэн. Мөн коронавирусын халдварт өвчний үед улсын төсвийн урсгал санхүүжилтээр 5,8 сая төгрөг, орон нутгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 36,4 сая төгрөг шийдвэрлүүлэн алба хаагчдын аюулгүй байдлыг ханган нэг удаагийн хувцас хэрэглэл, ариутгал халдваргүйжүүлэх бодисууд авч тараан олгосон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Үгүй” нөлөөллийн аяны орон нутгийн төсвийн 30,0 сая төгрөгийн холбогдох зардлыг иргэн аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллахад шаардагдах хэвлэл мэдээлэл, лого, таних тэмдэг, урьдчилан сэргийлэх тараах материалуудын зардлуудыг цаг тухайд нь шилжүүлэн олголоо.

Анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар: Ямар нэгэн бараа үйлчилгээ авахдаа хүсэлт бичих төсөв зардлын тооцоо ажлын төлөвлөгөө гарган хянуулж газрын даргаар батлуулж байж авах талаар алба хаагч нарт мэдээлэл өгч танилцуулж хэвшүүлэн ажиллаж байна.

Алба хаагчдад шөнийн ээлжийн хоол олгох талаар: Шөнийн ээлжид 24 цагаар ажиллаж байгаа хэлтэс, тасаг, тусгай салааны алба хаагч нарын судалгааг алба хаагчдын ажилласан хоногийн хуваариудыг нэг бүрчлэн нэгтгэн гаргуулан тооцоо хийн хоолны мөнгийг тооцож баримтжуулан олгож байна.

Шилэн дансны талаар: Санхүүгийн тайлангийн холбогдох ажлуудыг цахим хэлбэрээр олон нийтэд тухай бүр 96 удаа, сар бүр 36 удаа, улирал бүр 4 удаа, жилээр 9 удаагийн мэдээг тус тус цаг тухайд нь гарган мэдээлэн ажилласан.

Хаан банкны цалингийн гэрээний талаар: Тус цагдаагийн газрын алба хаагч нар нь Хаан банктай гэрээ хийн цалингаа авч байсныг Хаан банк нь оны эхэнд гэрээ дуусаж дахин гэрээ хийх талаар хүсэлт тавьсныг танилцаж, цалингийн зээлийн хүү 1,2-1,5 хувийн хүүтэй, харилцагч 2 байгууллагын дарга ямар нэгэн тодорхой заалтгүй зөвхөн цалингийн гүйлгээ хийх хэмжээний гэрээ хийгдсэнийг, гэрээнд цалингийн зээлийн хүүгийн хэмжээ, хүүгийн хугацаа, нийт хэдэн сараар зээл авах боломжтой, хэдэн төгрөг хүртэл батлан даагчгүй байх гэх мэт бусад заалтуудыг тодорхой болгох талаар шаардлага тавьж, одоогоор дээрх шаардлагуудыг тусган сарын тогтмол хугацаа хамаарахгүйгээр 1.2 хувийн хүүтэйгээр цалингийн зээл өгөх гэх мэт, дээд шатны байгууллагаас үл харгалзан мөрдөж ажиллах гэрээний саналыг ирүүлээд байна. Цаашид Төрийн банкнаас мөн адил санал авч, алба хаагчдад ашигтай байдлыг судалж шийдвэрлэхээр ажиллаж байна.

Өр авлагын талаар: Ханбогд сум дахь Цагдаагийн тасгийн он дамнасан 2018, 2019 оны халаалт дулааны 15,6 сая төгрөгийн өр, бусад бага хэмжээний өрийг барагдуулав.

Төсөв 2021-2023 оны төсвийн төсөөллийн талаар: Цагдаагийн газрын 2021-2023 оны төсвийн төсөөллийг аль болох бодит нөхцөлд тулгуурлан зардал бүрээр холбогдох хүснэгтүүдээр тооцоо хийн 2020 оны батлагдсан төсвөөс 10-40 хувь хүртэл өсөлттэйгөөр зардлын тооцоог гарган саналаа Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанд хүргүүлсэн.

Гэрээт алба хаагчдын төсвийн төслийн талаар: Монгол банк, Гашуун сухайт хилийн боомтын гэрээт алба хаагч нарын ирэх оны төсвийг зөвхөн цалинг тусгах бус шаардагдах бичиг хэрэг, хоол, шатахуун, хувцас, шуудан холбоо бусад зардлуудыг тусган саналаа гарган тус тус хүргүүлээд байна.

1.11. Хүний нөөцийн чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны Б/288 дугаар тушаалаар тус Цагдаагийн газар нь удирдлага /офицер-3/, Эрүүгийн цагдаагийн тасаг /офицер-9, ахлагч-1, бүгд 10/, Мөрдөн байцаах тасаг /офицер-6/, Захиргааны удирдлагын тасаг /офицер-5, ахлагч-7, энгийн-2, бүгд-14/, Нийтийн хэв журам хамгаалах тасаг /офицер-9, ахлагч-12, бүгд-21/, Замын цагдаагийн тасаг /офицер-3, ахлагч-2, бүгд-5/, Тусгай салаа /офицер-5, ахлагч-9, нийт-14/, Шуурхай удирдлагын тасаг /офицер 7, ахлагч 4, бүгд 11/, Цогтцэцийн сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс /офицер-20, ахлагч-6 бүгд-26/, Ханбогд сум дахь цагдаагийн тасаг /офицер 16, ахлагч 9, бүгд 25/, Гурвантэс сум дахь цагдаагийн тасаг /офицер 7, ахлагч 2, бүгд-9/, Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа /офицер 13, ахлагч 11, бүгд 24 буюу нийт 172 орон тоотойгоор ажиллаж байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/17 дугаар тушаалаар экологийн цагдаагийн алба шинээр байгуулагдсан бөгөөд тус Цагдаагийн газарт экологийн асуудал

хариуцсан ахлах байцаагч 1, экологийн асуудал хариуцсан мөрдөгч 1, экологийн асуудал хариуцсан байцаагч 5 буюу нийт 7 орон тоо мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/16 дугаар тушаалаар тус Цагдаагийн газарт эрүүгийн мөрдөгч /хар тамхитай тэмцэх/ 1 орон тоо, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/56 дугаар тушаалаар тус Цагдаагийн газрын Ханбогд сум дахь цагдаагийн тасагт хэсгийн байцаагч /гэрээт/ 2, эргүүлийн цагдаа /гэрээт/ 2 буюу нийт 4 орон тоо шинээр тус тус батлагдсан байна. 2020 оны 3 дугаар улиралд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/746 дугаар тушаалаар Хэрэг бүртгэх албаны албаны орон тоог өөр нэгж рүү шилжүүлэн чиг үүргийг хариуцуулсантай холбогдуулан тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасгийн даргыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн чиглэлийн ахлах байцаагч, ахлах мөрдөгчийг Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөгчөөр тус тус өөрчлөн шилжүүлсэн байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/313 дугаар тушаалаар тус Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт 4, Гурвантэс сум дахь цагдаагийн тасагт 1 нийт 5 зохицуулагчийн орон тоог, мөн даргын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/316 дугаар тушаалаар тус Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтний орон тоог чиглэлийн ахлах мэргэжилтэн болгож, хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нийт 2 орон тоог, мөн даргын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/319 дүгээр тушаалаар тус Цагдаагийн газарт 3, Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст 1, Ханбогд сум дахь Цагдаагийн тасагт 1 нийт 5 хэсгийн байцаагчийн орон тоог тус тус нэмэгдүүлээд байна.

Цагдаагийн газар нь үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангах, асуудлыг шударгаар шийдвэрлэх зорилгоор цагдаагийн байгууллагад орж ажиллахаар хүсэлтээ гаргасан иргэдийг судлах, зэрэг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдолтой эрх зүйн актуудыг байгууллагын веб хуудсанд байршуулснаар иргэд хүссэн үедээ шаардлагатай мэдээллийг чөлөөтэй авах боломжтой боллоо. Цагдаагийн байгууллагад ажилд орохоор хүсэлт гаргасан 31 иргэнийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/” журам, “Хүний нөөцийн судлах, ажилд томилох /код 901/” журмын дагуу эрүүл мэнд, бие бялдар, мэдлэг боловсрол, мэргэжлийн түвшин, ахуй амьдрал, амьжиргааны түвшин, ял шийтгэлийн байдлыг тогтоох зорилгоор судалгааны ажлыг чанартай явуулахад анхаарч “Цагдаагийн албанд ажилд орох, суралцахыг хүссэн иргэний бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт”, “Цагдаагийн байгууллагад ажилд орохыг хүссэн иргэний тухай мэдээлэл”, “Эрүүл мэндийн үзлэг”, иргэний боловсролын түвшин, Сэтгэл зүйн түвшинг тогтоох сорил, дүгнэлт зэргийг гаргуулах ажлыг удирдан зохион байгуулан ажиллав.

Цагдаагийн газарт сул орон тоо гарсан даруйд Төрийн албаны тухай хуулийн дагуу одоо ажиллаж байгаа алба хаагчдаас ажлын үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулж томилох, цагдаагийн байгууллагад ажиллах хүсэлтээ гарган журмын дагуу судлагдаж, нөөцөд бүртгэгдсэн иргэдийн хувийн хэрэг, материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаа дотоодын цэргийн албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-ын дагуу шалгалтад оруулж тэнцсэн иргэдийг зөвшөөрлийн дагуу томилох зэргээр хүний нөөцийн нөхөн хангалтыг хийж байна. Энэ

хугацаанд дээрх журмын дагуу судлагдсан 31 иргэнийг мэргэшлийн шалгалтад оруулахаар материалыг бүрдүүлэн хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагыг мэргэшсэн тогтвортой боловсон хүчнээр тасралтгүй хангах, алба хаагчдыг сургаж дадлагажуулах, ажиллах амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор тус Цагдаагийн газраас Хууль сахиулахын их сургуулийн эчнээ ангид жил бүр алба хаагчдыг элсүүлэн сургаж байгаа бөгөөд 2020 оны 01 дүгээр улиралд эчнээ ангид 4 алба хаагч, магистрын ангид 1 алба хаагчийг тус тус суралцуулсан байна.

2020 оны 2 дугаар улиралд тус Цагдаагийн газраас Дотоод хэргийн их сургуулийг эчнээгээр 4 алба хаагч суралцаж төгссөн.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Дотоод хэргийн их сургуулийн эчнээ ангид 1, магистрын ангид 2, удирдлагын сургуульд 1, офицер бэлтгэх дамжаанд 4 алба хаагч тус тус суралцсан байна.

Тус Цагдаагийн газарт 2020 оны 1 дүгээр улиралд шинээр томилогдсон 35 алба хаагч байгаа бөгөөд үүнээс цагдаагийн үндсэн алба хаагч 13, олон нийтийн цагдаа 22 байна. Цагдаагийн ерөнхий газрын Төрийн албаны салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор Цагдаагийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний сонгон шалгаруулалтад тэнцсэн 6 иргэнийг буюу Э.Батбаатарыг Хилийн боомтын цагдаагаар, З.Батмөнхийг Гурвантэс сум дахь цагдаагийн тасагт цагдаа жолоочоор, Б.Ууганбаярыг хэсгийн цагдаагаар, М.Баатархүүг мэдээлэл хүлээн авагч цагдаагаар, Г.Анхтөрийг Эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаагаар, М.Сүхбатыг харуулын цагдаагаар, Төрийн тусгай, төрийн бусад байгууллагаас шилжин ирж ажилласан болон офицерын албан тушаалд дэвшин томилогдсон нийт 7 алба хаагч буюу офицер 5, ахлагч 2 байгаа бөгөөд үүнээс төрийн тусгай албанд ажиллаж байсан ахлагч бүрэлдэхүүнээс офицер албан тушаалд дэвшин томилогдсон 2 алба хаагч буюу Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасаг, эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Ц.Билгүүн Ханбогд сум дахь экологийн асуудал хариуцсан байцаагчаар, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Баянзүрх дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч П.Эрхэмбаатар Замын цагдаагийн тасгийн зохицуулагчаар томилогдон ажиллаж байна. Мөн төрийн болон төрийн тусгай албанд ажиллаж байсан буюу бусад байгууллагаас шилжин ирж ажилласан нийт 5 алба хаагч байгаа бөгөөд үүнээс офицер 3, ахлагч 2 алба хаагч буюу Нийслэлийн Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Тэмүүжин Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн зохицуулагчаар, Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Саранчимэг Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчөөр, мөн албаны гарын хээний санч, жолооч, цагдаагийн ахлагч М.Батсайхан Захиргааны удирдлагын тасгийн цагдаа жолоочоор, аймгийн Гэр бүл залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Э.Сувданчимэг Захиргааны удирдлагын тасгийн Сэтгэл зүйчээр, Нийслэлийн Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн цагдаа жолооч, цагдаагийн дэд ахлагч Б.Шаравжамц Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн цагдаа жолоочоор тус тус томилогдсон байна.

2020 оны 2 дугаар улиралд Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын 2020 оны 6/03 дугаар тогтоолоор Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэдээс авсан элсэлтийн шалгалтад тэнцсэн 5 иргэнийг буюу Э.Хосбаярыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн

хамгаалалтын цагдаагаар, Б.Мөнх-эрдэнийг Баяндалай сум дахь хэсгийн цагдаагаар, Д.Эрхэмбаярыг Ханхонгор сум дахь хэсгийн цагдаагаар, Ж.Сүрэнжаргалыг Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн нягтлан бодогчоор тус тус шинээр томилогдсон байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар тус Цагдаагийн газарт шинээр томилогдсон Баянгол дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн цагдаа жолооч, цагдаагийн дэд ахлагч Б.Ганзоригийг тус Цагдаагийн газрын Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эдийн засгийн мөрдөгчөөр, Хар тамхитай тэмцэх газрын эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Ц.Энхманлайг Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүгийн хэсгийн даргаар, Өмнөговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дарга, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаярыг тус Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргаар, Дотоод хэргийн их сургуулийг төгссөн Г.Буяндалайг Манлай сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Дундговь аймаг дахь цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа О.Амарсанааг Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын даргаар, Дундговь аймаг дахь цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн Бичиг хэргийн эрхлэгч бичээч архивч, цагдаагийн дэд ахлагч А.Батзоригийг Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн бичиг хэргийн эрхлэгч бичээч архивчаар, цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Б.Болордуулгыг Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн цагдаа жолоочоор тус тус томилсон байна.

2020 оны 3 дугаар улиралд Цагдаагийн ерөнхий газрын тушаалаар Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын хоёрдугаар хэлтсийн мэдээлэл судалгааны мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Н.Эрдэнэцэцэгийг тус Цагдаагийн газрын Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн жижүүрийн мөрдөгчөөр, Увс аймаг дахь цагдаагийн газрын захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Мишигдоржийг Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын даргаар, Орхон аймаг дахь цагдаагийн газрын шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Т.Сэргэлэнбатыг тус Цагдаагийн газрын Гурвантэс сум дахь цагдаагийн тасгийн экологийн асуудал хариуцсан байцаагчаар, Тээврийн цагдаагийн албаны захиргааны удирдлагын газрын төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ж.Мэндбатыг тус цагдаагийн газрын Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн зохицуулагчаар, Увс аймаг дахь цагдаагийн газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, цагдаагийн ахмад Ж.Буянтогтохыг тус Цагдаагийн газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжилтнээр, Эрүүгийн цагдаагийн албаны эрэн сурвалжлах хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Ж.Мөнхсүлдийг тус цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар тус тус томилсон байна.

2020 оны 4 дүгээр улиралд ЦЕГ-ын даргын тушаалаар Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байрны эмчийн сул орон тоонд дадлагажих ажилтнаар Л.Ариунжаргалыг томилж цагдаагийн дэд ахлагч цол олгосон бөгөөд өөрийн хүсэлтийн дагуу ажлаас чөлөөлж, дэд ахлагч цолыг хураасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/981 дүгээр тушаалаар Дотоод хэргийн Их сургуулийг төгссөн Ж.Мягмарсүрэнг шуурхай удирдлагын тасагт жижүүрийн мөрдөгчөөр, Р.Бямбанямыг Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст эдийн засгийн мөрдөгчөөр, Б.Сайнзаяаг Манлай сум дахь экологийн байцаагчаар, Б.Оргилыг Сэврэй сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Б.Батаасүрэнг Ханхонгор сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Э.Пүрэвдорж, Л.Отгонсүрэн, Х.Анхболд нарыг

Ханбогд сум дахь Цагдаагийн тасагт хэсгийн байцаагч /гэрээт/-аар тус тус томилсон байна.

Тус Цагдаагийн газар нь 2020 оны 1 дүгээр улиралд дотооддоо 23 алба хаагчдын шилжилт хөдөлгөөн хийгдсэн ба офицер 10, ахлагч 13 байгаа бөгөөд үүнээс байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдаас 2019 онд ажлын үр дүнгээрээ хангалттай үнэлэгдсэн буюу ажлын байрны болзол шаардлага болон шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж байгаа 17 алба хаагчийг тасгийн дарга, ахлах албан тушаалд болон офицерын албан тушаалд дэвшүүлэн томилуулахаар нөөцөд бүртгэн авч ажиллаа. Тайлангийн хугацаанд нийт 10 алба хаагч албан тушаал дэвшин томилогдсон бөгөөд үүнээс ахлах албан тушаалд 4 алба хаагч буюу урьдчилан сэргийлэх мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Цолмон, Эрүүгийн цагдаагийн тасгийн экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Батзаяа, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Диваажигмэд, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн нягтлан бодогч, цагдаагийн ахмад Г.Батбилэг Ахлах нягтлан бодогчоор, офицерын албан тушаалд дэвшин томилогдсон 5 алба хаагч буюу Захиргааны удирдлагын тасгийн Бичиг хэргийн эрхлэгч, бичээч архивч, цагдаагийн ахлах ахлагч О.Төмөртоогоо Хүний нөөцийн мэргэжилтнээр, Шуурхай удирдлагын тасгийн мэдээлэл хүлээн авагч цагдаа, цагдаагийн дэд ахлагч О.Батбаяр Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн хилийн боомт хариуцсан хэсгийн төлөөлөгчөөр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлагч Б.Энхболд, эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч Т.Буянзаяа нар экологийн асуудал хариуцсан байцаагчаар, цагдаагийн ахлагч Д.Цогнэмэх аж ахуйн ажилтнаар тус тус шинээр томилогдсон, захиргааны санаачилгаар нийт 15 алба хаагч буюу офицер 6, ахлагч 13 буюу Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Баатархүү Хар тамхитай тэмцэх газрын эрүүгийн цагдаагийн 3 дугаар хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгчөөр, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Ц.Анхбаяр Цагдаагийн ерөнхий газрын Гэрч хохирогчийг хамгаалах хэлтэст, Захиргааны удирдлагын тасгийн Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Т.Баярсайхан Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Ё.Отгонтуяа жижүүрийн мөрдөгчөөр, бүтцийн өөрчлөлтөөр Ханбогд сум дахь хилийн боомтын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Б.Пүрэвсүрэн Эрүүгийн цагдаагийн тасагт эрүүгийн мөрдөгч /хар тамхи/-өөр, Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Т.Төгөлдөр экологийн асуудал хариуцсан мөрдөгчөөр, ахлагч бүрэлдэхүүнээс цагдаагийн ахлах ахлагч А.Наранбаатар, цагдаагийн ахлагч С.Содномцоодол, Г.Галбадрах, Д.Цогнэмэх, цагдаагийн дэд ахлагч Э.Цэцэгбаяр, Б.Энхбаяр, М.Түмэндэлгэр, М.Марал-Эрдэнэ, Ж.Дүүрэнбаяр нарын албан тушаалыг өөрчилж шилжилт хөдөлгөөн хийсэн байна.

2020 оны 2 дугаар улиралд Дотоод хэргийн их сургуулийг суралцаж 2020 онд эчнээгээр төгссөн Баяндалай сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч А.Наранбаатар Ноён сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Ханхонгор сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Н.Нарангэрэл Сэврэй сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн мэдээлэл хүлээн авагч, цагдаагийн дэд ахлагч Б.Батцэцэг тус хэлтсийн жижүүрийн мөрдөгчөөр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч Д.Өлзийбаяр Баян-Овоо сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, дадлагажих ажилтан Г.Батболд Шуурхай удирдлагын тасгийн

холбоо мэдээллийн инженерээр, Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ц.Өлзийбаатар Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн даргаар, Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Өнөрбаяр эрүүгийн ахлах мөрдөгчөөр тус тус дэвшин томилогдсон. Мөн Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Х.Намид Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч /гэрээт/-аар, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ө.Батжаргал Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагчаар, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн жижүүрийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Баяржаргал Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчаар, цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Наранбаатар Дундговь аймаг дахь цагдаагийн газрын даргаар, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн зохицуулагч, цагдаагийн дэслэгч Б.Тэмүүжин Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчаар, Дундговь аймаг дахь цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Розон Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн даргаар, Ханхонгор сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Даваажаргал Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн жижүүрийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Жавхлан тус хэлтсийн эрүүгийн мөрдөгчөөр, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Д.Майдар Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр, Сэврэй сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Баттулга Ханхонгор сум дахь хэсгийн төлөөлөгчөөр, Баян-Овоо сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад У.Ууганбаяр Шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн мөрдөгчөөр, Ноён сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Г.Дөлгөөн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгчөөр, Шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Ё.Отгонтуяа мэдээлэл судалгааны мэргэжилтнээр, Захиргааны удирдлагын тасгийн цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Е.Баянбаатар Дундговь аймаг дахь цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн цагдаа жолоочоор, Захиргааны удирдлагын тасгийн Бичиг хэргийн эрхлэгч бичээч архивч, цагдаагийн дэд ахлагч М.Марал-Эрдэнэ Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаагаар, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Т.Батцэцэг эргүүлийн цагдаагаар, эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Цэвээнжав Замын цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагчаар, хамгаалалтын цагдаа, цагдаагийн ахлагч Г.Галбадрах эргүүлийн цагдаагаар ажил өөрчлөн томилогдсон байна.

2020 оны 3 дугаар улиралд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн нягтлан бодогч, цагдаагийн ахлах дэслэгч З.Алтанзулыг тус хэлтсийн мэдээлэл судалгааны мэргэжилтнээр, тус Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа О.Амарсанааг Экологийн цагдаагийн албаны даргаар, Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа У.Мөнхсансарыг Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын даргаар, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эдийн засгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Б.Ганзоригийг Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газарт мөрдөн байцаах тасгийн мөрдөгчөөр, эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Т.Баярсайханыг Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эдийн засгийн

мөрдөгчөөр, Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн даргын зөвшөөрөл олгогдсоны дагуу тус цагдаагийн газрын даргын тушаалаар Бичиг хэргийн эрхлэгч бичээч архивч, цагдаагийн дэд ахлагч А.Батзоригийг Экологийн цагдаагийн албаны , цагдаа жолооч, цагдаагийн ахлах ахлагч Б.Болордуулгыг Автобаазын цагдаа жолоочоор, Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн харуулын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ц.Чулуун-Эрдэнийг Нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн мэдэлд тус тус шилжүүлэн томилогдсон байна.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн ахмад Г.Дөлгөөнийг эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс эрүүгийн мөрдөгчөөр, цагдаагийн дэд ахлагч Э.Цэцэгбаярыг Нийтийн хэв журам хамгаалах тасагт хэсгийн байцаагчийн сул орон тоонд дадлагажих ажилтнаар, цагдаагийн дэд ахлагч Б.Дөлгөөнийг мэдээлэл судалгааны мэргэжилтнээр тус тус ажил өөрчлөн томилуулсан байна.

2020 оны 1 дүгээр улиралд шинээр албан тушаалд томилогдсон болон албан тушаалд дэвшин томилогдсон нийт 18 алба хаагчдад буюу цагдаагийн дэд ахлагч цол 7 /Э.Сувданчимэг, Э.Батбаатар З.Батмөнх, Б.Ууганбаяр, М.Баатархүү, Г.Анхтөр М.Сүхбатыг/, цагдаагийн ахлах ахлагч цол 1 /цагдаагийн ахлагч Б.Бадарч/, цагдаагийн дэслэгч цол 5 /цагдаагийн ахлах ахлагч О.Төмөртоогоо, цагдаагийн дэд ахлагч О.Батбаяр, цагдаагийн ахлагч Д.Цогнэмэх, цагдаагийн ахлагч Б.Энхболд, цагдаагийн ахлагч Т.Буянзаяа/, цагдаагийн ахлах дэслэгч цол 3 /цагдаагийн дэслэгч Б.Лхагважав, цагдаагийн дэслэгч Г.Гантөр, цагдаагийн дэслэгч Т.Санжаадорж/, цагдаагийн хошууч цол 2 /цагдаагийн ахмад Г.Цолмон, цагдаагийн ахмад Б.Диваажигмэд/ алба хаагчид олгогдсон байна.

2020 оны 2 дугаар улиралд шинээр албан тушаалд томилогдсон болон албан тушаалд дэвшин томилогдсон нийт 13 алба хаагчдад буюу цагдаагийн дэд ахлагч цол 3 /Э.Хосбаяр, Б.Мөнх-Эрдэнэ, Д.Эрхэмбаяр/, цагдаагийн ахлагч цол 2 /цагдаагийн дэд ахлагч Ө.Баярбат, цагдаагийн дэд ахлагч Д.Алтанхүү/, цагдаагийн ахлах ахлагч цол 1 /цагдаагийн ахлагч С.Содномцоодол/, цагдаагийн дэслэгч цол 5 /цагдаагийн ахлах ахлагч А.Наранбаатар, цагдаагийн ахлах ахлагч Н.Нарангэрэл, цагдаагийн ахлагч Д.Өлзийбаяр, цагдаагийн дэд ахлагч Б.Батцэцэг, Г.Батболд/ цагдаагийн ахлах дэслэгч цол 1 /цагдаагийн дэслэгч Д.Майдар/, цагдаагийн хурандаа цол 1 /цагдаагийн дэд хурандаа Ц.Өлзийбаатар/ алба хаагчид олгогдсон байна.

2020 оны 3 дугаар улиралд шинээр томилогдсон болон албан тушаалд дэвшин томилогдсон, цол сэргээсэн болон хугацааны цол олгогдсон нийт 15 алба хаагчдад буюу цагдаагийн дэд ахлагч цол 2 /Ц.Болдбаатар, Б.Батбаатар/, цагдаагийн ахлагч цол 1 /дэд ахлагч С.Чулуунбат/, цагдаагийн сургагч ахлагч цол 1 /цагдаагийн ахлах ахлагч Ч.Ганзориг/, цагдаагийн ахлах дэслэгч цол 3 /цагдаагийн дэслэгч Э.Буяннэмэх, Я.Нэргүй, дэслэгч М.Пунцагдаржаа/, цагдаагийн ахмад цол 6 /цагдаагийн ахлах дэслэгч Д.Туул, Т.Эрдэнэцэцэг, М.Үүрдмандах, Л.Далайжаргал, Б.Пүрэвдорж, Ч.Энхбаатар/ цагдаагийн хурандаа цол 1 /цагдаагийн дэд хурандаа Н.Мишигдорж/, цол сэргээсэн 1 /цагдаагийн ахмад Ц.Эрдэнэбаатар/ алба хаагчид олгогдсон байна.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 4 алба хаагчид хугацааны цол олгосон байна. Цагдаагийн хошууч цол 2 /цагдаагийн ахмад Г.Батбилэг, цагдаагийн ахмад Ц.Ганбаатар/, цагдаагийн ахмад цол 1 / цагдаагийн ахлах дэслэгч М.Саранчимэг/, цагдаагийн ахлах дэслэгч цол 1 /цагдаагийн дэслэгч О.Батбаяр/ алба хаагчид тус тус олгогдсон байна.

Шагнагдсан алба хаагчдын талаар: 2020 оны 2 дугаар улиралд шинэ коронавирус /ковид-19/-т халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр онцгой болон өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэсэн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Ц.Эрдэнэбаатар, эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Алтантөр, Цогт-Овоо сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Ө.Баярбат, Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Л.Наранбадрах, харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Цэрэнчимэд нар Цагдаагийн ерөнхий газрын “Жуух бичиг”-ээр мөн хүн амины онц ноцтой гэмт хэргийг мэргэжлийн ур чадвар гарган илрүүлсэн Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Баярбат Цагдаагийн ерөнхий газрын “цагдаагийн гавьяа” тэмдгээр, хулгайн гэмт хэргийг мэргэжлийн ур чадвар гарган, түргэн шуурхай илрүүлсэн Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн жижүүрийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Жавхлан Цагдаагийн ерөнхий газрын “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан байна.

2020 оны 3 дугаар улиралд Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа тэмдгээр 2 алба хаагч /цагдаагийн ахмад Б.Эрдэнэбаатар, цагдаагийн ахмад Б.Баярбат/, Цагдаагийн ерөнхий газрын “Жуух бичиг”-ээр 8 алба хаагч /цагдаагийн ахлах дэслэгч Т.Санжаадорж, сургагч ахлагч Ч.Ганзориг, цагдаагийн хошууч Ц.Эрдэнэбаатар, цагдаагийн ахлагч Ө.Баярбат, цагдаагийн ахлагч Л.Наранбадрах, цагдаагийн дэд ахлагч Б.Цэрэнчимэд, цагдаагийн дэд ахлагч Б.Алтантөр, цагдаагийн ахлах дэслэгч Г.Жавхлан/, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн албаны төлөө-1” медалиар 3 алба хаагч /цагдаагийн хошууч Х.Намид, цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг, цагдаагийн хошууч Т.Розон/, “Цагдаагийн албаны төлөө-2” медалиар 4 алба хаагч /цагдаагийн ахмад Т.Түмэнжаргал, цагдаагийн ахлах дэслэгч Э.Буяннэмэх, цагдаагийн ахлах ахлагч Ц.Чулуун-Эрдэнэ, цагдаагийн ахмад Б.Баярбат/, “Цагдаагийн албаны төлөө-3” медалиар 3 алба хаагч /цагдаагийн ахлах дэслэгч П.Нанчинбат, цагдаагийн ахлах ахлагч С.Содномцоодол, цагдаагийн ахлах ахлагч С.Бадарч, цагдаагийн ахмад Б.Билгүүн, цагдаагийн дэслэгч А.Наранбаатар, цагдаагийн ахлагч М.Ширнэн/, Цагдаагийн ерөнхий газрын “Дурсгалын мөнгөн бөгж”-өөр 13 алба хаагч /цагдаагийн хурандаа О.Амарсанаа, цагдаагийн дэд хурандаа А.Төмөрмөнх, цагдаагийн дэд хурандаа Д.Нарангэрэл, цагдаагийн дэд хурандаа Б.Батсүх, цагдаагийн дэд хурандаа А.Түмэнбаяр, цагдаагийн хошууч Х.Намид, цагдаагийн хурандаа Ц.Өлзийбаатар, цагдаагийн хошууч С.Бат-Очир, цагдаагийн ахмад Ц.Мөнхдэлгэр, цагдаагийн хошууч Б.Диваажигмэд, цагдаагийн сургагч ахлагч Н.Сэргэлэнбат, цагдаагийн дэд хурандаа Ө.Батжаргал, цагдаагийн ахмад Б.Эрдэнэбаатар/ тус тус шагнагдсан байна.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар цагдаагийн ерөнхий газрын “Хүндэт жуух” бичгээр 2 / цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг, цагдаагийн ахмад У.Ууганбаяр/, мөнгөн урамшуулал буюу 300,000 мянган төгрөгөөр 2 /цагдаагийн ахлах ахлагч Н.Ганбат, цагдаагийн ахлах ахлагч С.Содномцоодол/ шагнагдсан байна.

Тус Цагдаагийн газрын даргын зөвлөл хуралдан 2020 онд бусдыгаа хошуучилсан алба хаагчдыг тодруулан цагдаагийн газрын “Хөдөлмөрийн аварга” аар 2 / цагдаагийн ахлах дэслэгч Г.Пүрэвбаатар, цагдаагийн ахлах ахлагч Н.Ганбат/, “Ажил мэргэжлийн шилдэг алба хаагч”-аар 14, “Тэргүүний удирдах ажилтан”-аар 1 /цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаяр/, “Оны онцлох алба хаагч”-аар 2 /Ахмад Б.Батмагнай, цагдаагийн ахлагч Л.Наранбадрах/, Цагдаагийн газрын “Баярын бичиг” –ээр 14 алба хаагч, “Тэргүүний хамт олон”-оор Мөрдөн байцаах тасаг тус тус шагнагдсан байна. Аймгийн Иргэдийн

төлөөлөгчдийн хурлын “Хүндэт өргөмжлөл”-өөр 7 алба хаагч/ цагдаагийн ахмад Б.Түвшинтөр, цагдаагийн дэслэгч Д.Цогнэмэх, цагдаагийн дэд ахлагч О.Будхүү, цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг, цагдаагийн ахмад Ц.Мөнхдэлгэр, дэд ахлагч Э.Бямбадорж/, мэргэжлийн хяналтын газрын “Өргөмжлөл”-өөр / цагдаагийн ахлагч Ө.Баярбат/ Өмнөговь аймгийн засаг даргын “Жуух бичиг”-ээр 9 алба хаагч / цагдаагийн дэд хурандаа Д.Нарангэрэл, цагдаагийн ахлагч Д.Алтанхүү, цагдаагийн дэд ахлагч М.Марал-Эрдэнэ, цагдаагийн ахмад Т.Түмэнжаргал, дэд ахлагч М.Төрмандах, цагдаагийн ахлах дэслэгч Д.Майдар, цагдаагийн хошууч Б.Эрзориг, цагдаагийн ахлах дэслэгч М.Сугирхүү/ нар тус тус шагнагдлаа.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “Ажил мэргэжлийн шилдэг алба хаагч”-аар тус Цагдаагийн газрын мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч О.Батдорж, Санхүү аж ахуйн албаны “Оны шилдэг жолооч”-оор цагдаа, жолооч, цагдаагийн ахлагч Ж.Мөнхмандах нар тус тус шалгаран шагнагдлаа.

Тэтгэмж олгогдсон алба хаагч нарын талаар: 2020 оны 2 дугаар улиралд тус Цагдаагийн газрын алба хаагчдаас хөдөө суманд тасралтгүй 5 жил ажилласан 5 алба хаагч /Гурвантэс сум дахь цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Төрбат, зохицуулагч, цагдаагийн хошууч С.Бат-Очир, Баян-Овоо сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад У.Ууганбаяр, Баяндалай сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Б.Ганболд, Ханбогд сум дахь хамгаалалтын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Ц.Чулуун-Эрдэнэ нарт, 2020 оны 3 дугаар улиралд Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Лхагважав, Хүрмэн сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч З.Батсайхан, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Жавхлан, цагдаагийн ахлах дэслэгч П.Нанчинбат/ нарт, 2020 оны 4 дүгээр 1 алба хаагч / цагдаагийн дэд ахлагч С.Буяндэлгэр/-д 30 сарын тэтгэмж олгогдсон байна.

Албанаас дутагдлаар халагдсан болон чөлөөлөгдсөн алба хаагчдын хөдөлгөөний талаар: Тус Цагдаагийн газарт 2020 оны 1 дүгээр улиралд албанаас дутагдлаар халагдсан алба хаагч байхгүй, өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдсөн 1, цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 1, хүүхэд асрах чөлөө олгогдсон 1 алба хаагч байгаа бөгөөд үүнээс Захиргааны удирдлагын тасгийн Ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Ганчимэг цэргийн байнгын тэтгэвэрт, аж ахуйн ажилтан, цагдаагийн дэслэгч Н.Баатархүү өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдсөн, Шуурхай удирдлагын тасгийн Зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн дэд ахлагч Б.Дөлгөөн хүүхэд асрах чөлөө авсан байна.

2020 оны 2 дугаар улиралд албанаас дутагдлаар халагдсан 2 /Гурвантэс сум дахь цагдаагийн тасгийн экологийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Энхболд, Манлай сум дахь экологийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Одонбаяр/, өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдсөн 2 /Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Д.Буянбазар, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүгийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Төрмөнх/, цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 5 Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа М.Наранбаяр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эрүүлжүүлэх саатуулах байрны эмч, цагдаагийн ахмад Д.Мөнхтүвшин, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн,

цагдаагийн хошууч Б.Оюунчимэг, Шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн мөрдөгч, цагдаагийн ахмад Ж.Энх-Амгалан, Замын цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагч, цагдаагийн сургагч ахлагч Н.Сэргэлэнбат/, хүүхэд асрах чөлөө авсан 2 /Шуурхай удирдлагын тасгийн мэдээлэл судалгааны мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Э.Гэрэлчимэг, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн мэдээлэл судалгааны байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Т.Эрдэнэцэцэг/ алба хаагч байна.

2020 оны 3 дугаар улиралд албанаас дутагдлаар халагдсан 2 /Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн жижүүрийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Д.Батпүрэв, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Сүхбат/, хүүхэд асрах чөлөө авсан 1 /Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Г.Гантуул/ алба хаагч байна.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар албанаас дутагдлаар халагдсан 1 /цагдаагийн ахлах дэслэгч Т.Баярсайхан/ алба хаагч байна.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

2.1. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Эрүүгийн цагдаагийн тасаг нь 2020 оны эхний 11 дүгээр сард иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргийн шинжтэй 663 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч, 279 өргөдөл, гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 306 өргөдөл, гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 32 өргөдөл, гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 38 өргөдөл гомдлыг зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн одоо 12 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байгаа бол 576 хэрэгт хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулснаас 165 хэргийг Мөрдөн байцаах тасагт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах саналтайгаар шилжүүлж, 194 хэргийг хааж, 21 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж одоо 196 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна.

Эрүүгийн цагдаагийн тасаг нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, ард иргэдийг чирэгдүүлэхгүй байхад онцгой анхаарч, хэрэг бүртгэлтийн ажиллагааг түргэн шуурхай, чанартай явуулах, өдөр тутмын хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн Шүүх шинжилгээний алба, Прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулсан, мөрдөн байцаах тасаг, прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг сар бүрийн эхний долоо хоногт багтаан зохион байгуулж, зөвлөгөөнөөр өнгөрсөн сард шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн талаар болон хүндрэл, бэрхшээл, алдаа, дутагдал, ололт амжилтын талаар зөвлөлдөж, алба хаагчдын ажлын үр дүнг дүгнэж, тухайн сард шийдвэрлэх хэргийн графикийг гарган ажиллаж хэвшээд байна.

2020 онд тус цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасаг нь нийт 3.386.328.800 төгрөгийн хохиролтой, 302 хүнд холбогдох 230 материалаар 230 хэрэг үйлдлийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай Мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн байна.

Шилжүүлсэн материалын 161 хэргийг гүйцэтгэх ажилтны мэдээллээр, 42 туслах хүчний мэдээллээр, 26 баримтжуулалтаар илрүүлсэн байна. Тухайлбал:

1. Иргэн Н нь нөхөр Б, төрсөн дүү Д, Х, Г, Б нарын хамт бүлэг зохион байгуулалтад орж 2017-2020 онуудын хооронд тус аймгийн Ханхонгор, Булган, Цогт-Овоо, Баяндалай, Мандал-Овоо, Цогтцэций, Ханбогд, Даланзадгад, Өвөрхангай аймгийн Богд сумдын нутаг дэвсгэрээс нийт 25 удаагийн үйлдлээр бусдын орон байранд хууль бусаар нэвтэрч 156.000.000 /нэг зуун тавин зургаан сая/ төгрөгийн хохиролтой эд зүйл, мотоцикл болон 168 тооны бог, 4 тооны бод мал хулгайлсан.

2. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 5 дугаар баг тоотод оршин суугч Б нь 2020 оны 06 дугаар сарын 15-ны шөнө 23 цаг 30 минутын үед гэртээ харих гэж яваад машинтай үл таних хүнд зодуулж, хүчиндүүлэн эд зүйлээ дээрэмдүүлсэн

3. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын тоот хашаанд 2020 оны 05 дугаар сарын 19-ны өдөр нас барсан байдалтай эрэгтэй хүний цогцос олсон хэрэгт Н гэгч нь талийгаач Б-г өөрийн харрер маркийн тээврийн хэрэгслээр дайрч амь насыг хохироон хэргээ нуух зорилгоор хэргийн газраас талийгаачийг тээвэрлэн өөр газарт аваачиж хаясан

4. 2020 оны 03 дугаар сарын 22-ны шөнө Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 4 дүгээр баг тоотод оршин суух У-ын гэрт Ч нь гаднын нөлөөтэй нас барсан эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг Ө гэгч нь хувийн таарамжгүй харьцаанаас болж үйлдсэн зэрэг ноцтой гэмт хэргүүдийг илрүүлэн ажилласан байна.

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газраас эрэн сурвалжлах “Asap” санд 2020 оны 11 дугаар сарын байдлаар нийт эрэн сурвалжлах зарласан 189, эрэн сурвалжлалт зогсоосон 188 төлөв байна. Үүнээс иргэний хариуцагчийг эрэн сурвалжлах чиглэлээр шүүхээс даалгасан бусад хүн төлөвт 44, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд төлөвт 113, оршин суугаа газраасаа сураггүй алга болсон хүн төлөвт 4, тээврийн хэрэгсэл төлөвт 3, эд зүйл 17, аман зургаар 1, оргодлоор 7 нийт 189 эрэн сурвалжлалт зарласан мэдээллийг төвлөрсөн тоо бүртгэлд оруулан эрэн сурвалжилж ажилласан байна.

Одоогийн байдлаар цагдаагийн газраас нийтдээ эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” санд оршин суугаа газраасаа сураггүй алга болсон хүн 2, Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 12, цогцос 1, Галт зэвсэг 4, Тээврийн хэрэгсэл 2, Түүх соёлын дурсгалт зүйл 2, аман зургаар 1, эд зүйл 36 үлдэгдэлтэй байгаа ба эрэн сурвалжлах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “**Сар шинэ-2020**” нэгдсэн арга хэмжээний хүрээнд мөрдөн байцаалтын 12, хэрэг бүртгэлтийн 11, нийт 23 хэргийг хаах саналтай, яллах дүгнэлт үйлдэж яллагдагчаар татан шүүхэд шилжүүлсэн 32, ажиллагааны явцад илрүүлсэн 13, урьд нь цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй 3 хэргийг тус тус илрүүлэн нийт 66 хэрэг бүртгэлтийн хэргийг шийдвэрлэж, 11 этгээдийн хаяг, байршлыг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан. Насанд хүрээгүй үедээ жирэмсэн болж хүүхэд гаргасан, үр хөндүүлсэн үйлдэлд өртөж хохирсон охид эмэгтэйчүүдийг илрүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдсан “**Нуугдмал-2**”, “**Нуугдмал-3**” нэгдсэн арга хэмжээг хариуцсан орон нутагтаа зохион байгуулж 16 настай болон түүнээс доош настайдаа үр хөндүүлсэн, хүүхэд төрүүлсэн 49 эмэгтэй дэлгэрэнгүй судалгааг гарган шалгах алба хаагчийг томилон цагдаагийн байгууллагын гэмт хэргийн санд энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй 26 гомдол мэдээллийг оруулан 16 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 10 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагааг явуулж эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай Мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн.

Цагдаагийн газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/58 дугаар тушаалаар “**Шийдвэрлэлт-Оргодол**” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын

хэсэг, салбар төлөвлөгөө, удирдамжийг боловсруулж сумдын хэлтэс, тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж биелэлт үр дүнг тооцон ажиллаж уг арга хэмжээний хүрээн эрэн сурвалжлах мэдээллийн Асап санд гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан 17, оргодол төлөвөөр эрэн сурвалжлагдаж байсан 1 этгээдийг Улаанбаатар хот болон бусад аймаг орон нутгаас олж баривчлан хэрэг бүртгэлтийн хэргүүдийг шийдвэрлэж, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан хулгайн 12 хэргийг илрүүлэн ажилласан байна.

“Мал мах” Цагдаагийн газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/76 дугаар тушаалаар “Мал мах” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан, удирдамж, төлөвлөгөөг боловсруулан сум дундын цагдаагийн хэлтэс, сумдын цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж, нэгдсэн арга хэмжээний хүрээнд Даланзадгад, Цогт-Овоо, Цогтцэций суманд ажиллах байнгын 4 пост, Ханбогд сумын Цагаанхад, Гурвантэс сумын шивээ хүрэн хилийн боомтод түр хугацаагаар ажиллах хяналтын 2 постод ажиллах алба хаагчдын хоол, шатахуунд шаардагдах 8.400.000 /найман сая дөрвөн зуун мянга/ төгрөг, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, санамж, шторк бэлтгэхэд шаардагдах 4.125.000 /дөрвөн сая нэг зун хорин таван мянган/ төгрөг, Тус аймгийн Даланзадгад, Цогт-Овоо сумын хяналтын постуудад автомашины дугаар илрүүлэх, хурдын хэмжээг тодорхойлох, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, татвар төлсөн эсэхийг илрүүлэх хяналтын 4 камерыг 100.000.000 /нэг зуун сая/ төгрөгийн өртөгтэйгөөр суурилуулахаар тус тус төсвийг боловсруулан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргад танилцуулж бүрэн шийдвэрлүүлсэн. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар газартай хамтран **“Ченж”**, Шүүх шинжилгээний албатай хамтран **“Сан-Тулгалт”** хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, мал эмнэлгийн гэрчилгээгүй мал, мах тээвэрлэсэн 12 зөрчлийг илрүүлэн зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйлд зааснаар 8 хүнд 1,200,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, алга болсон 270 малыг эрэн сурвалжлан олж тогтоон малын эздэд нь хүлээлгэн өгч, мал хулгайлах 1 гэмт хэргийг илрүүлж, ажиллагаанд байсан 5 хэрэг бүртгэлтийн хэргээс 1 хэргийн хааж шийдвэрлэн, эрэн сурвалжлах мэдээллийн ASAP санд гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан 18, эд зүйл 13, тээврийн хэрэгсэл 4, шүүхээс даалгасан 8 хүнийг, Дорноговь аймаг дахь цагдаагийн газраас гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд төлөвөөр эрэн сурвалжлагдаж байсан 2 хүнийг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны даргын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/97 дугаар тушаалын дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.4 дүгээр зүйл, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Эрэн сурвалжлах” журам /код 229/-ын хэрэгжилтийг хангах, эрэн сурвалжлагдаж буй сэжигтэн, яллагдагч, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг олж тогтоох ажлыг эрчимжүүлэх, эрэн сурвалжлах “ASAP” санд тулгалт хийж, зөрчлийг арилгуулах, алба хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор зохион байгуулсан **“Оргодол-Тулгалт-2020”** арга хэмжээний хүрээнд эрэн сурвалжлах мэдээллийн ASAP санд гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан 8 этгээд, эд зүйл 11, тээврийн хэрэгсэл 3, шүүхээс даалгасан хүн 6, Оршин суугаа газраасаа сураггүй алга болсон хүн 2-ыг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан. **“Байгалиа хамгаалъя”** нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн тасгаас Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүрс бүхий шторк, постер зэргийг “Өмнөговь цагдаагийн

газар” “Өмнөговь зарын нэгдсэн групп” “Сумдын цагдаагийн хэсгийн групп” зэрэг олон дагагчтай Фейсбүүк хаяг болон алба хаагчдын хувийн хаягуудаар дамжуулан анхааруулга уриалга бүхий мэдээ мэдээлэл, Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн шторкуудыг олон удаагийн давтамжтайгаар шэйрлэж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан бөгөөд фейсбүүк хаягуудад байршуулж аялгуут шторкуудыг Өмнөговь аймгийн Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг “Метро плас FM-89.1”-ээр цацаж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулан арга хэмжээний явцын тайлан мэдээг тухай бүрд нь Экологийн цагдаагийн албанд хүргүүлж үүрэг чиглэл авч ажилласан. “**Анчин**” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус аймгийн 14 сумаас анчдын судалгааг авч, хууль бусаар ан хийж болзошгүй урьд нь ял шийтгүүлж байсан сэжигтэй этгээд, сум худалдан борлуулдаг иргэд болон бүртгэл судалгаанд авагдаагүй галт зэвсэг эзэмшдэг иргэдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж экологийн цагдаагийн албанд хүргүүлсэн. Мөн тус аймгийн иргэд ашигладаг галт зэвсэг сонирхогч иргэд, анчдын фейсбүүк группийн судалгааг гарган түүнд тогтмол хяналт тавьж ажилласан. “**Бодис-2020**” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын газар, Онцгой байдлын газруудтай хамтран ажиллах төлөвлөгөө удирдамжийг боловсруулж тус аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумын нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл, химийн бодис ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 17 аж ахуй нэгжийг шалгаж гэмт хэргийн шинжтэй 2 үйлдэл, зөрчлийн шинжтэй 15 үйлдлийг илрүүлж холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулан арга хэмжээ тооцож ажилласан.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “**Нөхөн сэргээлт-2020**” арга хэмжээний хүрээнд аж ахуй нэгжийн 735 сая, улсын 11 сая төгрөгөөр эзэнтэй 238.28 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 58.95 га талбайд биологийн нөхөн сэргээлт, эзэнгүй орхигдсон 11.5 га талбайд техникийн нийт 308.73 га талбайд биологи болон техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн эвдэгдсэн нийт 53 талбайд хяналт шагалт хийн, үйл ажиллагаа явуулж байгаа 13 аж ахуй нэгжид албан мэдэгдэл хүргүүлж хариуг авч ажилласан.

“**Мөнгө угаалт Шийдвэрлэлт**” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан 3 гэмт хэрэг илрүүлж шалгаж суурь гэмт хэрэгт нь давхар зүйлчилж мөрдөн байцаах тасагт шилжүүлж, хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 11 аж ахуйн нэгжийн судалгааг шинэчилж гаргасан. гадаад улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж байгаа 1 аж ахуйн нэгж, хувиараа валют арилжаа эрхлэгч 1 иргэний судалгааг шинэчилж гаргаж мэдээллийг танилцуулгын хамт Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт хүргүүлсэн. “**Хуурам мөнгө**” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэх, гүйлгээнд оруулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас, гарын авлага, тараах материалыг Монгол банкны Өмнөговь аймаг дахь Монгол банкны хэлтэстэй хамтран бэлтгэж, 5 төрийн болон төрийн бус байгууллага, 76 иргэнд тарааж ажилласан. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Хаан, Төрийн, Голомт, Хас, Капитрон, Чингис хаан, Худалдаа хөгжлийн банк зэрэг 7 арилжааны банкны 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл гүйлгээнд гаргасан мөнгөн дэвсгэртийн тоо төрөл, тэдгээрийг хүлээж авсан иргэдийн талаар мэдээллийг гаргуулж авч, хяналт тавьж ажилласан байна.

2.2. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

Мөрдөн байцаах тасаг нь иргэн, аж ахуй нэгж байгууллагаас 2020 онд 305 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан нь 2018 оноос 50 нэгжээр буюу 16,3 хувь, 2019 оноос 56 нэгжээр буюу 22.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн тус тасаг нь 2020 онд хэрэг бүртгэлтийн 319 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан нь 2018 оноос 18 нэгжээр буюу 5,6 хувиар өссөн, 2019 оноос 20 нэгжээр буюу 5,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Түүнчлэн 2020 онд мөрдөн байцаалтын 211 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2018 оноос 4 нэгжээр буюу 1,8 хувь, 2019 оноос 23 нэгжээр буюу 10,9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөрдөн байцаах тасаг нь урьд оны үлдэгдэл 3 гомдол мэдээлэл дээр 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс харьяаллын гэмт хэргийн шинжтэй 302 өргөдөл, гомдол, мэдээлэл нэмж хүлээн авч нийт 305 гомдол мэдээлэл шалгаснаас, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 90, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 159, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 36, харьяаллаар 5 гомдол мэдээлэл шилжүүлсэн ба одоо үлдэгдэл 15 гомдол мэдээлэлтэй, нийт гомдол мэдээллийн 95 хувийг шийдвэрлэж, гомдол гаргагчид хариуг албан бичгээр 100 хувь мэдэгдэж ажилласан. 2019 оноос 56 нэгжээр буюу 22.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тус тасаг нь урьд оны хэрэг бүртгэлтийн 21 хэргийн үлдэгдэл дээр 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар шинээр нээсэн болон бусад газраас шилжин ирсэн 298 хэрэг нэмж, нийт 319 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 120 хэргийг хаах саналтай Прокурорын газарт хүргүүлж, 143 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 21 хэргийг харьяаллаар, 2 хэргийг нэгтгэж шийдвэрлэн ажилласан ба одоо 33 хэргийн үлдэгдэлтэй буюу нийт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан хэргийн 90 хувийг шийдвэрлэсэн байна.

Урьд оны мөрдөн байцаалтын 6 хэргийн үлдэгдэл дээр 2020 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар харьяаллаар шилжүүлэн ирүүлсэн болон шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 205 хэрэг нэмэгдэж, нийт 211 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, 166 хэргийг Шүүхэд шилжүүлэх саналтай Прокурорын газарт шилжүүлж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 37 хэргийг нэгтгэж, 4 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, одоо 4 хэргийн үлдэгдэлтэй буюу нийт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргийн 98,1 хувийг шийдвэрлэн ажилласан.

Мөрдөн байцаах албаны 2020 оны хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн 9 дэх хэсэгт заасны дагуу мөрдөгч нарын шалгаж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг бүрийг гомдол мэдээллийн шатанд нь уншиж, амаар зааварчилгаа өгч, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нь хэргүүдтэй уншиж танилцан, 2020 онд шалгасан 531 хэргээс 263 хэрэгт буюу нийт шалгасан хэргийн 49.6 хувьд бичгээр зааварчилгаа өгч, биелэлт, үр дүнг тооцон ажилласан байна.

.Тус тасаг нь урьд оны хэрэг бүртгэлтийн 21 хэргийн үлдэгдэлтэй байснаас 9 хэргийг хаах саналтай Прокурорын газарт хүргүүлж, 12 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж урьд оны хэрэг бүртгэлтийн хэргийг 100 хувь 4 сард шалгаж дуусгасан ба урьд оны мөрдөн байцаалтын 7 хэргийн үлдэгдэлтэй байснаас 5 хэргийг Шүүхэд шилжүүлэх саналтай Прокурорын газарт шилжүүлж, 2 хэргийг харьяаллын дагуу

шилжүүлэн мөрдөн байцаалтын хэргийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан 100 хувь эцэслэн шийдвэрлэж ажилласан байна.

Тус тасагт 2020 онд Шүүхээс 6 хэрэг буюу эрүүгийн 1928001360140, 1929000310022, 1929001370057, 2028000150005, 2028000880105 1829002350160 дугаартай хэргүүд нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар буцаж ирсэн бөгөөд дээрх хэргүүдэд нэмэлт ажиллагаа хийж 100 Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлэн шийдвэрлэж ажилласан байх ба буцсан хэрэг нь нийт шалгаж шийдвэрлэсэн мөрдөн байцаалтын хэрийн 2,8 хувийг эзэлж байна.

Мөн мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1.320.710.713 төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 1.276.461.376 төгрөгийн хохирол буюу нийт хохирлын 96,6 хувийг нөхөн төлүүлж ажилласан байна.

Хариуцсан нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, эрүү, хэв журмын нөхцөл байдлыг сум, багаар нь тогтоож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах зорилгоор гэмт хэрэг гаргах болсон шалтгааны нөхцөлийг нарийн судалж, Криминалоги судалгааны багт гарган өгч, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад албан мэдэгдэл бичиж, хариуг авч ажиллаж байгаа ба мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлыг шалгах, мөрдөгчийн бичиж байгаа албан мэдэгдлийг чанаржуулах зорилгоор “Мэдэгдэл” хэсэгчилсэн арга хэмжээг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 22-ны өдрийн хооронд, 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 08-ны өдрийн хооронд нийт 3 удаа зохион байгуулж ажилласан. Арга хэмжээний хүрээнд мөрдөгч нарт үүрэг, ажлын чиглэл бичгээр 3 удаа өгч, үр дүнг тооцон ажилласан. Тус тасаг нь 2020 оны жилийн эцсийн байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нийт 531 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 494 хэргийг шийдвэрлэн ажилласан ба нийт шийдвэрлэсэн хэргээс 255 хэрэгт буюу 51,6 хувьд нь мөрдөгчийн мэдэгдэл бичсэн байна.

Тус тасгийн мөрдөгч нарын өдөр тутмын ажлыг “Able” программд шивүүлж, мөрдөгч нарын хийсэн ажилтай өглөө бүр танилцаж, календарьчилсан төлөвлөгөөг баталж, биелэлтийг цахимаар болон дараа өдрийн өглөө нь нүд үзэн шалган ажиллав. 2020 онд “Able” программд мөрдөгч нар нийт 5126 ажил буюу 1 мөрдөгч дунджаар 6-8 ажил төлөвлөн ажилласан байна. Мөн түүвэр болон шалгах төлөвлөгөөг “Од” программд шивүүлэн, гүйцэтгэлийг хийлгүүлж, өдөр тутмын хяналтыг тавьж, хугацаа хэтэрч улайрч байгаа мэдээллүүдийг засуулж, хөдөө орон нутагт хэрэг шалгахаар явахад нь программаас түүвэр болон шалгах төлөвлөгөөг нь хэвлүүлэн өгч явуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг түргэн шуурхай хуулийн анхны хугацаанд гүйцэтгүүлж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 332 хэргийг программд шивүүлэн ажилласан ба мөрдөгч нараас программд ажиллах үйл ажиллагаа жигдэрч байна.

Мөрдөн байцаах албаны 2020 оны хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг мөрдөн байцаах нэгж бүр хэрхэн хангаж ажилласныг улирал бүр дүгнэж ирүүлдэг ба тус Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасаг нь 1 дүгээр улиралд 12 заалтаас 8 заалтыг хангаж орон нутгийн мөрдөн байцаах нэгжүүдийн хэмжээнд 2 дугаар байр, 2, 3, дугаар улиралд 12 заалтаас 11 заалтыг хангаж тус тус 1 дүгээр байр, 4 дүгээр улиралд болон жилийн эцсийн байдлаар 12 заалтаас 12 заалтыг бүрэн хангаж бусад нэгжүүдээ хошуучлан ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн онц ноцтой, хүнд гэмт хэргийн талаарх

мэдээ, мэдээллийг ЦГ, МБА-ны дарга болон ХГХМШХ-ийн дарга нарт шуурхай танилцуулж, удирдлагыг бодит мэдээллээр хангаж, чиг үүргийн хэлтсүүдтэй харилцан мэдээлэл солилцож, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх боломжийг бүрдүүлэн, аймгийн төвийн 4 мөрдөгчийн дунд 1, тасгийн даргад 1, Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 2 мөрдөгчид 2, Гурвантэс сум, Ханбогд сум, Ханбогд сумын Хайрхан багийн “Цагаанхад” хариуцсан мөрдөгч нарт тус бүр 1, нийт 7 ширхэг “Samsung Cover” маркийн гар утас, 2 ширхэг “Vimble” брэндийн гар утасны хөдөлгөөн тогтворжуулагч зэргийг шийдвэрлүүлэн олгуулж, “True conf” программыг суулгаж, ХГХМШХ-т танилцуулан “IP” хаяг авч, хөдөлгөөнт төхөөрөмжийг хэргийн газрын үзлэг, цогцост хийх шинжилгээ болон шаардлагатай мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах ажлыг тогтмолжуулах талаар мөрдөгч нарт үүрэг, ажлын чиглэлийг өгч, программыг ашигласан талаарх “Бүртгэлийн дэвтэр”-ийг шинээр нээж, бүртгэлжүүлэн ажиллаж байна. Сумдын болон аймгийн төвийн ахлах мөрдөгч, мөрдөгч нарт хүний амь нас хохирсон, олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй хэргийн газрын үзлэг, цогцост задлан шинжилгээ хийх болон бусад төрлийн ажиллагаа явуулахдаа “True conf” программыг ашиглаж, мэдээ мэдээллээр хангаж, зөвлөмж авч хэвших талаар 6 заалт бүхий ажлын чиглэл хүргүүлж, үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг сар, улирал бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд тусгаж, дүгнүүлж байхаар зохион байгуулалтыг хийн ажиллаж байна.

2.3. Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

Тус тасаг нь 2020 оны 07 сарын байдлаар иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас 140 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 36 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 4 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 57 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж, 37 гомдол мэдээлэлд мөрдөн байцаалтын хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, үлдэгдэл 6 гомдол мэдээлэлтэй хуулийн хугацаандаа шалгагдаж байна.

Хүлээн авсан гомдол мэдээллээс хугацаа хэтрүүлсэн гомдол мэдээлэл байхгүй 100 хувь хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэж байна.

Хүлээн авч хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн 36 гомдол мэдээлэлд 100 хувь гомдол гаргагчид хариу өгч ажиллаж байна.

Тус тасаг нь 100 хэрэг бүртгэлтийн хэрэг шалгаснаас 20 хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлж, 60 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, харьяаллын дагуу 5 хэрэг шилжүүлж, одоо 15 хэргийн үлдэгдэлтэй байна.

Гомдол мэдээллээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 39 мөрдөн байцаалтын хэрэг, бусад газраас шилжиж ирсэн 4 мөрдөн байцаалтын хэрэг, хэрэг бүртгэлтийн хэргээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 60 хэрэг нийт мөрдөн байцаалтын 103 хэрэг шалгаснаас 100 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, мөрдөн байцаалтын 1 хэргийг хэрэгсэхгүй болгож одоо мөрдөн байцаалтын 1 хэргийн үлдэгдэлтэй, хэрэг бүртгэлтийн 15 хэрэг, мөрдөн байцаалтын 1 хэрэг нийт 16 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг хуулийн анхны хугацаандаа шалгагдаж байна.

Иргэд, аж ахуй нэгж, байгууллагад 66.190.000 \жаран зургаан сая нэг зуун ерэн мянга, \төгрөгийн хохирол учирснаас 63.890.000 \жаран гурван сая найман зуун ерэн мянга\ төгрөгийн хохирол төлөгдөж 2.300.000 төгрөгийн үлдэгдэлтэй хохирол нөхөн төлүүлэлт 96.5 хувьтай нөхөн төлөгдсөн байна.

Хэрэг бүртгэх албаны 2020 онд хүрэх түвшингийн байдлаар урьд оны дугаартай хэрэг бүртгэлтийн 14 хэрэг байснаас 13 хэргийг шийдвэрлэж, хэрэг бүртгэлтийн 1 хэргийн

үлдэгдэлтэй урьд оны дугаартай хэрэг бүртгэлтийн хэрэг хэргийн шийдвэрлэлт 92.8 хувьтай байна. Урьд оны мөрдөн байцаалтын үлдэгдэл хэрэггүй ажилласан.

2020 оны 07 сарын байдлаар хэргийн илрүүлэлт 85.0 хувьтай, хэргийн шийдвэрлэлт 85.7 хувьтай байна.

Мөрдөн байцаалтын 103 хэргээс 101 хэргийг шийдвэрлэн 1 хэргийн үлдэгдэлтэй нийт шалгасан мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт 99.1 хувьтай байна.

Нийт шалгасан хэргээс хугацаа сунгасан, прокурор, шүүхээс буцсан гологдол хэрэг байхгүй, яллагдагч оргон зайлснаар түдгэлзүүлсэн хэрэг байхгүй бүх хэрэг хуулийн анхны хугацаандаа шалгагдаж шийдвэрлэгдэж байна.

Гомдол мэдээллийг хүлээн аваад эзэн холбогдогч нь тодорхой хэрэгт түргэн шуурхай шийдэх, иргэдийг чирэгдүүлэхгүй байхын тулд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхгүй шууд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж хөнгөн хэргийг 14 хоногийн дотор хүнд хэргийг 30 хоногийн дотор шийдвэрлэж шийдвэрлэсэн нь хэргийн хувь өссөн бөгөөд сөрөг тал нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдолд хэрэг илэрсэнд тооцдог учраас гомдол мэдээллээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдолд илрүүлэлтийн хувь буурсан байна.

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасаг нь 2019 оны 07 сарын байдлаар илрүүлэлт 80.4 хувьтай, шийдвэрлэлт 92.1 хувьтай байсан бол 2020 оны 07 сарын байдлаар хэргийн илрүүлэлт 85 хувьтай хувьтай шийдвэрлэлт 99.1 хувьд хүргэн илрүүлэлт 4.6 хувиар өссөн шийдвэрлэлт 7 хувиар өссөн үзүүлэлттэй ажилласан байна.

2020 оны 3 дугаар улиралд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/746 дугаар тушаалаар Хэрэг бүртгэх албаны албаны орон тоог өөр нэгж рүү шилжүүлэн чиг үүргийг хариуцуулсантай холбогдуулан тус Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасгийн даргыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн чиглэлийн ахлах байцаагч, ахлах мөрдөгчийг Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөгчөөр тус тус өөрчлөн шилжүүлсэн байна.

2.4. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Цагдаагийн байгууллагын нэгдсэн систем /system.police.gov/, цагдаагийн байгууллагын мэдээллийн систем /dbservice.police.gov/-д хамгаалалт, эргүүл удирдлагын систем /rmanage.police.gov/-д өдөр тутмын эргүүлийн томилгоог хийж хяналт тавин ажиллав.

Давхардсан тоогоор 245 офицер, 415 хүн/цагийн, 1258 цагдаа, 1356 хүн/цагийн, 351 олон нийтийн цагдаа 1254 хүн/цагийн эргүүл/пост/, хяналт шалгалтын үүргийг 6 суурин станц, автомашины 11 станц, алба хаагч бүр гар станц, агсамж, 278 автомашинтайгаар 35.900.000 км туулж, 5840 литр шатахуун зарцуулан эргүүл/пост/-д үүрэг гүйцэтгэж, 945 цэгт хяналт тавин гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2541 удаагийн дуудлага мэдээллийг хүлээн авч, хэргийн газрын хамгаалалтад 41 удаа үүрэг гүйцэтгэж, 1562 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 1512 этгээдэд 50624250 төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 215 этгээдийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, 1036 этгээдийг эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 180 жолоочийг илрүүлж, 6700 тээврийн хэрэгслийг шалгаж, зөрчилтэй явсан 4500 тээврийн хэрэгслийг саатуулж, 450 аж ахуйн нэгжийг шалгаж, 145.5

литр архи, 75,5 литр пиво согтууруулах ундаа зүйлсийг хурааж, 827 хайрцаг тамхийг хурааж, холбогдох зөрчилд шалгах ажиллагааг явуулав.

Аймгийн хэмжээнд 79 цэгт хяналтын 24 цагийн пост ажиллуулж, хөл хорио хорио цээрийн дэглэмийг сахиулж, цагдаагийн газраас давхардсан тоогоор 602 алба хаагч, бусад байгууллагаас 868 ажилтан алба хаагч 79 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж ажилласан бөгөөд онцгой нөхцөл байдлын үед ажиллах төлөвлөгөө, схем, зураглалд тодотгол хийж, “Гамшгийн үед ажиллах төлөвлөгөө”, “Бүсчлэн хаах төлөвлөгөө”-г шинэчлэн батлуулав. Цагдаагийн байгууллагын 2020 оны “Терроризмоос сэргийлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулж батлуулав. Цагдаагийн газрын даргын 2020 оны 01 дүгээр сард “Орон тооны бус тусгай бүлгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай” тушаалыг гаргаж, тусгай бүлгийн алба хаагчдыг томилгоожуулав.

2020 оны 05-р сард мөн Орон тооны бус тусгай бүлгийн бүрэлдэхүүнд тодотгол хийж алба хаагч нараар гарын үсэг зуруулж баталгаажуулав. “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль”, “2020 оны Орон нутгийн ээлжит сонгууль”-ийн үед ажиллах үеийн хамгаалалтын төлөвлөгөө, зураглал, эмх замбараагүй байдал би болсон үед ажиллах төлөвлөгөө зураглалыг тус тус боловсруулж Цагдаагийн газрын даргаар батлуулж, алба хаагчдын албаны бэлэн байдлыг 6 удаа шалгаж, Цагдаагийн газрын даргын үүргийг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж гарын үсэг зуруулж баталгаа авав. Мөн үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг нэг бүрийг тусгай хэрэгслээр хангаж, хамгаалалтыг зохион байгуулсан.

Олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр: Тус аймгийн нутаг дэвсгэрт Коронавирусийн халдвар /Covid-19/ / цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд Өмнөговь аймгийн Онцгой комиссын шийдвэр, Өмнөд бүсийн төв Онцгой байдлын газартай хамтран 15 тусгаарлах байр бэлдэж уг тусгаарлах байранд 2020 онд тусгаарлан ажиглалтад Гашуунсухайт хилийн боомтод 36, Шивээхүрэн хилийн боомтод 31, Ханхонгор суманд 1, гэрийн ажиглалтад 440, хавьтлын тусгаарлалтад 15 хүнийг хяналтад авч хамгаалалтад цагдаагийн 22 алба хаагч, бусад байгууллагаас 33 ажилтан хамтран ажилласан бөгөөд цаашид Коронавирусийн халдвар /Covid-19/ / цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт тавьж ажиллаж байна.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авах, шалган шийдвэрлэх ажиллагааны талаар: Өнгөрсөн хугацаанд иргэдээс ирүүлсэн 2136 зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол, дуудлага мэдээллийг хүлээн авч, хуулийн анхны хугацаанд зөрчил шалгах ажиллагаа явуулан 526 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 645 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, харьяаллын дагуу 136 материалыг шилжүүлж, 778 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдэж ажиллагаанд 51 зөрчил ажиллагаанд байна.

Хорих анги болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн хүмүүст тавих захиргааны хяналтын талаар: Захиргааны хяналтад байгаа 84 хүний хувийн хэргийн баяжилтыг хийж, 38 хүнтэй биечлэн уулзаж зөвлөгөө өгч, 24 хүнтэй ганцаарчлан уулзалт хийж зөвлөгөө өгсөн байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааны талаар: Гэмт хэрэг, зөрчил үйлдсэний улмаас хүргэгдэж ирсэн 940 этгээдийг хөдлөнгийн гэрчийг байлцуулан биед нь эрүүл мэндийн үзлэг хийж, эд зүйлийг түр хураан авч тэмдэглэл хөтлөн эрүүлжүүлсэн бөгөөд 900 эрэгтэй, 40 эмэгтэйг эрүүлжүүлсэн байна.

Мөн баривчлах байранд Шүүхээс 7-30 хоногийн хугацаатай баривчлах шийтгэл оногдуулсан 281 этгээдийг шүүгчийн захирамжаар хүлээн авч, 7 хоногт 1 удаа усанд оруулж, 7 хоногийн баасан гаригт цагийн хуваарийн дагуу 15-20 минутын хугацаатай

эргэлт, уулзалтыг зохион байгуулж, баривчлагдсан 281 этгээдийн биед нь үзлэг хийж хувийн хэрэгт тэмдэглэл хөтлөн зардал болох 13143360 төгрөгийг төрийн сангийн нэгдсэн санд төвлөрүүлсэн.

ЭСБ-нд баривчилгаанд байгаа хүмүүсийн хоолны дээжийг өдөр бүр авч, Дундговь аймаг дахь Мэргэжлийн хяналтын газрын харьяа итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлж, хоолны илчлэгийг тухай бүр тогтоолгосон.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлын хангах хэсгийн үйл ажиллагааны талаар: Аймгийн Шүүхийн тамгын газартай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, үр дүнг тооцон ажиллав. Шүүхийн удирдлага, ажилтнуудтай 6 удаагийн уулзалт зөвлөгөөнийг хийж, хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцон ажиллав. Шүүхийн харуул, хамгаалалтын цагдаа нар Цагдаагийн газрын даргын баталсан томилгооны дагуу эрүүгийн хэргийн шүүх хуралд 340 удаа, иргэний хэргийн шүүх хуралд 409 удаа, захиргааны хэргийн шүүх хуралд 44 удаа, зөрчлийн шүүх хурал 52 нийт 845 удаагийн шүүх хурлын хамгаалалтад үүрэг гүйцэтгэж, 4510 оролцогчийн аюулгүй байдлыг хангаж, шүүхийн байранд 367 удаа 2866 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, 9142 иргэнийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлж ажилласан.

“Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах” журмын дагуу Шүүхийн байранд 41, цагдан хорих байранд 45 удаа, Ханбогд сум дахь сум дундын Шүүхийн байранд 12 удаагийн хуяглан хүргэх ажиллагааг ямар нэг зөрчилгүй зохион байгуулж шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэв.

Аймгийн хэмжээнд шүүхээс даалгасан бусад 41 хүнийг эрэн сурвалжилж, шүүхээс эрэн сурвалжлагдаж байгаа 16 этгээдийн хаяг байршлыг тогтоож, Шүүхийн тамгын газарт болон нэхэмжлэл гаргагчид албан бичгээр мэдэгдэж, албадан ирүүлэх захирамжтай 26 этгээдийг олж тогтоон, Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах мэдээллийн нэгдсэн санд тус цагдаагийн газраас эрэн сурвалжлах санд 18 хүний үлдэгдэлтэй байна.

Хамгаалалт зохицуулалтын чиглэлээр: “Сар шинэ”, “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”, “Монгол цэргийн өдөр”, “Эрх үрсийн баяр”, Монгол улсын Засгийн газрын 102 дугаар тогтоолоор баталсан шинэ төрлийн коронавирус /COVED-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2 удаа бүрэн хааж давхардсан тоогоор 368 алба хаагч, бусад байгууллагын 608 ажилтан алба хаагчийг төлөвлөгөө, зураглалын дагуу хуваарилж Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг бүслэн хаасан. Тухайлбал:

- “МУ-ын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль”,
- “Орон нутгийн 2020 оны ээлжит сонгууль”,
- Өмнөговь аймгийн засаг даргын тамгын газраас санаачлан зохион байгуулж байгаа Монгол Улсын Харцага Ц.Одбаярын цолны мялаалгын баяр наадмын хамгаалалт
- Монгол Улсын Ерөнхийлөгч 3 удаа Өмнөговь аймгийн нутагт айлчилж төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай танилцах
- Монгол Улсын Ерөнхий сайд 3 удаа Өмнөговь аймгийн нутагт айлчилж төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай танилцах, иргэдтэй уулзах
- Монгол Улсын Их Хурлын дарга 1 удаа Өмнөговь аймгийн нутагт айлчилж төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай танилцах
- Гэгээнтэн /лам багш/ Өмнөговь аймгийн иргэдтэй уулзаж бурхан ном айлдах

- Номгон сумын “Элстэй” гэх газар хууль бусаар гар аргаар алт олборлож байгаа иргэдийг албан тараах, хамгаалалт
- Баян далай сумын “Хувийн гол” гэх газар хууль бусаар гар аргаар алт олборлож байгаа иргэдийг албан тараах, хамгаалалт
- Иргэний хөдөлгөөн төрийн бус байгууллагын тэргүүн Цэгмэдийн хууль бус жагсаал цуглаан
- Таван-толгойгоос Гашуунсухайт хилийн боомт чиглэлийн нүүрс тээврийн жолооч нарын жагсаал цуглаан /бослого/ гэх зэрэг арга хэмжээнүүдэд төлөвлөгөө зураглал гарган 166 алба хаагч болон бусад байгууллагын 802 ажилтныг дайчлан ажиллуулсан бөгөөд ямар нэг зөрчил дутагдалгүй үүрэг гүйцэтгэсэн.

2.4. Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Замын цагдаагийн тасгаас 13 Тээврийн цагдаагийн албаны Гэрээт цагдаагийн хэлтсээс 30 алба хаагч, хот хоорондын хяналтын 2 цэгт болон нүүрс тээвэрлэлтийн автозамуудад 6 автомашин, 16 шалгах багаж, 6 согтуурал шалгах багаж, 4 согтуурал тандагч, 4 хурд хэмжигчтэйгээр үүрэг гүйцэтгэж, тасгийн дарга, ахлах зохицуулагчаас алба хаагчдын ажлын цаг ашиглалт, эргүүл хяналтын цэгийн хуваарьт тогтмол хяналт тавин ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авто тээврийн төвтэй хамтран зохион явуулж Даланзадгад сумын төвд 4 алба хаагч аймгийн төвөөс Улаанбаатар хот руу чиглэсэн улсын чанартай автозамын 2.5 дахь км-т, Цогтцэций сумын цагдаагийн хэлтсээс 5 алба хаагч сумын төв рүү орох, гарах автозамд болон уурхай орчимд, Ханбогд сумын цагдаагийн тасагт 2 алба хаагч сумын төвөөс орох, гарах автозамд, Гурвантэс сумын цагдаагийн тасагт 1 алба хаагч сумын төв рүү орох гарах автозам, нүүрс тээвэрлэлтийн автозам болон хил орчимд, Гэрээт цагдаагийн хэлтсээс 30 алба хаагч нүүрс тээвэрлэлтийн 239 км автозамыг хариуцан шалган нэвтрүүлэх цэг 1, 2, 4 дүгээр пост, Ухаа худаг уурхайгаас Гашуун Сухайт хилийн боомт хүртэлх автозамын 133 дахь км-т /Сүлжээ гэх газар/, Оюутолгой ХХК-ий автозамын уулзвар, Цагаанхад орчимд замын хяналт, шалгалтыг тогтмол зохион явуулж хоногт илрүүлсэн зөрчил, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээг өдөр бүр Замын цагдаагийн тасагт нэгтгэн Тээврийн цагдаагийн албанд 21:00 цагт өгч ажиллаа.

Эрүүгийн хэргийн шалгалт шийдвэрлэлтийн талаар

Хариуцсан нутаг дэвсгэрт 2020 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол 342 бүртгэгдсэн нь өмнөх оны /368/-аас 26 нэгжээр буюу 7.1 хувиар буурсан, нас баралт 28 байгаа нь өмнөх оны /31/-ээс 3 нэгжээр буюу 9.7 хувиар буурсан, гэмтсэн хүн 28 байгаа нь өмнөх оны /23/-аас 5 нэгжээр буюу 17.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэн прокурорын байгууллагад хянуулж ажиллаа.

Бүртгэгдсэн ослууд нь Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутгаар дамжин өнгөрөх “Ухаа худаг” уурхайгаас “Гашуун сухайт” хилийн боомт хүртэлх нүүрс тээвэрлэлтийн болон орон нутгийн авто замууд, сумдаас сумдын хооронд хөдөө хээрийн замд болсон, шалтгаан нөхцөлийг авч үзвэл хурд хэтрүүлж, зогсоох арга хэмжээ аваагүй,

хориглосон нөхцөлөөр гүйцэж түрүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эгнээ хоорондын зай баримталж хурдаа тохируулаагүй зэрэг шалтгаантай байна

Захиргааны зөрчлийн шалгалт, шийдвэрлэлтийн талаар

Энэ онд алба хаагчид гудамж замын хяналт шалгалтаар 32156 тээврийн хэрэгсэл шалгаснаас 16591 зөрчил илрүүлж, 15864 хүнийг 746.897.250 төгрөгөөр торгосон нь урьд оны мөн үе /18520/-аас 1929 нэгжээр буюу 10.5 хувиар буурсан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 727 зөрчил илрүүлж, 629 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 251.600.000 төгрөгөөр торгон 98 иргэнийг шүүхээр баривчлуулан албадан сургалтад хамруулан ажиллав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний сахилга, соёлыг дээшлүүлэхэд анхаарч, гарч буй хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор аж ахуй нэгж байгууллагад 62 мэдэгдэл, шаардлага хүргүүлэн биелэлт, үр дүнг тооцон, хариуг авч ажилласан.

Нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтыг 105 удаа, Авто тээврийн төвтэй хамтарсан хяналт шалгалтыг 86 удаа зохион явуулж Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс болон Тээврийн цагдаагийн албанаас цахим орчинд байршуулсан мэдээлэл, гарын авлага, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгээс хэвлүүлэн жолооч нарт тарааж, тогтмол тарааж ажилласан.

Энэ онд тус аймгийн Цогт-Овоо, Даланзадгад сумдын нутагт 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан цагдаагийн байнгын хяналтын постыг түшиглэн тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тодорхойлох хяналтын камер суурилуулах саналыг аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 41/970 дугаартай албан бичгээр хүргүүлснээр шаардагдах төсөв хөрөнгийг 99.810.000 /Ерэн есөн сая найман зуун арван мянган/ шийдвэрлүүлэн 2020 оны 11-р сард хяналтын камерыг суурилуулах ажлыг дуусгасан.

Тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тодорхойлох хяналтын камер суурилуулах ажлыг “Оргил дельта трейд” ХХК хийж, Даланзадгад, Цогт-Овоо сумдын хяналтын постуудад дугаар илрүүлэгчтэй, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, даатгал, татварын мэдээллийг авах, эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгслийг мэдээлэх, дундаж хурдын тодорхойлох хүчин чадал бүхий тус бүр нь 7, нийт 14 хяналтын камерыг суурилуулан төв серверийг Замын цагдаагийн тасгаас хянаж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тээврийн хэрэгслийн техникийн эвдрэл гэмтэлтэй, улсын бүртгэл, техникийн хяналтын үзлэгт ороогүй зөрчлийг арилгуулах, тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн бүтэн байдалд тавих хяналт шалгалтыг сайжруулах ажлын хүрээнд:

1. А-0202 кодтой “Даланзадгад-Улаанбаатар” чиглэлийн замд 26 удаа,
2. Тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл техникийн зөрчил, тусгай дуут болон гэрэл дохио, улсын дугаарын зөрчилд тавих хяналтыг эрчимжүүлэн ажлын тормозын систем, жолооны механизм ажиллахгүй бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцсон 4164 зөрчил илрүүлэн 83.550.000 төгрөгөөр, улсын дугааргүй буюу зөрчилтэй, улсын дугаараа нуун далдалсан 1982 зөрчил илрүүлэн 23.240.000 төгрөгөөр, хурд хэтрүүлсэн 503 зөрчил илрүүлж 25.150.000 төгрөгөөр, үзлэг оношилгоонд оруулаагүй 645 зөрчил илрүүлж 645 жолоочийг 32.250.000 төгрөгөөр, маршрутын бус замаар зорчсон 232

зөрчил илрүүлэн 232 жолоочийг 34.800.000 төгрөгөөр, тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх журам зөрчсөн 125 иргэнийг 12.500.000 төгрөгөөр, тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх журам зөрчсөн 655 зөрчил илрүүлж 13.100.000 төгрөгөөр тус тус торгосон байна.

2.5. Шуурхай удирдлагын албаны чиглэлээр:

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн нийт 3011 дуудлага мэдээлэл бүртгэснээс тухайн онд гэмт хэргийн талаарх мэдээлэл нийт 841, зөрчил нийт 2170 үүнээс сураггүй алга болсон, олдсон хүний талаарх мэдээлэл байхгүй, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нийт 92, зам тээврийн ослын нийт 1583 мэдээлэл, хүний биед халдах 34, хулгайлах 22, гүтгэх 1, АСТТХууль зөрчих 20, хүүхдийн эрх зөрчих 28, хэв журмын зөрчил 105, бусад зөрчил 285 бүртгэгдсэн байна.

Үүнээс гадаадын иргэнтэй холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн өргөдөл, гомдлын мэдээлэл тухайн сард байхгүй, цагдаагийн алба хаагчтай холбоотой болон бусад төрлийн мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авсан даруйд 110 хэргийн газрыг хамгаалалтад авч, жижүүрийн бүрэлдэхүүнийг цаг алдалгүй явуулж, хойшлуулшгүй ажиллагааг хийж, гэмт хэргийн талаар Цагдаагийн газрын дарга болон хариуцсан тасгийн дарга нарт тухай бүрд нь танилцуулан, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ болон орон нутгийн нөхцөл байдал мөн хоногийн хугацаанд хийсэн ажлын талаар дүн мэдээ, хүн хүчний болон шинэ төрлийн короно вирусын дэгдэлтээс хамгаалах хөл хорио тогтоосон, шалган нэвтрүүлсэн, хамгаалалт, тусгаарлалт хийсэн мэдээллүүдийг нэгтгэн Цагдаагийн Ерөнхий Газрын Шуурхай Удирдлагын Штабын Төв жижүүрт болон Мэдээлэл Шуурхай Удирдлагын Төвийн жижүүрт хоног тутамд өгч ажиллав.

Олон нийтийн эргүүлд нийт 58 байгууллагын 346 иргэнийг 19-21 цагийн хооронд үүрэг гүйцэтгүүлж олон нийтийн эргүүлд гаргах үед нь заавар, зөвлөгөө өгч ажилласан бөгөөд халдварт өвчин гарсантай холбогдуулан тодорхойгүй хугацаагаар олон нийтийн эргүүл гаргах ажлыг зогсоосон.

Угтах үйлчилгээний ажилтан 6719 иргэний халууныг халуун хэмжигч багажаар үзэн бүртгэж, АСАП сангаас холбогдлыг шалган цагдаагийн газарт нэвтрүүлж, камерын хяналтын ажилтан 1358 зөрчил илрүүлэн замын цагдаагийн тасагт шилжүүлж ажилласан байна.

Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийн дагуу жижүүрийн офицерууд эргүүлд гарч байгаа алба хаагчдад хутганаас хамгаалах хантааз, бээлийг тогтмол өмсгөж албаны бэлэн байдлыг шалган өөрийнхөө болон хамтрагчийнхаа аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллахыг үүрэгжүүлэн, эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүр, цэвэр усны харуул болон Монгол банк, шүүхийн харуулуудыг өдөр бүр биечлэн шалгаж аюулгүй байдлаа бүрэн хангаж сонор сэрэмжтэй үүрэг гүйцэтгэх талаар үүрэг чиглэл өгч тэмдэглэл хөтлөн 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газар болон бусад тасаг, албадаас зохион байгуулсан цахим хурлыг 121 удаа техникийн бэлэн байдлыг ханган явуулж давхардсан тоогоор 412 алба хаагчийг хамруулж ажилласан.

Байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа 106 компьютерт тогтмол үзлэг хийж 89 компьютерыг албан ёсны лицензтэй болгож хэвийн ажиллагааг хангасан, бэлэн бусын

торгуулийн 36 төхөөрөмжийг холбож, дахин дамжуулах, суурин, автомашины болон гар станц, гэрэл дохионд нийт 218 удаагийн засвар үйлчилгээ, тохиргоо хийж хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй ажиллаж байна.

Сумдын хэсгийн төлөөлөгч нарын 60 компьютерыг форматлан Цагдаагийн байгууллагын домэйн сүлжээ болон direct access сүлжээнд холбож алба хаагч бүрд зааварчилга өгч ажилласан байна.

Тайлант хугацаанд албаны компьютерт үйлдлийн систем суулгаж форматалсан 159, принтерийн хор цэнэглэх болон драйвер таниулсан 112, гар станц тохируулсан 98, гар станцыг МТХТ-д засварлуулахаар явуулсан 2, алба хаагчдад домэйн системд нэвтрэх эрх авч тохируулж өгсөн 89, цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд холбож од программ хангамж суулгасан 89, цахим гарын үсгийн программ суулгасан 16, gmail шинээр нээж хаягийн нууц үг 58-ийг сольж, 21 компьютерт алдаа засах болон вирусны программ суулгаж ажилласан мөн Эрүүгийн цагдаагийн тасгийн дотоод сүлжээний тоног төхөөрөмжид үзлэг үйлчилгээ хийсэн. Тоног төхөөрөмжүүдийг ил байрлуулсан байсныг зориулалтын хайрцагт хийж кабелин толгойг дахин цэнэглэн, эмх цэгцийг сайжруулах, ЭЦТ-ийн өрөөнд дотоод сүлжээний кабел татаж холбох, дотоодын цэргийн тусгай салааны өрөөнд интернэтийн кабел татан холболт хийх, урьдчилан сэргийлэх мэргэжилтний өрөөний кабелиудын толгойг дахин цэнэглэж, 70194608 болон 70194611 дугаарын телефон утасны кабелиг шинэчилж ажиллагаанд оруулж, МТХТ-ийн засварын төвд 2 ширхэг гар станцыг явуулсныг засварлуулан авч алба хаагч нарт хүлээлгэн өгч, эрүүлжүүлэх байрны дотоод сүлжээний кабел тасарсан гэмтлийг засварлаж, шинэ кабел татсан, соронзон цоожны нууц үгийг сольж ажилласан байна.

Цагдаагийн газрын шилэн дансны мэдээлэл болон аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээллийг цагдаагийн газрын цахим хуудсанд байршуулж, ЦЕГ МШУТ-өөс ирүүлсэн теле хяналтын камерын цахилгаан тэжээлийн судалгаа, “Э-Токен төхөөрөмж олгогдоогүй алба хаагчийн судалгаа”-г гарган хүргүүлэв.

Теле хяналтын системийн 30 камерын гэмтлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулан тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн газраас зохион явуулж буй “Үгүй гэж хэлье” аяны цахим хуудсанд нийтлэгдэж байгаа бүх мэдээ мэдээлэл, видео бичлэгийг өөрийн Facebook хуудсаар дамжуулан бусдад түгээн сурталчилж ажилласан. Мөн Цагдаагийн газрын Page хуудсыг boost хийж ажиллав.

Тайлант хугацаанд гэмт хэрэг, зөрчил, өргөдөл, гомдол, мэдээллийн санд шивэгдсэн нийт 28083 маягтыг тасгийн дарга нараар хянуулах, нэгдсэн тоо бүртгэлд авах ажлуудыг зохион байгуулан ажиллаа.

Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч нар болон албан байгууллагаас ирүүлсэн маягт, албан тоотын дагуу нийт 2634 хүний ял шийтгэгдсэн эсэхийг мэдээллийн сангаас зааврын дагуу шалгаж хариуг хүргүүлсэн мөн байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 1781 иргэний ял шийтгэгдсэн эсэх тодорхойлолтыг гарган хүргүүлж ажиллаа.

Сар бүрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулгыг 11 удаа, сумдад үйлдэгдсэн гэмт хэргийн тоон судалгааг 11 удаа, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан бусад чиглэлээр 209 судалгаа, тогтмол гаргадаг судалгааг 59 удаа, сангийн бүрдүүлэлтийн чиглэлээр 36 танилцуулга боловсруулсан, сангийн бүрдүүлэлтийг хангах зорилгоор 55 ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж, нийт алба хаагч нарыг

хамруулсан 13 сургалт, ганцаарчилсан болон хэсэгчилсэн 192 сургалт зохион байгуулж алба хаагч нарт цахимаар болон бичгээр 1823 зөвлөмж, зааварчилга бичиж хүргүүлсэн.

2.6. Улсын онц чухал объектын хамгаалалтын талаар:

Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн Объектын харуулд 24:72 цагаар 3 офицер, 8 ахлагч, ээлжийн хугацаанд 1 офицер, 2 ахлагч нийт 3 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 24 цагаар аюулгүй байдлыг хангаж хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд гүний 1, 2, 3, 4, 5 дугаар худаг, цэвэр усны нөөцийн санг 2 цаг тутамд явганаар болон машинт эргүүлийн журмаар хянаж алба хаагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч, баталгаа гаргуулан гарын үсэг зуруулан ажиллаж байна.

2020 онд объектын 1, 2 дугаар цэгээр байнгын үнэмлэхтэй 901 хүн, түр үнэмлэхээр 303 хүн шалган нэвтрүүлж ажилласан бөгөөд 1000 тээврийн хэрэгсэл зохих дүрэм зааврын дагуу шалган нэвтрүүлж хяналтад 5667 хөдөлгөөн авч нийт 7871 хөдөлгөөнийг бүртгэн ажилласан байна.

Харуулчдын сонор сэрэмж, албан үүрэг гүйцэтгэлтийг Цагдаагийн газрын ёс журмын эргүүл, салааны захирагч нар өдөр тутам тогтмол шалгаж нэмэлт үүрэг чиглэлээр хангаж ажиллалаа.

2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Монгол улсын Засгийн газар, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, аймаг, сумын ИТХ, ЗДТГ, ГХУСАЗСЗ-өөс гаргасан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой албан даалгавар, хөтөлбөр, ажлын чиглэлийг өдөр тутмын үйл ажиллагаандаа удирдлага болгон биелэлт үр дүнг тооцож ажиллалаа.

Өмнөговь аймгийн хэмжээнд Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомж, “Аюулгүй-Амар тайван Өмнөговь”, “Архидан согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх”, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, ЦЕГ-аас зохион байгуулж байгаа “Сар шинэ-2020”, Мөрдөн байцаах албанаас зохион байгуулсан залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Ятгах тусам нягтал”, Хэрэг бүртгэх албанаас зохион байгуулсан хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Архигүй орчин”, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсээс Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хайр өвтгөдөггүй” нэгдсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээлэл, танилцуулгыг аймгийн Засаг дарга, ГХУСАЗСЗ-д танилцуулан зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 онд улсын болон орон нутгийн төсөвт 599.840.000 /таван зуун ерэн есөн сая найман зуун дөчин мянган төгрөг/-ийг урьдчилан сэргийлэх ажлын зардалд тусгуулсан.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2020 оны нэгдүгээр хуралд 2019 оны ажлыг тайлагнаж, гэмт хэргийн криминологи судалгааг гаргаж дийлэнх бүртгэгдсэн зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэл, өмчлөлийн эсрэг хулгай, архидан согтуурсны улмаас үйлдэгдэх гэмт хэрэг бууруулах чиглэлээр 4 улиралдаа нэг, нэг нөлөөллийн аяныг зохион байгуулахаар хэлэлцэж 2020 оны төлөвлөгөөнд 16 ажил арга хэмжээг санаачлан хүргүүлж батлуулсан.

2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн архидан согтуурахын эсрэг “Зөв хүн-Зөв гэр бүл-Зөв ирээдүй” уриатай “Үгүй” аяныг зохион байгуулж, зохион байгуулахад шаардлагатай 49,953,000 төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ-аас гаргуулахаар шийдвэрлүүлэн ажиллалаа. Аяныг хэрхэн зохион байгуулах удирдамж чиглэлийн дагуу харьяа хэлтэс, тасаг, хэсэг рүү ажлын чиглэлийг Цагдаагийн газрын даргын нэр дээр гаргаж хүргүүлэв. Мөн аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргын нэр дээр бүх сумд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, уул уурхайн компаниудад аяныг дэмжиж идэвхтэй оролцох талаар албан бичиг хүргүүлсэн. Даланзадгад сумын ГХУСАЗСЗ-ийн 2020 оны нэгдүгээр хуралд 2019 оны ажлыг тайлагнаж, 2020 оны төлөвлөгөөнд 23 ажил арга хэмжээг санаачлан хүргүүлж, батлуулсан.

“Үгүй” аяны явц, зохион байгуулалтын талаар алба хаагчдад мэдээлэл өгч, Цагдаагийн газрын даргын нэр дээр харьяа нутаг дэвсгэр хариуцсан хэлтэс, тасаг, хэсгүүдэд үүрэг, ажлын чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Мөн аймгийн Засаг даргын нэр дээр аймгийн нийт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, компаниудад, аймгийн ИТХ-ын даргын нэр дээр бүх сумдын ГХУССЗСЗ-ийн дарга нарт аяныг Цагдаагийн байгууллагатай хамтран санаачилгатай зохион байгуулж, ажлын тайланг ирүүлэх талаар үүрэг, ажлын чиглэл хүргүүллээ.

Нөлөөллийн аяныг хамтран дэмжиж зохион байгуулах төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудын 20 төлөөлөгчтэй уулзалт хийж, үйл ажиллагаанд хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцож, төлөвлөгөөний дагуу ажлаа хуваарилсан.

Мөн ЭМГ, БОЭТ, МХГ, Статистикийн хэлтэс, багийн Засаг дарга нарт согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой болон архаг архичдын талаар судалгаа авахаар албан бичиг хүргүүлэн, судалгаануудыг авч ажиллалаа.

Цагдаагийн газрын даргын 2020.01.24-ны өдрийн А/10 тоот тушаалаар нөлөөллийн аяныг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллав. Аяны үндсэн санаа концепц, уриалга, лого, постер, фрэйм, ковер гаргах хэвлэлийн дизайнерыг шалгаруулан, захиалгаар 15 төрлийн хэвлэлийн эх бэлтгүүлж ажиллав. Мөн график дизайнерын компаниудаас үнийн санал авч, чанарын шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан олны танил 15 хүнээр урилга видео, уран сайхны найруулга бүхий 10 видео шторк хийлгэхээр санааг гарган хүргүүлэв.

Тус аймгийн Цогт-Овоо, Даланзадгад сумдын нутагт 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан цагдаагийн байнгын хяналтын постыг түшиглэн тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тодорхойлох хяналтын камер суурилуулах саналыг аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 41/970 дугаартай албан бичгээр хүргүүлснээр шаардагдах төсөв хөрөнгийг 99.810.000 /Ерэн есөн сая найман зуун арван мянган/ Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас шийдвэрлүүлэн, хяналтын камерыг суурилуулах ажлыг “Оргил дельта трейд” ХХК-аар гүйцэтгүүлэх тухай А/1034 дугаартай захирамж гаргуулан гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.

Орон нутгийн зам хөдөлгөөний соёл урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд Даланзадгад-Мандалговь, Даланзадгад Баяндалай сум чиглэлийн нийт 254 километр хатуу хучилттай авто зам дагуу байрлуулах мэдээллийн гэрэлтэй самбар 5 ширхэг, дуут хурд сааруулагч 25 километр тутамд, гэрэлтдэг маяк 17 ширхэг, аюулгүйн зогсоол 4 ширхгийг тохижуулах, автозамын огцом эргэлттэй аюултай хэсгийн захаар хэвтээ тэмдэглэл шинээр хийх /нийт 65 км үргэлжилнэ/, Даланзадгад сумын ерөнхий

боловсролын 7 сургуулийн орчмын явган зорчигчийн гарцыг гэрэлтүүлэх зэрэг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд шаардагдах 80.600.000 /наян сая зургаан зуун мянга/ төгрөгийг Говийн оюу хөгжлийг дэмжих сангаас шийдвэрлүүлэн уг ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулах ажил зохион байгуулагдаж байна.

Аймгийн засаг даргын 2018 оны А/508 дугаартай захирамжаар батлагдсан хүнд даацын ачааны авто машины зорчих замын маршрутын дагуу 3.5 тонноос дээш жинтэй ачааны авто машиныг аймгийн төвийн урдуур зорчуулж захирамжийн хэрэгжилтийг ханган Даланзадгад сумын Захирагчийн ажлын албатай хамтран хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгсэлд түр замын зөвшөөрөл олгон хяналт тавьж байна. Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчид сумын Засаг даргын ачаа тээврийн хэрэгслийн чиглэлийг шинэчлэн батлах тухай 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/123 тоот захирамж мөн тус сумын төв рүү хүнд даацын автомашин нэвтрэхийг хориглох тухай 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/144 тоот дугаартай захирамж, 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/82 тоот дугаартай “Таван толгой түлш” ХХК-ний ачаа тээврийн хэрэгслийн зорчих автозамын чиглэлийг тогтоох захирамжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээний талаар дараах ажлыг хийж хэрэгжүүллээ. Үүнд:

ЦЕГ-аас зохион байгуулж байгаа “Сар шинэ-2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: Шинэчлэн найруулсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг таниулах зорилгоор Хуулийн хэлтсийн 2019 оны 5г/5989 дүгээр албан бичгээр ирүүлсэн гарын авлагаар сургалт бэлтгэж, Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйжид байршуулсан видео тус бүр Цагдаагийн газрын 58 алба хаагчдад 2 удаа сургалт зохион байгуулан, сумдын хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарт сургалтыг Power Point программ дээр бэлтгэж, сурталчилж ажиллахыг үүрэг болгон ажлын чиглэл хүргүүлэн ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хуулийг сурталчлан таниулах, нэг мөр хэрэгжүүлэх чиглэлээр Цагдаагийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 39/72 дугаар албан бичгийг 53 төрийн болон төрийн бус байгууллагуудад хүргүүлэн сургалт авах хүсэлт ирүүлсэн 6 байгууллагын 132 албан хаагчдад сургалт явуулж, “Нутгийн захиргааны байгууллагын үүрэг”, “Төрийн алба хаагчдын үүрэг”, “Иргэний үүрэг”, “Иргэдэд гэмт хэрэг, зөрчлийн талаар үнэн бодит мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах” чиглэлээр гарын авлага бэлтгэж 350 иргэнд тарааж ажилласан. Хуулийг сурталчлах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын “Урьдчилан сэргийлэх хэлтэс” пэйж хуудсанд байршуулсан видео шторкийг Өмнөговь Цагдаагийн газрын Facebook, Page хуудсанд байршуулж олон дагагчтай зарын групп болон Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумд болон Цагаан хадны жолооч нарын 1,921,394 дагагчтай 80 групп шэйрлэсэн ажилласан байна. Мөн Өмнөговь Цагдаагийн газрын Facebook, page-д 65 мэдээ, мэдээлэл байршуулан web хуудсанд хулгай, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Өмнөговь Цагдаагийн газрын Facebook, page, web хуудсанд 7 постор байршуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 1 удаа яриа таниулга өгч ажилласан байна. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн гол шалтгаан болсон архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах

нөхцөлийг бүрдүүлэх, согтууруулах ундааны хор холбогдол, мөн чанарыг олон нийтэд таниулж, согтууруулах ундаагүй сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж чаддаг эрүүл хандлагыг төлөвшүүлэх, хойч үе үр хүүхдэдээ үлгэрлэн дуурайх замаар архидан согтуурах явдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор архинд “Үгүй гэж хэлье” нэртэй нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар нь Мөрдөн байцаах албаны даргын 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 11/62 дугаартай мэдээлэл ажлын чиглэлийг хүлээн авч “Ятгах тусам нягтал” Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион явуулах 12 заалт бүхий салбар төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулан нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, сумдад дотоод сүлжээгээр хүргүүлсэн ба хариуцсан нутаг дэвсгэрт арга хэмжээг чанар үр дүнтэй зохион явуулах талаар сум дундын Цагдаагийн хэлтэс, тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт тухай бүр нь болон бичгээр 10 заалт бүхий үүрэг ажлын чиглэлийг тус тус хүргүүлж дараах ажил арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үүнд: Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнд тус аяны зорилго, төлөвлөгөөг танилцуулан “Ятгах тусам нягтал” залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд нэгдүүлж алба хаагч нэг бүрийн фейсбүүк хаягийн профайл хүрээг “Ятгах тусам нягтал” аяны лого бүхий зургаар солих ажлыг зохион явуулснаар аяны арга хэмжээг эхлүүлсэн ба тус арга хэмжээний хүрээнд мөрдөгч болон хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг багт хувааж хийх ажлыг хуваарилан зохион байгуулалтын арга хэмжээг авч хийсэн ажлыг 7 хоног, 14 хоногоор авч нэгтгэн Мөрдөн байцаах албанд хүргүүлсэн.

Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын нээлттэй пэйж хуудас болон фейсбүүк хуудсыг “Ятгах тусам нягтал” хүрээтэй болгосон ба Мөрдөн байцаах алба, Урьдчилан сэргийлэх хэлтсээс өөрийн пэйж хуудсанд байрлуулсан “Ятгах тусам нягтал” логотой зурган постер, видеонуудыг шэйрлэх, шэйрлэсэн талаар скрэншот хийж “Бид нэг хамт олон” хаалттай группээр дамжуулан мэдэгдэж ажиллах талаар алба хаагч нарт чиглэл өгч хүн нэг бүрээр нь дүгнэж олон нийтэд түгээн ажилласан.

Даланзадгад сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Ятгах тусам нягтал” аяны лого бүхий зурган мэдээлэл, постер, брошурыг 1000 ширхэг, хүрээ 6 ширхэг, сурталчилгааны мэдээлэл 50 ширхэг, 0,7 x 1,3 метрийн хэмжээтэй 2 талаасаа харагддаг хулдаасан самбар 25 ширхэг, 3х6 метрийн хэмжээтэй 1 ширхэг самбар, гудамж талбайн гэрэлтүүлэгт 70 ширхэг дарцаг зэргийг хэвлүүлэн бэлтгэж Даланзадгад сумын төв гудамж талбайд буюу олон нийтийн газарт байршуулан иргэдэд түгээн сурталчилж ажилласан. Мөрдөн байцаах албанаас ирүүлсэн 200 ширхэг зурган мэдээлэл бүхий постер, шторк, брошур зэргийг хүлээн авч түүнийгээ өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан дахин 300 ширхгийг нэмж хэвлүүлэн Даланзадгад сумын нутаг дэвсгэрт иргэд олноор цуглардаг худалдааны үйлчилгээний төвүүд, банк, шатахуун түгээх станцуудын мэдээллийн самбарт байрлуулж “Иргэн танд зөвлөж байна” нэртэй брошурыг иргэдэд тараах ажлыг зохион байгуулсан. Мөн дүрс бүхий шторк, постер зэргийг “Өмнөговь Цагдаагийн газар” “Өмнөговь нэгдсэн зарын групп” “Өмнөговь төв узель” “Өмнөговь үнэгүй зар” “Өмнөговь шуурхай зар” зэрэг олон дагагчтай хандалт ихтэй Фейсбүүк хаяг болон алба хаагчдын хувийн хаягуудаар дамжуулан анхааруулга сэрэмжлүүлэг бүхий мэдээ мэдээлэл, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах алба, урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн шторкуудыг олон удаагийн давтамжтайгаар шэйрлэж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан бөгөөд Фейсбүүк хаягуудад байрлуулсны үр дүнд 32800 иргэнд хүрсэн байна.

Мөн аялгуут шторкуудыг Өмнөговь аймгийн Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг Метро плас FM-89.1-ээр цацаж иргэдэд хүргэх ажлыг зохион явуулсан. “Ятгах тусам нягтал” залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгаас орон нутгийн “Алтанговь”, “Говийн наран”, “UCTV” зэрэг телевизүүдэд болон “Говийн мэдээ” сонин, Монцэма агентлагийн сэтгүүлч нарт залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг ухуулга, яриа, мэдээлэл өгч тус телевизүүдээр нэвтрүүлж мөн МҮОНРадиогийн хурд агентлагийн мэдээллийн хөтөлбөрөөр цацаж иргэдэд хүргэсэн бол орон нутгийн “Говийн мэдээ” сонин 8, 9 дугаарт залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Ятгах тусам нягтал” аяны үйл ажиллагааг сурталчилсан нийтлэлийг нүүр хуудсанд 600000 төгрөгөөр гаргуулан орон нутгийн иргэдэд хүргэж ажилласан. “Ятгах тусам нягтал” аяны хүрээнд хэсгийн байцаагч, мөрдөгч нарын хамтарсан багууд урьдчилан төлөвлөсөн хуваарийн дагуу Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудаар явж нөлөөллийн аяны арга хэмжээний зорилгыг танилцуулан, уг аянд нэгдүүлж, залилах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар бэлтгэсэн сургалт, яриа таниулгыг зохион явуулж, хамрагдсан хүмүүсийн фейсбүүк хаягийн профайл зургийг аяны логотой хүрээгээр солиулж бусдад мөн түгээн хамтран ажиллахыг уриалан ажилласан бөгөөд арга хэмжээний хүрээнд Аймгийн засаг даргын тамгын газар, Шүүх, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газар, Гадаадын иргэн харьяатын газар, Зэвсэгт хүчний 167-р анги, Хилийн цэргийн 0131-р анги, Хөдөө аж ахуйн газар, Даланзадгад сумын Засаг даргын тамгын газар, Монгол банкны салбар, Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хаан банкны салбар, Нэг цэгийн үйлчилгээний төв, Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хамт олон, Улсын бүртгэлийн хэлтэс болон арилжааны 7 банк, хувийн хэвшлийн 26 аж ахуй нэгж байгууллагууд нэгдэж хамтран ажилласан. Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын Иргэдийг хүлээн авах танхимд байрлах дэлгэц, Арилжааны банкнуудын үүдэнд байрлах дэлгэцүүд болон Даланзадгад сумын төв Батмөнх даян цэцэн хааны талбайд байрлах LED дэлгэцээр аяны хүрээнд гаргасан видео шторкуудыг аяны хугацаанд нэвтрүүлэн ажилласан. Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг электрон барааны “BSB”, “Номин”, “PC mall” дэлгүүрүүдэд зарагдаж байгаа үзэсгэлэнгийн телевизорын дэлгэцээр аяны видео шторкуудыг 2020 оны 01-р сарын 15-ны өдрөөс 01-р сарын 31-ний өдрийн хооронд тасралтгүй гаргаж байсан нь шинэ санаа байсан бөгөөд үр дүн ихтэй байсан. Нүүрс тээврийн үйл ажиллагаа явагдаж байгаа нутаг дэвсгэрүүдэд тоосжилт ихтэй дээр нь шинэ төрлийн коронавирус гарсантай холбоотой маскны эрэлт ихтэй байсан тул амны маскан дээр “Ятгах тусам нягтал” аяны лого бүхий сэрэмжлүүлгийг нааж тээврийн жолооч нарт тарааж аяны зорилго, залилах гэмт хэргийн өсөлт, бууруулах шалтгаан зэрэг ухуулга яриа таниулгыг хийж ажилласан нь шинэлэг ажил арга хэмжээний нэг болсон юм. Хүнсний дэлгүүрүүдээр зарагдаж байгаа өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнүүд дээр нийт 200 ширхэг “Ятгах тусам” аяны лого бүхий сэрэмжлүүлгийг нааж уг аяныг сурталчлан ажилласан. Аяны арга хэмжээг сум орон нутгийн иргэд малчдад дараах ажил арга хэмжээг зохион байгуулан хүргэж ажилласан. Үүнд: Цогтцэций суманд “Ятгах Тусам Нягтал” нөлөөллийн аяны арга хэмжээний хүрээнд тус сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчид цахим орчинд 163 мэдээлэл, 10 төрлийн видео бичлэгийг Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Манлай сумын группд тавьж ажилласан. Мөн 7 төрлийн самбар бэлтгэж, Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудыг нэгтгэж, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

чиглэлээр 4 төрлийн зурагт хуудас, 5 төрлийн тараах материал бэлтгэн иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад тарааж хамтран ажилласан. Иргэд олон нийтийг Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өртөж хохирохгүй байх талаар Цогтцэций сумын төв үзель, болон “Цогтцэций сумын шуурхай зар”, “Цогтцэций сумын зарын нэгдсэн групп” зэрэг хандалт ихтэй фейсбүүк хаяг болон алба хаагчдын хувийн хаягуудаар дамжуулан анхааруулга сэрэмжлүүлэг бүхий мэдээ мэдээлэл, Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах албанаас бэлтгэсэн шторкуудыг олон удаагийн давтамжтайгаар шэйрлэж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан. Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хөдөлгөөнт хүн амын урсгал нэмэгдсэн, уул уурхай дагасан бүлэг бөөгнөрөл ихэссэн, иргэд амар хялбар аргаар мөнгө олох санаа сэдэлтэй байдгаас үүдэлтэй залилан мэхлэх гэмт хэрэгт өртөж хохирох, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 7 байгууллага төрийн бус 19 байгууллагууд болон 518 иргэдэд Залилах гэмт хэргийн талаарх ойлголт, гарч болзошгүй хор хохирлын талаар мэдлэг мэдээлэл олгох зорилгоор уулзалт, сэрэмжлүүлэг зохион байгуулан ажилласан. Ханбогд суманд Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс пэйж дээр байрлуулсан “Ятгах тусам нягтал” аяны 15 төрлийн видео шторкийг Ханбогд сум Цагдаагийн тасаг, Ханбогд сумын нэгдсэн зар болон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн зарын нэгдсэн хаяг болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллалаа. Ханбогд сумын Жавхлант, Гавилууд, Баян, Номгон багийн 170 малчин иргэнд, мөн 19 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн 250 ажилтан алба хаагч нарт “Ятгах тусам нягтал”, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар сургалт орж, мэдээлэл хийж ажилласан. “Ятгах тусам нягтал” аяны 15 төрлийн видео, шторк, простеруудыг Ханбогд сум Цагдаагийн тасаг фейсбүүк хаягаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллага, сумын зарын нэгдсэн фейсбүүк хаягаар иргэдэд хүргэж, “Ятгах тусам нягтал”, Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, анхааруулгыг нийт 1000 ширхгийг хэвлэж малчид, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын ажилтан алба хаагч нарт тарааж сурталчилсан. Ханбогд суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллагын мэдээллийн самбарт “Ятгах тусам нягтал” аяны сэрэмжлүүлгийг байршуулж, иргэд жолооч нарт 500 ширхэг гарын авлага материалыг тараасан. Ханбогд сумын Хайрхан багийн нутагт “Ятгах тусам нягтал” аяны арга хэмжээний хүрээнд Хилийн шалган нэвтрүүлэх цэргийн 18 алба хаагчдад сургалт зохион байгуулж “Ятгах тусам нягтал” аянд нэгдүүлсэн. Гашуун сухайт авто зам ХХК-ний хөдөлгөөнт эргүүл, нүүрс тээврийн жолооч нарт “Ятгах тусам нягтал” аяны 200 ширхэг сэрэмжлүүлгийг тарааж аянд нэгдүүлэв. Ханбогд сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудад арга хэмжээний сэрэмжлүүлэг, мэдээллийг бүрэн хүргүүлж “Ятгах тусам нягтал” 15 төрлийн сэрэмжлүүлгийг 1700 ширхэг хэвлэж байгууллагын мэдээллийн самбарт байршуулж иргэдэд тарааж урьдчилан сэргийлж ажиллав. Гурвантэс суманд нийт 12 аж ахуй нэгжийн 327 хүнд сургалт зохион байгуулж Ятгах тусам нягтал арга хэмжээг сурталчилж урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан ба сумын төвд 3х5м, болон 3х3м хэмжээтэй хулдаасан самбарыг байрлуулан тээврийн хэрэгслийн жолооч болон иргэдэд нийт 5 төрлийн 150 ширхэг ухуулга сурталчилгааны материал тарааж ажилласан. Булган сумын хэмжээнд Сум орон нутгийн Засаг захиргаа удирдлагуудаас эхлэн Засаг даргын тамгын газрын хамт олон, Эрүүл мэндийн төв, 5-р цэцэрлэг, “Кокс заг” ОНӨАҮГ, Цаг уур зэрэг

байгууллагуудад залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт мэдээлэл өгч уг арга хэмжээнд нэгдүүлэн хамтран зохион байгуулж ажилласан ба Булган сумын ГХУСАЗСЗөвлөлөөс “Ятгах тусам нягтал” аяны лого бүхий 4x5 метрийн харьцаатай хулдаасан самбарыг сумын төвд байрлуулан замын хөдөлгөөний хяналт шалгалтын үеэр “Ятгах тусам нягтал” зурагт хуудсыг тээврийн хэрэгслийн жолооч нарт тарааж мэдээлэл өгч аянд нэгдүүлснээс гадна сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг дэлгүүр аж ахуй нэгжүүдэд “Ятгах тусам нягтал” аяны зурагт хуудаснуудыг тараан урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч ажилласан. Мөн 2020 оны 01 сарын 24-нд 4 багийн нэгдсэн өдөрлөгөөр малчид иргэдэд Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шинээр батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлан мэдээлэл өгч гарын авлага боршур тараан ажиллалаа.

Хэрэг бүртгэх албанаас ахуйн хүрээнд архидан согтуурсны улмаас хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг зөрчилд, өртөж, холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтэд хууль сурталчлах, шалтгаан нөхцөлийг арилгах, хөршийн холбоог сайжруулах зорилгоор “Архигүй орчин” арга хэмжээг төлөвлөгөөний дагуу салбар төлөвлөгөө гаргаж газрын даргаар батлуулан ажиллалаа. Ухуулга, нөлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр: Ахуйн хүрээнд архидан согтуурах, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг зөрчилд өртөж, холбогдохоос урьдчилан сэргийлэх богино хэмжээний сэрэмжлүүлэг мэдээ тогтмол бэлтгэж иргэд олон нийтэд хүргэж ажилласан. Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Facebook, page, web хуудсанд “Архигүй орчин” арга хэмжээний 2 ширхэг постор бэлтгэж байршуулсан. Орон нутгийн “Алтанговь, “Говь HD” телевизүүдээр 1 удаа хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Түвшинтөр иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажилласан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсээс гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлөвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдаж буй “Хайр өвтгөдөггүй” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цагдаагийн газрын facebook, page, /web/ -д 16 төрлийн постор, 15 төрлийн шторкыг байршуулж, олон дагагчтай зарын группүүдэд шэйрлэж, түгээлтийн мэдээг цаг тухай бүр хүргэж, цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилж ажиллалаа.

Соён гэгээрүүлэх гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд: Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 60 сургалт, мэдээлэл алба хаагч, иргэдэд өгч, 388 иргэнийг хамруулсан байна. /Хамрагдсан иргэдийг ажил, мэргэжлээр нь авч үзвэл: төрийн малчин 14, оюутан 1, сурагч 98, ажилгүй 16, төрийн байгууллага 10, аж ахуй нэгж 11, ерөнхий боловсролын сургууль 1/. Тус Цагдаагийн газрын Баривчлах байранд шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 42 иргэнд “Архи ба амьдрал” сэдэвт сургалт, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан 4 иргэнийг бүртгэл судалгаанд хамруулан, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт” сэдвээр болон Монгол улсын Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгч ажиллалаа.. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх “Үгүй” аяны хүрээнд Хилийн цэргийн 0131-р ангийн 48, Зэвсэгт хүчний 167-р ангийн 45, аймгийн Төв номын сангийн 10 ажилтанд “Архи ба

амьдрал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна. Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, уулзалт, хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгуулсан байна. Шинэчлэн найруулагдсан Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар пресентейшн бэлтгэн, 44 алба хаагчдад сургалт орж бэлтгэсэн сургалтыг албаны дотоод группэд байршуулан сумдын алба хаагчдад хүргүүлсэн. Хүнс хөдөө аж ахуй, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, орон нутгийн телевизийн сэтгүүлч нар, 7-р сургуулийн нийт 103 алба хаагчдад шинэчлэн найруулсан Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулсан. Мөн ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсээс Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах зорилгоор бэлтгэсэн 2 видеог алба хаагчдад үзүүлэн, иргэдэд сурталчлах ажлыг олон нийтийн сүлжээгээр дамжуулан түгээж зохион байгуулсан байна.

Эрүүлжүүлэх саатуулах байранд 2020 оны 06 сарын байдлаар нийт 126 хүн баривчлагдсанаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж 10, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож 112, зөрчлийн тухай хуулийн 8.6-ээр 4 иргэн тус бүр шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан байна. Эдгээр иргэдэд зан үйлд нөлөөлөх ажлыг “Мөнхийн гэгээн амьдрал” ТББ-ын тэргүүн Ц.Сайнхүүтэй хамтран ажиллах гэрээ байгуулж одоогоор давхардсан тоогоор 211 иргэнд “Та үүнийг мэдэх үү”, “Аз жаргалтай гэр бүлийн нууц”, “Архины хор уршиг”, “Хандлага”, “Хүчирхэг гэр бүл”, “Эр хүн таны үнэ цэнэ”, “Эр хүний гол шинж” гэх сэдвүүдээр 56 цагийн сургалт, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 6 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөөг өгч ажилласан байна.

Аймгийн 22 ЕБС-д “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийг байгуулан бүлгэмийн 318 гишүүн сурагчдыг оролцуулан “Өсвөрийн сэргийлэх” facebook цахим хаяг нээж цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 13 постор, 1 видео, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх 4 постор, хүүхдийн эсрэг хүчирхийлэл 6 мэдээ, мэдээллийг байршуулж өөрийн сургуулийн хүүхдүүдэд дамжуулах талаар үүрэг чиглэл өгч, осол гэмтлийг бууруулах ажилд сурагчдын өөрсдийн оролцоог нэмэгдүүлэн ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирус халдвар нь манай улсад бүртгэгдэж, нийгэм эдийн засаг, хүн амын удмын сангийн аюулгүй байдалд ноцтой аюул учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэнтэйгээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан архи согтууруулах ундааг 18 цагаас хойш худалдаалахгүй байх аймгийн Засаг даргын 2020.03.10-ний өдрийн А/226 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд давхардсан тоогоор 116 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, 34 алба хаагч 61 цагийн эргүүлийн чиглэлд оруулж, хяналт тавьж ажиллав. Хууль бусаар гар дээрээс архи согтууруулах ундаа худалдан борлуулж болзошгүй эмзэг цэг болох нүүрс тээвэрлэлтийн авто замын 4, 6 дахь километрүүдэд 2 удаагийн хяналт шалгалт хийж ажилласан байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус сумын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу алба хаагчид төрийн байгууллагын алба хаагчидтай хамтран сумын төвд үйл ажиллагаа явуулж буй ресторан, зоогийн газруудад нийтийг хамарсан байдлаар архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх “Зөвлөмж”-ийг боловсруулан давхардсан тоогоор 404 аж ахуй нэгж байгууллагад хүлээлгэн өгч бүртгэлжүүлсэн. Мөн аймгийн цагдаагийн газрын даргын 2020 оны 09 тоот албан “Мэдэгдэл”-ийг сумын төвд үйл ажиллагаа явуулж буй тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр агуулах, гэрээт харуул хамгаалалт, тусгай зөвшөөрөл бүхий 40 аж ахуйн нэгж байгууллагуудад тарааж гарын үсэг зуруулан бүртгэлжүүлж, хэрэгжилтийг цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасагт хүргүүлсэн.

Орон нутгийн Алтан говь ТВ-д захиалгаар “Хуулиас гадуур Гэрэлтэй цонх” нэвтрүүлгийг хийлгэж, олон нийтэд түгээн сурталчлав. ЭЦГ-аас зохион байгуулж байгаа бага насны болон өсвөр насны охидыг бэлгийн хүчирхийлэлд өртүүлсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа “Нуугдмал” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд охидын хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, аймгийн БОЭТ, ЭМГ-т албан бичиг хүргүүлэн, насанд хүрээгүй байхдаа хүүхэд төрүүлсэн, жирэмсэлсэн, үр хөндүүлсэн охидын судалгааг гаргуулан авсан. Орон нутгийн “Алтанговь” телевиз, аймгийн ЭМГ-тай хамтран өсвөр насны охидын жирэмслэлтийн талаар нэвтрүүлэг бэлдэж, олон нийтэд хүргэв. ЕБС-ын хяналтын камерын үйл ажиллагааг сайжруулах, хүүхдийн эрхийг хангах, сургалт мэдээлэл зохион байгуулах чиглэлээр аймгийн төвийн 6 дунд сургууль, Политехник коллежид албан мэдэгдэл бичиж хүргүүлсэн. Арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн охидод зориулсан РР сургалт бэлдэн 2-р дунд сургуулийн ахлах ангийн 103 охидод сургалт зохион байгуулан ажиллав. Сурагчдын улирлын амралттай холбоотойгоор өсвөр насны охидод зохион байгуулах урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл тасарсан болно. Өсвөр насны хүүхдийн согтуурах, мансуурах донтолтын эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх нөлөөллийн аян зохион байгуулах ажлыг саналыг аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2020 оны ажлын төлөвлөгөөнд оруулан Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар зохицуулагдсан. Иргэний нийгмийн байгууллагууд хүүхдүүдийн дундах согтуурах мансуурах донтолтын эрсдэлийг үнэлэх санал асуулгыг бэлтгэн ажилласан бөгөөд хөл хориотой холбоотойгоор хойшлогдоод байна. Санал асуулгын үр дүнд насанд хүрээгүй хүүхдүүд болон сургуулийн сурагчдын дунд зохион байгуулах нөлөөллийн ажил тодорхойлогдох юм.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газруудын судалгааг гаргаж, цагдаагийн алба хаагчийн болон олон нийтийн эргүүлийн өдөр тутмын эргүүлийн чиглэлд хамруулан хяналт шалгалт хийж ажиллав. Хөл хориотой холбогдуулан цахим тоглоомын газруудын үйл ажиллагааг түр зогсоогоод байна. Судалгаагаар Даланзадгад сумын төвд 3, Цогтцэций сумын төвд 1 цахим тоглоомын газар Харилцаа холбооны зохицуулах хорооны зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2020.02.03-ны өдөр “Үгүй” аяны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэвлэлийн хурлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хамруулан зохион байгуулав. Архидан согтуурахын эсрэг бүх нийтийн нөлөөллийн аяныг Хилийн цэргийн 0131-р анги дээр очиж 48 алба хаагчид сурталчилж, аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран “Архи ба амьдрал” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Мөн Аймгийн “Номин говь” бөөний худалдааны төвийн хамт олныг аянд нэгдүүлж, худалдааны тв дэлгэцээр аяны логог тавиулж, лого бүхий тэмдгийг өөрсдөөр нь дэмжүүлэн хийлгэж, бүх худалдааны ажилтнуудад зүүлгэв. График дизайны компанийг сонгон шалгаруулж, Өмнөговь аймгийн гаралтай олны танил 15 хүнээр архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх уриалга видео, уран сайхны видео шторк 10-ыг, өөрийн Шонхор студиэр 8 уриалга видеог хийлгүүлэн олон нийтийн сүлжээнд байршуулан алба хаагчдаар түгээлгэх ажлыг зохион байгуулан ажиллав. Аймгийн засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/188, 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/226 дугаартай захирамжуудыг Ханбогд сумын төвд архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 29 аж ахуй нэгж байгууллага, Хайрхан баг Цагаан хад суурьшлын бүсэд архи согтууруулах ундаа зардаг тусгай зөвшөөрөлтэй 12, хүнсний дэлгүүр 14, явуулын цайны газар 6, гэр болон бусад цайны газар 42, 7 махны дэлгүүрт

тарааж биелэлтэд нь хяналт тавьж захирамж зөрчсөн 2 зөрчлийг илрүүлж хариуцлага тооцон ажиллаж байна. “Архи согтууруулах ундааны зүйл худалдан борлуулах түүгээр үйлчлэхгүй байх тухай” аймгийн засаг даргын захирамжийг хэрэгжүүлэн цахимаар 5 төрлийн мэдээ мэдээллийг иргэдэд тарааж ажилласан.

Шинэ төрлийн коронавирусууд урьдчилан сэргийлэх зорилгоор улсын болон аймаг, сумын Онцгой комиссоос гаргасан зөвлөмж, санамж сэрэмжлүүлгийг тухай бүр нь Цагдаагийн тасгийн цахим хаягаар иргэдэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Ханбогд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэрлэх, хадгалах үйл ажиллагаа явуулж байгаа Махам ХХК, хамгаалалтын үйл ажиллагаа явуулж байгаа Бамбай секьюрити сервис ХХК, Империа профессионал сервис ХХК-уудад Оюутолгой ХХК-ний аюулгүй байдлын хэлтэс [/OTSiteSecurity@kt.mn/](mailto:OTSiteSecurity@kt.mn)-ээр дамжуулан хүргүүлж мэдээ, мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, авто замын хөдөлгөөнд оролцогчдын хариуцлагыг дээшлүүлэх, тэдний сөрөг хандлагыг өөрчлөх, соёл төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулсан “Бид нэг амьтай шүү” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд: Тус аймгийн Даланзадгад сумын Эрүүл мэндийн газар, 5-р сургууль, Онцгой байдлын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Зэвсэгт хүчний 167-р анги, Дулааны цахилгаан станц, Холбооны 148-р анги, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Даланзадгад сумын тамгын газар, Хаан банк, Хас банк, татварын хэлтэс, захирагчийн ажлын алба, авто тээврийн газрын нийт 12 байгууллагын 263 алба хаагчдад Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа О.Чинзоригтой хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа, таниулга хийж, бүх байгууллагуудын алба хаагчдыг соён гэгээрүүлэх аяндаа нэгдүүлж, уриалга хэлүүлж ажиллалаа. Аяны хүрээнд Цагдаагийн газрын “Бид нэг амьтай шүү” нөлөөллийн ажлын хүрээнд тус Цагдаагийн газрын нийт 136 алба хаагчдын frame зургуудыг солиулж ажиллалаа. ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд байршуулсан “Бид нэг амьтай шүү” аянтай холбоотой зурган постер болон видеог Өмнөговь Цагдаагийн газар фейсбүүк хуудсанд болон аймгийн олон дагагчтай зарын групп, хүн амын төвлөрөл ихтэй томоохон сум болох Цогтцэций, Ханбогд, Цагаан хад хилийн боомтын ачаа тээврийн жолооч нарын группүүдэд шэйрлэн, илтгэх хуудсыг хүргүүлэн ажиллалаа. ЦЕГ-ын УСХ-ээс ирүүлсэн аянтай холбоотой зурган 3 төрлийн 600 ширхэг постерыг хүлээн авч аймгийн төвд шатахуун түгээх станц, орон сууцны хаалга, Банкны АТМ, авто машин, үйлчилгээний төвүүд, аж ахуйн нэгжүүд зэрэг цэгүүдэд эргүүлүүдийн хүчээр байршуулж, аймгийн худалдааны төвүүдээр нийт 43 иргэнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, аяндаа нэгдүүлсэн.

Аяны хугацаанд Замын цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагч нар замын хөдөлгөөнд оролцож буй 358 иргэдэд анхааруулга сэрэмжлүүлэг өгч, аяндаа нэгдүүлж, “Бид нэг амьтай шүү” зүрхэн постерыг тээврийн хэрэгсэлд нааж ажиллалаа.

Тус Цагдаагийн газар нь Экологийн Цагдаагийн албаны даргаас 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 16/490 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Байгалиа хамгаалъя” арга хэмжээний ажлын чиглэл, төлөвлөгөөний хүрээнд, Өмнөговь аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран дараах ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Үүнд: “Байгалиа хамгаалъя” арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан

хариуцсан нутаг дэвсгэрт арга хэмжээг чанар, үр дүнтэй зохион явуулах талаар сум дундын Цагдаагийн хэлтэс, тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт төлөвлөгөө, үүрэг ажлын чиглэл хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажилласан.

Өмнөговь аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд “Байгалиа хамгаалъя” арга хэмжээг зохион байгуулахад гарах зардлыг шийдвэрлүүлэх талаар танилцуулж, 1.110.000 төгрөгийг шийдвэрлүүлэв. Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдын дунд “Гар зургийн уралдаан”-ыг зохион байгуулах удирдамжийг батлуулан, сургуулиудад хүргүүлж, сурагчдаас ирүүлсэн зургуудыг Цагдаагийн газрын иргэдийг хүлээн авах танхимд байршуулж нийт гар зургийн уралдаанд нийт 37 хүүхэд бүтээлээ ирүүлснээс баг ангийн сурагчдаас 5 дугаар ЕБСургуулийн 2б ангийн сурагч Э.Төгөлдөр “Тэргүүн” байр Өргөмжлөл, алтан медаль, 63.000 төгрөгийн мөнгөн шагнал, мөн сургуулийн 2д ангийн сурагч О.Халиунаа “Дэд байр” Өргөмжлөл мөнгөн медаль, 54.000 төгрөгийн мөнгөн шагнал, 1-р ЕБСургуулийн 4б ангийн сурагч Э.Хонгорзул “Гутгаар байр” Өргөмжлөл хүрэл медаль, 45.000 төгрөгийн мөнгөн шагнал, 5-р ЕБСургуулийн 1а ангийн сурагч М.Сарангуа нь тусгай байрт шалгарч Өргөмжлөл, 42.750 төгрөгийн мөнгөн шагналаар тус тус шалгарсан байна. Дунд ангийн сурагчдаас 5 дугаар ЕБСургуулийн 8в ангийн сурагч О.Тэмүүжин “Тэргүүн” байр Өргөмжлөл, алтан медаль, 63.000 төгрөгийн мөнгөн шагнал, мөн сургуулийн 8в ангийн сурагч Ж.Доржжаргал “Дэд байр” Өргөмжлөл мөнгөн медаль, 54.000 төгрөгийн мөнгөн шагнал, мөн сургуулийн 6в ангийн сурагч А.Оргилболд “Гутгаар байр” Өргөмжлөл хүрэл медаль, 45.000 төгрөгийн мөнгөн шагнал, 7а ангийн сурагч Э.Мягмарсүрэн нь тусгай байрт шалгарч Өргөмжлөл, 42.750 төгрөгийн мөнгөн шагналаар тус тус шалгарсан байна. 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Өмнөговь аймгийн засаг даргын А/536 тоот захирамжийн дагуу Номгон сумын Эмгэнбулаг багийн нутаг “Элстэй” гэх газарт хууль бусаар гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, хяналт шалгалтыг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа О.Амарсанаагаар ахлуулан, нарийн бичгийн даргаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаяр, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Б.Пүрэвтулга, Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтулга, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Л.Баярсайхан, Тагнуулын газрын дарга, дэд хурандаа Ө.Ганжууржав, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Өнөржаргал, Олон нийттэй харилцах албаны дарга Б.Бямбасайхан, Авто тээврийн төвийн дарга Д.Гантуяа, Номгон сумын засаг дарга Ж.Баяр-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Уг ажлын хэсгийн хурлаар дээрх байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалт хийх удирдамжийг боловсруулан, Цагдаагийн газраас 3, Онцгой байдлын газраас 2, Мэргэжлийн хяналтын газраас 3, Авто тээврийн төвөөс 1, Байгаль орчин аялал жуулчлалын газраас 1, Эрүүл мэндийн газраас 1, Номгон сумын засаг даргын тамгын газраас 3 алба хаагчийг болон Олон нийттэй харилцах албанаас 1 сэтгүүлч нийт 17 алба хаагч, 3 тээврийн хэрэгсэлтэй 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 7 хоног ажиллах хуваарь гарган ажиллаж байна.

“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд сурталчилгааны самбарт 1 постор байршуулан, Даланзадгадын сумын төвийн гэрлийн шонгуудаар аяны лого бүхий туг байршуулж, уул уурхайн компаниудын дунд “Байгалиа хамгаалъя” аяны удирдамж гаргаж аянд идэвх санаачилгатай оролцсон, тасралтгүй зохион байгуулж, бусдад нөлөө үзүүлэхүйц шинэлэг ажил, арга хэмжээ зохион байгуулсан компаниудыг шагнаж

урамшуулах ажлын зохион байгуулж байна. Цагдаагийн газар шалгагдаж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн сүүлийн 5 жилийн судалгааг 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар гаргаж, гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг завшсан, ашигласан, түүнийг хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан шинж болон Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргээр зүйлчилж мөрдөн шалгах ажиллагаа явуулах талаар зааварчилгаа, ажлын чиглэл өгч ажилласан. “Ногоон хөгжлийн бодлого”, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”, “Байгаль орчинд хортой нөлөөлж, ашигт малтмалыг хууль бусаар ашиглаж байгаа үйл ажиллагааг таслан зогсоох талаар авах арга хэмжээний тухай зөвлөмж”, “Алт-2” үндэсний хөтөлбөрийг тасгийн алба хаагчдад танилцуулж хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэхдээ хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг ажлын чиглэл өгсөн. Хариуцсан нутагт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа 43 аж ахуй нэгж, 34 техник хэрэгсэл, 9 нөхөрлөл, 76 иргэний талаарх судалгааг Цагдаагийн байгууллагын судалгаа, хяналтын Patrol2.police.gov программд оруулан ажиллаж байгаа бөгөөд цаашид хариуцсан алба хаагчдаар тогтмол шивүүлж үр дүнг тооцож ажиллаж байна. Өмнөговь аймагт нийт эвдрэлд орж орхигдсон 14 сумын 105 газарт 481 га талбай эвдэгдсэн байсныг тогтоосон. Даланзадгад сумын төвд үйл ажиллагаа явуулдаг модны захуудад хяналт шалгалт хийж, судалгааг шинэчлэн гаргаж Patrol2.police.gov судалгаа хяналтын санд баяжилт хийн хууль бусаар заган ойд заг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан худалдан авсан, хадгалсан, боловсруулснаас хохирол учруулсан тохиолдол бүрт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, байгаль экологид учруулсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар үнэн зөв, бодитоор тогтоолгон, хохирлыг нөхөн төлүүлэх, эд хөрөнгө битүүмжлэн хамгаалах, нэхэмжлэлийг хангах ажиллагааг хойшлуулшгүй гүйцэтгэх, хууль бусаар олсон ашиг орлого, гэмт үйлдэлдээ ашигласан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу эд мөрийн баримтаар хураан авч, нэгдсэн санд төвлөрүүлэхээс гадна энэ төрлийн гэмт хэргийг давтан үйлдсэн этгээдүүдийн үйлдэл, амьжиргааны эх үүсвэрээ болгосон нөхцөл байдал, хамтран оролцогч нарыг шалган тогтоож байх талаар сумдын хэсгийн төлөөлөгч нарт зааварчилгаа өгч ажиллаж байна.

Цагдаагийн Ерөнхий газрын Хэрэг бүртгэх албаны даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 13/671 дугаартай албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэл, “Аюулгүй байдал-Амьдралын баталгаа” хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын Хэрэг бүртгэх тасаг, тус цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нар хамтран 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 10 заалт бүхий салбар төлөвлөгөө боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Арга хэмжээний зорилго, хийж гүйцэтгэх ажлууд, арга хэмжээг зохион явуулахад шаардагдах зардлын тооцоог гарган аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд танилцуулж видео шторк, гарын авлага, зурагт хуудас тараах материал хэвлүүлэхэд зардалд 800.000 төгрөгийн төсвийг шийдүүлэн, хэсэгчилсэн арга хэмжээний үед хариуцсан нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй барилга, байгууламж, үйлдвэрлэл, уул уурхайн компаниудад хүргүүлэх мэдэгдлийг боловсруулан төлөвлөгөөний хамтаар сумдын Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарт дотоод сүлжээ, цахим хаягаар

хүргүүлэн танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулсан ажил арга хэмжээний мэдээллийг өдөр бүр Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хэрэг бүртгэх албанд нэгтгэн хүргүүлсэн. Алба хаагчдын ажлын үр дүнг ахиулах чиглэлээр Цагдаагийн газрын даргаас 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр бичгээр үүрэг чиглэл өгч сумдын хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлсэн. Хүний эрүүл мэндэд болгоомжгүйгээр хохирол учруулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Аюулгүй байдал-Амьдралын баталгаа” аяны хүрээнд орон нутагт 5 төрлийн видео шторк бэлтгэн иргэдэд түгээж, өөрийн дотоод нөөц бололцоог ашиглан 3 төрлийн зурагт хуудас 500 ширхгийг олшруулан иргэдэд тарааж ажилласан болно. Орон нутгийн “Алтанговь”, “Говь HD” телевизүүдийн цаг үеийн мэдээллийн цагаар зохион байгуулагдаж байгаа арга хэмжээний зорилго, үр дагаврын талаар мэдээлж, хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Түвшинтөр ярилцлага мэдээлэл өгч, иргэд, аж ахуйн нэгжүүдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээнд нэгдэхийг уриалсан. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт барилга, байгууламж, үйлдвэрлэл, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн судалгааг гаргаж, аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт шалгалт, бүртгэлжүүлэх чиглэлээр сумдын хэсгийн төлөөлөгч нарт нэгдсэн үүрэг чиглэл өгч биелэлтийг тооцон 2019 онд “Хүний эрүүл мэндэд болгоомжгүйгээр хохирол учруулах” гэмт хэрэгт холбогдон шалгагдсан аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж тухайн байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудад тусгайлан сургалт зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтын хүрээнд Даланзадгад суманд барилгын үйл ажиллагаа эрхэлж байгаа 6 аж ахуй нэгж, тоосгоны үйлдвэр 1, цемент барилгын материалын үйлдвэр 1, оёдлын үйлдвэр 3, Цогтцэций суманд нүүрс олборлолт, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа “Эрдэнэс таван толгой”, “Таван толгой” ХК, “Энержи ресурс”, “ТТJVCO”, “Моннис”, “Хишиг-Арвин индиструал”, “Овоот толгой” ХХК-ууд, барилгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа “Шанх майнинг”, “Хос бор морь”, “Грейн ресурс” зэрэг 10 компани, Гурвантэс сумын нутагт нүүрс олборлох чиглэлээр “Саус гоби сэндс” ХХК, “Монголын Алт-МАК” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Чинхуа-Мак Нарийн сухайт” ХХК, тэсрэх материал үйлдвэрлэх, худалдаалах чиглэлээр “Бласт” ХХК зэрэг аж ахуй нэгжүүд, мөн нүүрс тээврийн замыг хариуцан ажилладаг “NTB” ХХК, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Чухам жаргалан” ХХК, “Хөгшөө” ОНӨААТҮГ, “Шугшаа” ОНӨААТҮГ, 16 айлын орон сууц барьж буй “Алтай бумбат” ХХК гэсэн аж ахуй нэгжүүдэд “Албан мэдэгдэл”-ийг хүргүүлж “Аюулгүй байдал-Амьдралын баталгаа” хэсэгчилсэн арга хэмжээнд нэгдүүлж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд Гурвантэс сумын Шивээхүрэн хилийн боомтод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын дарга эрхлэгч болон нүүрс тээвэрлэдэг жолооч нарт буюу нийт 222 иргэнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт яриа таниулгыг 1 удаа зохион байгуулж ажилласан.

Тус Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Цолмон, Говийн наран АА бүлгэмийн тэргүүн Т.Дашцэрэн нар Гурвантэс сумын төвд оршин суух хаягтай архины хамаарал бүхий 14 иргэнд архинаас хэрхэн ангижрах арга замын талаар ганцаарчилсан болон бүлгийн яриа таниулга хийж, тус суманд АА бүлгэмийг шинээр байгуулахаар 1 иргэнийг Дундговь аймагт зохион байгуулагдсан “Архичид аминчлахуй” чуулга уулзалтад хамруулан ажилласан. Өмнөговь аймгийн Политехник коллежийн 2, 3 дугаар курсийн 250 оюутанд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан

сэргийлэх тухай хууль, зөрчлийн тухай хууль, хөдөлмөр хамгааллын чиглэлээр, ерөнхий боловсролын 3 дугаар бүрэн дунд сургуулийн 6 дугаар ангийн 23 сурагчдад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 40 минутын яриа хийж ажилласан. Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг аймгийн Дулааны цахилгаан станц ХХК-ны ажилчдад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 удаа сургалт зохион байгуулж ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт оршин суух бүртгэлтэй нийт 111 хүнд захиргааны хяналт тавин ажиллаж байна. Иргэдийн эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, шинэчлэн батлагдсан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг таниулах ажлын хүрээнд 130 иргэнд биечлэн сургалт, зөвлөгөө өгч ажилласан байна.

Телевизээр: Цагдаагийн газраас 2020 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 69 удаа, радиогоор 5 удаа, үүнээс орон нутгийн Алтанговь телевизтэй хамтран “Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 99 жилийн ойн өдрийг тохиолдуулан Гурвантэс сум дахь Цагдаагийн тасгийн зохицуулагч, цагдаагийн хошууч С.Бат-Очирын талаар “Эгэл цагдаа” нэвтрүүлэг, аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран өсвөр насны охидын жирэмслэлтийн талаар нэвтрүүлэг, хамтран хууль бус гар дээрээс согтууруулах ундаа зарж борлуулж байгаа иргэдийн талаар “Хуулиас гадуур гэрэлтэй цонх” нэвтрүүлэг тус бүр бэлтгэж олон нийтэд хүргэсэн. Аяны зорилго, явц үр дүнгийн талаар Говийн мэдээ сонинд аянтай холбоотой 2, Алтан нутгийн мэдээ сонинд 2, МонЦамэ агентлагт 2 мэдээлэл бэлтгэж өгөв. МҮОНТВ-д 2 удаа, Монгол НД, ТВ-9, Стар, Өлзий телевизүүдэд тус бүр 1 удаа архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн аяны талаар мэдээлэл хийв. Сумдын Засаг дарга нарын цугларалтаар Цагдаагийн газрын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдээлэл хийж, аянд нэгдүүлэн, 3 видео шторк хийж ажиллав.

Цахим хуудсаар: Цагдаагийн газрын /Facebook, page/ олон нийтийн сүлжээнд 2020 онд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл тавигдаж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 1143 мэдээ мэдээлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн мэдээ, мэдээлэл 978, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр буюу аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Үгүй”, “Хайрлая” аяны хүрээнд 53 уриалга, 18 шторк, 25 постор, лого 2, Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн шторк, уриалга, постор, 213 гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн заалт ангиллын талаар мэдээлэл 63 удаа мэдээлэл, хүрээнд зурагт хуудас зэргийг нийтэлж иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн ба орон нутгийн иргэдийн хандалт ихтэй цахим хуудас Өмнөговь аймгийн автомашины зарын нэгдсэн групп /22495 гишүүнтэй/, Өмнөговь шуурхай зар /65931 гишүүнтэй/, Цагаан хад жолооч нарын групп /68201 гишүүнтэй/, Таван толгой цагаан хад ганц мод хоорондох нүүрсний тээврийн жолооч нар /36872 гишүүнтэй/, Цагаан хад жолооч нарын групп /68200 гишүүнтэй/ зэрэг орон нутгийн иргэдийн хамгийн их бүртгэлтэй нийгмийн сүлжээнд давхардсан тоогоор 745.822 гишүүдтэй хуудсанд нийтэлж, түгээж ажилласан. Тус Цагдаагийн газраас Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Тус Цагдаагийн газрын дэргэдэх “Шонхор” студиэр дүрс бүхий шторк 1, 5 төрлийн постор, “Гайхамшигт говь” ТББ-ийн тэргүүн Х.Түмэндэлгэр урьж бидний дуу хоолой байгалийг хамгаалж чадна уриатайгаар “Хууль бус алт олборлолт” сэдэвт подкаст, “Өмнөговь цагдаагийн газар”-ын Facebook, page, web хаягт байршуулж “Өмнөговь зарын нэгдсэн групп”, “Сумдын цагдаагийн хэсгийн групп” зэрэг олон дагагчтай Фейсбүүк хаяг болон алба хаагчдын

хувийн хаягуудаар дамжуулан анхааруулга уриалга бүхий мэдээ мэдээлэл, Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн шторкуудыг олон удаагийн давтамжтайгаар шэйрлэж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан бөгөөд фейсбүүк хаягуудад байршуулж аялгуут шторкуудыг Өмнөговь аймгийн Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулдаг “Метро плас FM-89.1”-ээр цацаж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан болохыг илтгэн танилцуулъя.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журам зөрчин үйлдэгдэж буй хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны талаар хууль дүрмийг сурталчлан таниулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд зорилгоор орон нутгийн иргэдийн хандалт ихтэй цахим сүлжээнд Хэрэг бүртгэх алба, Цагдаагийн Ерөнхий Газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн урьдчилан сэргийлэх видео шторк, зурагт хуудсыг тухай бүрт нь иргэдэд тогтмол түгээж Өмнөговь аймгийн автомашины зарын нэгдсэн групп /22495 гишүүнтэй/, Өмнөговь шуурхай зар /65931 гишүүнтэй/, Цагаан хад жолооч нарын групп /68201 гишүүнтэй/, Таван толгой цагаан хад ганц мод хоорондох нүүрсний тээврийн жолооч нар /36872 гишүүнтэй/, Цагаан хад жолооч нарын групп /68200 гишүүнтэй/ зэрэг орон нутгийн иргэдийн хамгийн их бүртгэлтэй 35 нийгмийн сүлжээнд давхардсан тоогоор 549834 гишүүдтэй хуудсанд нийтэлж ажилласан болно. “Аюулгүй байдал-Амьдралын баталгаа” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд сум хариуцсан цагдаагийн хэлтэс, тасгийн алба хаагч нар албан байгууллагуудад хууль эрх зүйн сургалтыг зохион байгуулж иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажилласан.

“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний нээлтийг орон нутгийн “Мэлмий” телевиз сурталчилж, хүрэлцэн ирсэн 150 иргэнийг “Яараад яахав дээ” урианд нэгдүүлэн фото зураг авч, 7 минутын нэвтрүүлэг бэлтгэн Өмнөговь цагдаагийн газар, Орон нутгийн замын цагдаа, Өмнөговь шуурхай зарын групп, Цогтцэций нэгдсэн зарын групп зэрэг олон хүний дагагчтай Facebook цахим хуудсанд байршуулсан. Мөн төвийн бүсийн 7 аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажилчид тус аймагт ажлын айлчлал хийх үед “Яараад яахав дээ” аяныг сурталчлан 1 минут 36 секундийн шторк хийж Facebook цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн газрын хэмжээнд Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий нийт 200 ширхэг тараах материал, “Ятгах тусам нягтал” аяны лого бүхий тус аяныг сурталчилсан 0,7х1,3 м хэмжээтэй 40 ширхэг хулдаасан самбар, 40х80см, 3х6, 6х5 метрийн хэмжээтэй 3 ширхэг хулдаасан самбар, 2 ширхэг хүрээ, 25 ширхэг хөөсөн самбар, 3 ширхэг өргөмжлөл, 21 ширхэг медаль зэргийг хэвлүүлж, хүнсний бараа бүртгээгдэхүүн, автомашин болон бал, маск зэрэгт наах лого бүхий наалтыг 30 ширхгийг бэлтгэн нийт 1.650.000 төгрөгийн хөрөнгийг аймгийн болон сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс болон тус газраас гарган зарцуулж хүн, хүч нөөц боломждоо тулгуурлан арга хэмжээг амжилттай зохион байгуулан ажилласан

Тараасан сурталчилгааны материал: Цагдаагийн газрын хэмжээнд Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий нийт 5600 ширхэг тараах материал, “Ятгах тусам нягтал” аяны лого бүхий тус аяныг сурталчилсан 0,7х1,3 м хэмжээтэй 25 ширхэг хулдаасан самбар, 4х5, 3х6, 3х5, 3х3 метрийн хэмжээтэй 4 ширхэг хулдаасан самбар, 70

ширхэг дарцаг, 10 ширхэг хүрээ, 45 ширхэг хөөсөн самбар хэвлүүлж, хүнсний бараа бүтээгдэхүүн, автомашин болон бал, маск зэрэгт наах лого бүхий наалтыг 2500 ширхгийг бэлтгэн нийт 3625000 төгрөгийн төсвийг зарцуулж ажилласан байна.

Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх “Үгүй” аяны хүрээнд аяны уриа үг, 8 төрлийн фрэйм, ковер, баннер 20 ширхэг, хулдаас 20 ширхэг, лого 40 ширхэг, 4 төрлийн зурган постерыг 2500 ширхэг, стикер 10000 ширхгийг хэвлүүлэн, аймгийн хэмжээнд тараан байршууллаа. “Үгүй” аянтай сурталчлах зорилгоор 3х6 хэмжээтэй 4 анонсыг аймгийн төвд байршуулав. “Сар шинэ-2020” 10 төрлийн санамж, сэрэмжлүүлэг 200 ширхэг, хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 250 ширхэг, Мал хулгай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 300 ширхэг, хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 5 төрлийн 25 ширхэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс болон тус газраас гарган зарцуулж хүн, хүч нөөц боломждоо тулгуурлан арга хэмжээг амжилттай зохион байгуулан ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсээс ирүүлсэн 500 ширхэг тараах материалыг гудамж талбай, олон нийтийн газар, орон сууцны хаалга, Даланзадгад сумын 112 аж ахуй нэгжийн үүдэн, халуун ус зэрэг газруудаар байршуулж иргэд олон нийтэд хүргэсэн.

“Байгалиа хамгаалъя”, арга хэмжээний хүрээнд “Ноён дизайн” хэвлэлийн газраар 10 төрлийн посторын эх бэлдүүлж 3000 ширхгийг хэвлүүлж тараасан.

“Яараад яах дээ” “Бид нэг амьтай шүү” аяны хүрээнд 5000 ширхэг, санамж, сэрэмжлүүлэг хэвлүүлэн тараасан. Хамтрагч байгууллагуудыг оролцуулан орон нутгийн “Алтанговь”, “Говь НД”, “Говийн наран” олон улсын Глобал сэтгүүлийн сэтгүүлчдийг хамруулан хэвлэлийн бага хурал зохион байгуулан телевиз, олон нийтийн сүлжээгээр аяны үйл ажиллагааг сурталчлан ажиллав.

Аймгийн төвд 3х6 хэмжээтэй аяныг сурталчилсан анонс 4-ийг, зам дагуух сурталчилгааны самбар 20 ширхгийг байршуулан, 3 төрлийн зурган постер 2500 ширхэг, аяны логог 5000 ширхэг хэвлүүлэн сумдад хуваарилан аймгийн хэмжээнд тарааж ажилласан. Архи ба амьдрал сэдэвт сургалтыг 0131-р ангийн 48 алба хаагчид болон аймгийн Төв номын сангийн 10 ажилтанд зохион байгуулж, аянд нэгдүүлэх ажлуудыг зохион байгууллаа.

Нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгүүд сум орон нутагтаа аяны талаарх сурталчилгааг хариуцан зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэдийг нэгдүүлэн, 14 хоног тутамд мэдээллээ ирүүлэн нэгтгэж ажиллаж байна. Тус тасаг нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2019-2023) хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн хариуцсан нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд жолооч нарын анхаарал болгоомжийг нэмэгдүүлэх зорилгоор Даланзадгад Мандалговь чиглэлийн улсын чанартай автозам болон аймгийн төвд “Яараад яахав дээ” нөлөөллийн самбар 9 ширхэгийг байрлуулахад шаардагдах 1.562.000 төгрөгийг аймгийн Засаг даргын тамгын газраар шийдвэрлүүлж, самбаруудыг байрлуулсан. Мөн тус аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэрт хамаарах хашаа байшинд амьдардаг 920 айл өрхөөр орж сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудсыг 920 ширхэгийг тараасан. Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хамаарах хашаа байшинд амьдардаг 810 айл өрхөөр орж сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудсыг 810 ширхэгийг,

Гурвантэс сумын нутаг дэвсгэрт хамаарах хашаа байшинд амьдардаг 315 айл өрхөөр орж сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудсыг 315 ширхэгийг, Ханбогд сумын нутаг дэвсгэрт хамаарах хашаа байшинд амьдардаг 300 айл өрхөөр орж сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудсыг 300 ширхэгийг тус тус тарааж аймгийн хэмжээнд 5000 ширхэг санамж сэрэмжлүүлэг хэвлүүлснээс 2345 иргэн, айл өрхөд тараасан.

Аймгийн хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож буй 2655 тээврийн хэрэгслийн жолоочид “Тээврийн хэрэгслээ хэрхэн байрлуулж, аюулгүй хөдөлгөөн эхлэхдээ анхаарах” чиглэлээр бэлтгэсэн 2655 ширхэг санамж материалыг тарааж ажилласан.

Цагдаагийн байгууллага, аймгийн Онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, хяналтын цэгүүдийн байршлын мэдээллийг орон нийтийн Говийн наран Говь HD телевизүүдэд 6 удаа өгч, Өмнөговь Цагдаагийн газар Facebook хаяг болон пэйж хуудсаар сурталчлан, иргэдэд хүргэх ажлыг зохион явуулахын зэрэгцээ Өмнөговь аймгийн зарын 10 групп, томоохон сумд болох Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдын болон Таван толгой цагаан хадны жолооч нарын, Өмнөговь аймгийн Автомашины нэгдсэн зар харьяа Цагдаагийн хэлтэс, тасаг хэсгүүдийн 400.000 гаруй дагагчтай 24 групп хуудсанд байршуулан иргэд олон нийтэд сурталчилсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний сахилга, соёлыг дээшлүүлэхэд анхаарч, гарч буй хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор аж ахуй нэгж байгууллагад 6 мэдэгдэл, шаардлага хүргүүлэн биелэлт, үр дүнг тооцон, хариуг авч ажилласан.

Гурав. Дүгнэлт

Тус аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заагдсан ерөнхий ажил, арга хэмжээ ажлын явц, үр дүн хэвийн явагдаж байгаа бөгөөд хэрэгжилт хангагдаагүй ажил, арга хэмжээ байхгүй байна.

Дөрөв. Санал

1. 2021 онд тохиох Ардын хувьсгалын болон Цагдаагийн байгууллага үүссэний 100 жилийн ойтой холбогдуулан улсын болон орон нутгийн төсөвт тусгуулсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах.

2. 2021 онд сахилга, ёс зүйн зөрчилгүй, шилдэг хамт олон болох гэсэн хоёр цогц ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР